

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-93

-
- 1. Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох** 13-43
 - 2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./** 44-66
 - 3. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/** 66-71
 - 4. Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох** 71-93

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
12 дугаар сарын 10-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, М.Мандхай, Н.Наранбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Л.Мөнхбаясгалан, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хэлэлцэх асуудлын 3 дугаарт байгаа Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт хэлэлцэх горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаарх мэдээллийг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт хэлэлцэхээр тогтов.

Нэг. Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Довчинсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний газрын дарга Б.Эрдэнэчимэг, мөн газрын мэргэжилтэн Н.Бумцэнд, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Х.Эрдэнэбилэг, мөн газрын хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Р.Ундармаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны

ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Довчинсүрэн мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, У.Отгонбаяр, Ц.Идэрбат, С.Замира, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, А.Ундраа, М.Ганхүлэг, Т.Аубакир нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Довчинсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний газрын дарга Б.Эрдэнэчимэг, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Р.Ундармаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 12 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Довчинсүрэн, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Нямхүү, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч Я.Самбууням нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Ц.Идэрбат, П.Батчимэг, Б.Уянга, Ц.Мөнхбат, С.Замира, З.Мэндсайхан нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч Я.Самбууням, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Бейсен: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралт “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн 22.6.1.1 дэх дэд заалтыг “Монгол Улсын бүх хот суурин буюу хүн ам төвлөрсөн газруудад озон, PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл зэрэг агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодис тус бүрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг хэмжих” гэж, суурь оныг “2023” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 11
Бүгд: 17
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралт “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлт”-ийн “22.6.1.2. дахь дэд заалтыг “Улаанбаатар хот болон 21 аймгийн төвүүдэд агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 11
Бүгд: 17
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн шалгуур үзүүлэлтэд “22.6.2.4-т “Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлэх” гэж, хэмжих нэгжийн “Тоо” гэж, Суурь оныг “2023” гэж, Суурь түвшнийг “0” гэж, Зорилтот түвшнийг “1” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дээрх санал хураалтыг дахин явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дээрх санал хураалтыг дахин явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Бейсен: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн шалгуур үзүүлэлтэд “30.8.1.2.Санхүүжилт авсан хоршоодын орлогын өсөлтийн хувь” гэж, хэмжих нэгжийг “Хувь” гэж, Суурь оныг “-” гэж, Суурь түвшнийг “-” гэж, Зорилтот түвшнийг “10” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 14
Бүгд: 17
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан, “Дархан арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламж, /Дархан-Уул, Хонгор сум/” гэснийг “Төвийн

бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Дархан-Уул, Хонгор сум/” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Болормаа, М.Сарнай, А.Ундраа, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэбат, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Үндэсний Аудитын газрын дүгнэлтээр зураг төсөвгүй, төслийн шаардлага хангаагүй 4 арга хэмжээ нийт 99,2 тэрбум төгрөг тавигдсанаас 31,4 тэрбум төгрөгийг хасч, “Цэцэрлэг, сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны материал худалдан авах” зардлыг 31.4 тэрбумаар бууруулсныг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 15
Бүгд: 17
11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Соноор, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө

оруулалтын газрын дарга З.Тулга, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Довчинсүрэн, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Нямхүү, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Нэг.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын тавьсан асуултад Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат хариулж, тайлбар хийв.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.9 дэх заалт нэмэх:

“15.1.9.байгууллагын төсвөөр түүхэн үйл явдлын ой, салбарын зарим ажил, мэргэжлийн ажилтны тэмдэглэлт өдөр, бусад тэмдэглэх өдрийг тэмдэглэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 11
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дээрх санал хураалтыг дахин явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, мөн газрын Зээл, төслийн хэлтсийн дарга Н.Энхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаар Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Ц.Идэрбат, Л.Мөнхбаясгалан, С.Замира, М.Ганхүлэг, Р.Сэддорж, П.Мөнхтулга, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 цаг 40 минут үргэлжилж, 21 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 76.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 10-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 10 цаг 10 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 59,1 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар 2 дугаар тойрог ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн байна. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Телеуханы Аубакир гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн чөлөөтэй. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр ирсэн байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Ирц Аубакир гишүүн нэмэгдэж, 63,6 хувьтай болсон байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээр асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай /Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг/ санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлэх ёстой.

2 дахь асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд, мөн 12 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлэх ёстой.

3 дахь асуудал. Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох.

4 дүгээрт. Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох.

5 дугаарт. “Тавантолгой түлш” компанийн үйлдвэрлэл технологийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний нөөц, чанарын талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатарын захирагчийн мэдээллийг сонсох ёстой.

Ийм 5 асуудлыг хэлэлцэх ёстой. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу. Батчимэг гишүүн санал гаргалаа. Үг хэлье гэж байна.

П.Батчимэг: Та бүхний энэ өдрийн мэндийг айлтгая. Та бүхэндээ 1990 оны ардчилсан хувьсгалын ойн өдрийн мэнд. Олон Улсын хүний эрхийн өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.1.3-д заасныг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулж 1 горимын санал байгаа юм.

2024 оны 12 сарын 4-ний өдөр Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт нийт 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг өнөөдөр өргөн мэдүүлээд байгаа юм. Гэвч өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байхгүй байгаа юм. Яагаад энэ хуулийн төсөл орж ирэхгүй байгааг бүгдээрээ мэдэж байгаа байх. Мэдээж эрхлэх ажлын хүрээнд Төсвийн байнгын хороонд бол энэ хуулийн төсөл харьяалагдаж байгаа. Гэхдээ энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр ААНОАТ-ын тухай хуулийн 22.5.22 албан татвар төлөгчийн 2025 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлэх Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үндсэн үйл ажиллагааны орлогод 5 жилийн хугацаанд 90 хувиар албан татварын хөнгөлөлт үзүүлнэ гэсэн ийм маш чухал ач холбогдолтой заалтыг нэмсэн байгаа.

Манай Байнгын хороо бол Хүнс, хөдөө аж ахуй чиглэлээр эрхлэх ажлын хүрээнд маш том Байнгын хороо шүү дээ. Тэгээд энд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд “...хангайн бүсийг уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн бүс, төвийн бүсийг хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс, баруун болон хойд бүсийг байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн болон аж үйлдвэрийн дэд бүс болгон хөгжүүлнэ.” гээд ингээд заачихсан. Ийм асуудлууд манай Байнгын хорооны яг эрхлэх ажлын хүрээнд хамаарагдаад байхад энэ хуулийн төслийг хэлэлцэхгүй өнгөрч болно гэж бодож байна уу манай гишүүд ээ.

Тэгэхээр надад энийг ингээд дагасан хэд хэдэн юм тодруулах асуултууд байгаа юм. 2025 оны төсвийн хуулийн 2 дугаар хавсралтад Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн .../минут дуусав/

Б.Бейсен: Батчимэг гишүүн 1 минут.

П.Батчимэг: 2025 оны төсвийн хуулийн 2 дугаар хавсралтад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдэлд туссан Хөвсгөл аймгийн сумуудад хэрэгжүүлэх бяслагийн үйлдвэрийн төсөл дээрх бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал туссан уу. Энэ төсөл импортыг орлох, экспортыг дэмжих төсөлд хамаарах юм уу. 100 хувь улсын төсвөөс шууд санхүүжиж байгаа ийм төслүүд дээрх татварын хөнгөлөлтөд хамрагдах уу гээд ийм асуудлууд хөвөрч байгаа.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан уламжлалт мал аж ахуй, хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлэх импортыг орлох, экспортыг дэмжих хэчнээн төслүүд өнөөдөр байгаа юм бэ. Эд нар нь бүгдээрээ татварын хөнгөлөлтөд хамрагдаж байгаа ийм тооцоо, судалгаа байгаа юу. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих гэснийг хэн тодорхойлох юм. Засгийн газар юм уу .../минут дуусав/

Б.Бейсен: Энийг Төсвийн байнгын хороо дээр бас хэлэлцсэн байна. Гэхдээ энэ та бүгд бас Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн нэг юм танилцуулъя гэж бодож байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой. Энэ сүүлийн 3 асуудал байна шүү дээ. Энэ мал махны бэлтгэл нийлүүлэлт, тэгээд ЖДҮ, Тавантолгой түлш, тэгээд нөгөө зудын асуудал байж байгаа. Тэгэхээр энэ 3 асуудлыг өнөөдөр төсөв хэлэлцэж байгаа 2 асуудал нэлээн сунжрах байх. Зарчмын зөрүүтэй саналууд ч байх шиг байна. Тэгээд энийг хойшлуулж байгаад, энэ 7 хоногт багтаагаад хэлэлцвэл яасан бэ гэсэн санал байна.

Нөгөө талаар Байнгын хорооноосоо давсан ажлын хэсэг гээд гарчхаад Байнгын хорооны гишүүдээ ч тоохгүй. Гадаад, дотоод явахдаа тэд нар л тэргүүлж явдаг ийм асуудал гараад байна. Тэгэхээр энэ асуудал дээр бид нар нухацтай хандаж байгаад, Байнгын хорооны хурал дээр яг энэ зарим юунууд дээр ажлын хэсэг гаргаад, Байнгын хорооны эрх мэдлийн хүрээнд Байнгын хорооны гишүүдийн саналыг сонсож байгаад асуудал шийдэхгүй бол бас зарим асуудлууд байж байна.

Тэгэхээр өнөөдөр энэ 2, 3 асуудал байж байна. Агаарын бохирдлын асуудлыг та бүгд бас мэдэж байгаа. Энэ түлшний асуудалтай холбоотой. Тэрийг бас бид нар оруулсан. Манай Байнгын хороонд бас иргэдээс хүсэлт ирсэн. Энийг хэлэлцээд өг гээд. Гэтэл энэ түлшний асуудлыг Байгаль орчны яамнаас агаарын бохирдлын асуудлыг гаргаад аваад явчихсан. Тийм ээ. Тэгэхээр энэ асуудал дээр бас Байгаль орчны яам бас зүгээр байж болохгүй. Тэгээд ч энэ асуудлыг дараа нь хэлэлцвэл энэ 7 хоногт багтаагаад Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж байгаад, цаг гаргаад бид нар тусдаа яривал яасан бэ гээд санал байна 1 дүгээрт.

2 дугаарт сая нөгөө төсөл хөтөлбөрүүдийн тал дээр даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар тэгээд баталчихсан байна лээ. Хоршооны асуудлаар Энэтхэг явж байхад. Тэгэхээр энэ дээр ямар саналтай байна гишүүд ээ. Энийг нь хойшлуулчихвал яасан юм.

П.Батчимэг: Үгүй ээ, сая гаргаж байгаа миний горимын санал бол ер нь Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо чинь цаашдаа нэг ийм дагалдах хуулийн төслүүдийг хэлэлцэхдээ жишээ нь өнөөдөр ингээд Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд хэлэлцээд ороод ирж байна. Гэтэл бид нар цаг үетэйгээ холбоотой, манай Байнгын хорооны эрхлэх ажлын хүрээнд өчнөөн төчнөөн том асуудлууд байна. Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин энэ асуудлуудыг дагасан хуулийн төслүүдээ хэлэлцэхгүй юм бол бид нар өнөөдөр энд ингээд Байнгын хороо гээд гишүүд суугаад яах юм бэ. Ер нь миний хэлэх гээд байгаа юм юу вэ гэхээр ААНОАТ-ын хуулийн төслийг манайх хэлэлцээд явчхаж болно шүү дээ. Санал, дүгнэлтээ гаргаад Төсвийн байнгын хороонд оруулаад явчхаж болно. Энэ ААНОАТ-ын тухай энэ хуулийн төсөл чинь хамгийн чухал. Хамгийн манай Байнгын хорооны хамаарах.../минут дуусав/

Б.Бейсен: Таны саналыг сонсож байна. Мэдэж байна л даа. Энийг бид нар саналаа хүргүүлсэн. Гэтэл эрхлэх асуудлын хүрээнд Төсвийн байнгын хороо ярьж гэсэн хариулт өгсөн байхгүй юу. Тэгэхээр Байнгын хорооноос бид нар саналаа хүргүүлээд бас цаашдаа ийм асуудлууд дээр ер нь манай эрхлэх асуудлыг Байнгын хороогоор ярьж байя гэдэг асуудлыг хүргүүлье.

Та бүгдийн саналыг сонсоод би даргын дэргэдэх зөвлөлийн хурал дээр танилцуулъя. Та бүгд бас саналаа хэл. Би та бүгдийн саналыг даргын дэргэдэх

зөвлөл хуралд танилцуулъя. Мөнхбаясгалан гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн 2 санал гэж байна. Мөнхбаясгалан гишүүнд микрофон өгье.

Л.Мөнхбаясгалан: Өнөөдөр 12 дугаар сарын 10-ны өдөр. Монголд Ардчилсан холбоо үүсгэн байгуулагдсаны 35 жилийн ойн баярын мэндийг энд байгаа нийт гишүүддээ хүргэе.

Байнгын хорооны даргын гаргасан саналыг дэмжиж байна. Гадаа талбай дээр ард иргэд амьсгалах агаарынхаа төлөө жагсаал цуглаан хийж, үзэл бодлоо илэрхийлж байгаа. Улаанбаатар хотод байгаа хорт утааны хэмжээ бүр онц байдал зарлахуйц хэмжээнд хүрсэн гэдгийг та бид бүгдээрээ мэдэж байгаа. Орой болохоор үзэгдэх орчин хязгаарлагдаж байна. Эмнэлгүүд ачааллаа дагахгүй байна. Уушгины өвчин, ханиад маш ихээр нэмэгдэж байгаа. Тийм учир ерөөсөө энэ асуудлыг манай Байнгын хороо хэлэлцэх нь зөв. Гэхдээ хуралдаан сунжрах учраас үдээс хойш дахин хуралдаан зарлавал яасан юм дарга аа. Энэ 7 хоногт гэхээр бид нар чинь энэ 7 хоногт төсөв гүйцээж батлах ёстой шүү дээ. Чуулганы хуралдаантай. Тэгэхээр бид нар цаг зав олдохгүй байх. Тийм учраас үдээс хойшоо дахин Байнгын хороог зарлаж, Тавантолгой түлш компани буюу компанийн асуудал Нийслэлийн Засаг дарга Нямбаатар нарыг байлцуулан, Байгаль орчны яамыг байлцуулан үдээс хойшоо хуралдаан зарлаж өгөөч ээ гэсэн санал оруулж байна.

Б.Бейсен: Тэгэхээр чинь энэ Нямбаатар дарга байхгүй байгаа юм байна. Гадаад томилолттой байгаа юм байна. Утааны асуудал эрчим хүчтэй холбоотой Доржханд бас гадаад томилолттой гэсэн. Тэгээд чуулганы завсар ер нь зай гарах юм уу бид нарт. Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Батчимэг гишүүний яриад байгаа тэр ААНОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулахад холбоотой асуудал яагаад манай Байнгын хороо дээр орж ирэхгүй байгаа юм бэ гээд. Уг нь бол энэ чинь нөгөө Төсвийн хууль өргөн барьчихсан. Дагах хуулиуд нь давхар явж байгаа. Бид нар энийгээ яриад явчихад нэг их асуудалтай юм байхгүй болов уу гэж хараад байгаа шүү дээ. Өөрсдөө саналаа илэрхийлээд л явчих нэг процесс байх.

Утаатай холбоотой асуудал дээр зүгээр манайх өнгөрсөн хугацаанд яагаад утаа арилаагүй вэ гэдэг дээр нэг зүйл хэлмээр байгаа юм. Ялангуяа энэ утаатай холбоотой асуудал дээр. Хэрвээ би тэр мэдээлэл сонсох гэж байгаа бол ганцхан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам биш ээ. Энэ утааны асуудлыг Байгаль орчны яаманд даатгаж ирсэн учраас өнөөдөр хүртэл утаа арилаагүй байхгүй юу. Яагаад гэхээр утаа гэдэг чинь өөрөө дулаан үйлдвэрлэл, эрчим хүчтэй холбоотой асуудал. Байгаль орчны яам түлшний үйлдвэрийг хариуцдаггүй. Инженер байдаггүй. Байгаль орчны яаманд. Бүгд Эрчим хүчний яам дээр байдаг.

2 дугаарт Засгийн газрын бүх яамнуудад агаар орчны бохирдлоос холбоо бүхий асуудал дээр хариуцуулчихсан байдаг. ДЭМБ-аас дэгдэмхийг 5 хувиас дээш байлгаж болохгүй гэж 2 жил билүү, 3 жилийн өмнө ЭМЯ-нд зөвлөмж ирсэн шүү дээ. Тэгээд энийг өнөөдөр хүртэл ярихгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр холбогдох бүх яамнуудын нь өөрсдийг нь байлгаж байгаад үнэхээр энэ утааны асуудлыг ярих гэж байгаа бол ярих хэрэгтэй. Тодорхой хэмжээнд тэр хяналтын сонголт хийхээс авхуулаад сая Ганжавхлан нарын иргэд бас гадаа гудамжинд санал аваад, 70 мянга хүрчихсэн юм байна лээ. Тэгээд тэр тодорхой хэмжээний хяналтын

сонсголүүд нь явах болов уу гэж бодож байгаа. Тэр үедээ хэдүүлээ юмаа яриад явах нь зөв байх гэж ойлгож байна.

Нөгөө талдаа бид нар өнөөдөр одоо энд ярих юмнуудаа хурдан ярьж эхлэхгүй бол цаг алдаад байна л даа дарга аа. Тэгэхээр утаа дээр бол бүх салбар яамнууд, холбоо бүхий яамнуудыг бүгдийг нь байлгаж байгаад бид нар асуудлуудаа тусдаа ярьсан нь зөв болов уу гэсэн ийм саналтай байгаа.

Б.Бейсен: Батчимэг гишүүний асуудал дээр нөгөө даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар баталчихсан учраас та төсөв хэлэлцэх үед тэр үед нь санал гаргаад яриарай. Одоо болохгүй юм байна. Тийм дэг байхгүй юм байна. Тэгэхээр энэ хэлэлцэх асуудлын тавууланг ярихаар боллоо. Хуралдааны нээлттэй байгаад үдээс хойш энэ сүүлийн 3 асуудлыг энэ утааны асуудлыг ярихгүй бол иргэдээс бас санал ирж байна. Сая хэн Бат-Эрдэнэ сайд ярьж байна. 70 мянга хүрчихсэн байсан гэсэн үү. Тэгэхээр манай Байнгын хороо бас яриад, саналаа хүргүүлье. Тэгэхээр үдээс хойш нь бусад 3 асуудлыг ярья. Сангийн сайдыг дуудаарай.

Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн. Сангийн сайд Боловсролын байнгын хороо дээр хурал давхацсан байна. Бат-Эрдэнэ гишүүн горимын санал гаргая гэж байна.

Б.Бат-Эрдэнэ: Сангийн сайд маань Боловсрол, шинжлэх ухааны байнгын хороо дээр мэдээлэл хийж байгаа учраас хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулаад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээллийг сонсоод явж байх саналтай байна.

Б.Бейсен: Сангийн сайд Байнгын хороонд мэдээлэл хийж, хариулт өгч байгаа юм байна. Тийм учраас Бат-Эрдэнэ гишүүний горимын саналаар санал хураая. Батжаргал гишүүн, Мөнхбаясгалан гишүүн, Батчимэг гишүүн 3-ыг дэмжсэнээр аваарай. Санал дэмжигдсэн учраас Хүнс, хөдөө аж ахуйн сайдын мэдээллийг сонсьё.

Эхлээд **Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсьё.**

Ажлын хэсгийг оруулъя. Мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр танилцуулна. 6 номерын микрофон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилт зохицуулах газрын дарга Довчинсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Тулга, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Болдбаатар, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Батзориг, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний газрын дарга Эрдэнэчимэг, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Эрдэнэбилэг, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрийн хэлтсийн дарга Ундармаа, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний газрын мэргэжилтэн Бумцэнд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг.

Мэдээллийг Энхбаяр сая танилцуулъя. 6 номер.

Ж.Энхбаяр: Манай хүнсний үйлдвэрийн бодлогын газрын дарга Довчинсүрэн презентаци бэлдсэн танилцуулга байгаа. Тэгээд нэмэлт асуултыг би хариулаад явъя гэж. Манай газрын дарга нар бүгд мэдээллээ өөрсдөө хийе гэж байгаа юм.

Г.Довчинсүрэн: Сайн байцгаана уу. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Мал, махны бэлтгэн нийлүүлэлтийн нөөц, экспортын талаар та бүхэндээ танилцуулгыг хүргүүлье.

1 дүгээрт. Мал сүргийн бүтэц, малын тэжээл, мал, мах, махны бэлтгэн нийлүүлэлтийн нөөц, нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэж буй махны нөөц, экспортлогч оронтой байгуулсан гэрээ хэлэлцээр, мах, махан бүтээгдэхүүний экспортын гүйцэтгэлийн талаар та бүхэндээ танилцуулъя.

Мал сүргийн бүтэц.

Монгол Улсын мал сүргийн тоо бол 2025-2023 оны онд бол дунджаар 2,6 хувиар өссөн бөгөөд 2024 онд 15,4 сая төл хүлээн авч бойжуулсан. 2024 оны хагас жилд бол 66,8 сая толгой мал тоолуулсан. Харин мал сүргийн бүтцээр шилжиж ингээд харах юм бол нийт малын 46,4 хувь нь бол үржлийн насны эм мал, 25 хувь нь эр болон сувай мал, 4,6 хувь нь бол үржлийн эцэг мал, 23,3 хувь нь бол сүрэг сэлбэх өсвөр насны мал байна.

Эндээс түрүүний тэр тоотой харьцуулаад үзэхэд ямаа 25,9 сая толгой буюу 39 хувийг нь бол эзэлж байна. Тэмээ 0,5 сая толгой буюу 1 хувийг эзэлж байна. Адуу 4,8 сая толгой буюу 7 хувийг нь эзэлж байна. Үхэр 5,3 сая толгой буюу 8 хувийг, хонь 30,3 сая буюу 45 хувийг нь бол эзэлж байгаа.

Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэж буй нөөцийн махны талаар нийслэлээс ирсэн мэдээллийг та бүхэндээ танилцуулъя.

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасны дагуу нутаг дэвсгэрийнхээ хүн амын стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатын Засаг дарга авч хэрэгжүүлэхээр заасан төдийгүй Засгийн газрын 2023 оны журам батлах тухай 344 дүгээр тогтоолоор стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг баталж, стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлэж байхыг бол аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан.

Иймд нийслэлийн хүн амын 2024-2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан нийт 5100 тонн махыг 6 аж ахуйн нэгж бэлтгэн нийлүүлэхээр шалгарсан бөгөөд нийт бэлтгэх махны 60 хувийг нь бол хонины мах байхаар, 40 хувийг нь бол үхрийн мах байхаар тооцож, үхрийн махны бэлтгэлийн үнийг ер нь 9400 төгрөгөөр, хонины махны бэлтгэлийн үнийг 8800 төгрөгөөр бэлтгэхээр бол ийм тохиролцсон байгаа.

Нөөцийн мах бэлтгэлийн санхүүжилтийг бол арилжааны банкны эх үүсвэрээр нийт 18 хувийн хүүтэй олгох ба үүнээс бол 11 хувийн хүүгийн хөнгөлөлтийг бол

нийслэлийн төсөвт тусгаж, 7 хувийг нь аж ахуйн нэгж төлөхөөр бол шийдвэрлэсэн ба өнөөдрийн байдлаар бол 3 аж ахуйн нэгж нийтдээ 2330 тонн махыг бол бэлтгэсэн. Бэлтгэл ажлыг бол ханган ажиллаж байна.

Мөн нийслэлийн хүн амын хангамжийг нийлүүлэлтийг бол нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 12 сарын 12-оос 21-ний хооронд ийм үйл ажиллагаа явагдана. Хоршоологчдод хотынхондоо гээд өвлийн идэш өргөтгөсөн худалдаа бол зохион байгуулагдана. Энийг бол 7 дүүрэгт зохион байгуулах гээд байршил нь тодорхой бол гарчихсан байгаа. Энэ дээр зөвхөн мах худалдаалахгүй цагаан идээ, жимс жимсгэнэ мөн малчдын өөрсдийн болон орон нутгийнхны бэлдсэн зөгийн бал болон бусад бүтээгдэхүүнээр оролцохоор 7 дүүрэгт бол бэлдчихсэн байгаа.

Монгол Улс 1997 онд бол Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэж, Дэлхийн худалдааны байгууллагын эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх хэлэлцээр буюу эс би эс хэлэлцээрийг хэрэгжилтийг хангах тарифын бус хориг саадыг багасгах зорилгоор гадаад орнуудтай хүнс, мал, амьтан, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага, экспортлох, импортлох үеийн нөхцөлийг тохиролцсон худалдааны чөлөөт байдлыг ханган ажиллаж байгаа. Тухайлбал, мал амьтны хорио цээрийн чиглэлээр 26 улс оронтой бол хамтран ажиллаж байна. Засгийн газрын 17 хэлэлцээр, хорио цээр, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлагын тухай 15 протокол, мөн харилцан ойлголцлын 6 санамж бичиг, мал эмнэлгийн гэрчилгээ 60-ыг тохирсон гэх жишээний, мал эмнэлэг хорио цээрийн нөхцөл 5-ыг гэх жишээний ийм юунуудыг тохиролцож ажиллаж байна.

Мах, махан бүтээгдэхүүний экспортлох эрхтэй аж ахуйн нэгжүүдэд Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хоорондох хэлэлцээрийн дагуу бол Монгол Улс, БНХАУ, ОХУ, Узбекистан улсад мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох аж ахуйн нэгж нь импортлогч улсаас эрсдэлийн үнэлгээ хийгдсэн. Тухайн улсын холбогдох мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага хангасан үйлдвэр байдаг ба уг үйлдвэрийг тухайн улсын эрх бүхий байгууллагын цахим системд бүртгэснээр Монгол Улсаас мах махан бүтээгдэхүүнийг экспортлох эрх үүсдэг.

БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар нь 2021 оны 248 дугаар тушаалаар баталсан импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын аж ахуйн нэгжийг бүртгэх захиргааны журмыг тус газрын 249 дүгээр тогтоолоор баталсан. БНХАУ-ын экспорт, импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хүрээнд бол 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тус улсад хүнсний 18 нэр төрлийн бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгжийн хүсэлтийг ХХААХҮЯ-аар дамжуулан цахимаар уламжилдаг болсон байгаа.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас БНХАУ-д адууны мах экспортлох 11, дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн экспортлох 21, дулааны аргаар боловсруулсан мах бэлтгэх буюу төхөөрөх 10, баруун 5 аймгаас түүхий мах экспортлох 6 аж ахуйн нэгжийг бол бүртгэсэн байдаг.

ОХУ-ын мал эмнэлэг, ургамлын эрүүл ахуйн хяналтын хороонд бол 29 үйлдвэр бас бүртгэгдсэн байдаг.

Узбекистан улсад бол 24 гэх мэтчилэн юу байдаг. Сүүлийн үед бол булангийн орон буюу Иран, Ирак руу мах, махан бүтээгдэхүүн нэлээн түлхүү экспорт бол

хийгдэж явж байна. Хуучин бараг 90 орчим хувь нь БНХАУ-д экспортлогддог байсан бол одоо булангийн орнуудад нийтдээ бараг 30 гаруй хувийг нь эзэлсэн байгаа.

Иран улсын мал эмнэлгийн байгууллагатай сэврээсэн вакуум савласан маханд тавигдах эрүүл мэндийн шаардлагыг тохиролцсон бөгөөд Монгол Улсаас Мал эмнэлгийн ерөнхий газар 2024 оны 10 сарын 23-ны өдөр 59 аж ахуйн нэгжийн жагсаалтыг тус байгууллагад хүргүүлсэн байгаа.

Булангийн орнуудад мах, махан бүтээгдэхүүн экспортлохтой холбогдуулаад мусалман шашинтай халал аргаар бэлтгэсэн мал, амьтны махыг бол хүнсэндээ хэрэглэдэг. Тус ХХААХҮЯ нь НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага буюу ЮНИТО-той хамтран экспортыг дэмжих төслийн хүрээнд бол тохирлын үнэлгээний байгууллагын чадавхыг сайжруулах чиглэлээр техникийн туслалцаа авч, булангийн орнуудад хамтын ажиллагааны зөвлөлийг дэргэдэх итгэмжлэлийн төвтэй 2023 оны 12 дугаар сард Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллагын 3 байгууллагад аудит хийгдэж халал хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулах итгэмжлэлийг 4 жилийн хугацаатайгаар авсан. Энэ хүрээндээ хэд хэдэн үйлдвэрүүдийн баталгаажилт хийгдсэн байгаа.

Мал, мах бэлтгэн нийлүүлэлт.

Нийтдээ бол 66,8 сая толгой мал байгаа. Түрүүн та бүхэндээ дурдсан. Малын тоо нийт орон нутгаас авсан судалгаагаараа малын тоог бол 16 сая толгой малыг хэрэгцээлж 50,8 сая толгой мал өвөлжих урьдчилсан дүн гарсан байгаа. 16 сая толгой мал буюу 543 мянган тонн махыг нийтийн хэрэгцээнд хэрэгцээлэхээр болсон. Үүндээ дотоодын хэрэгцээнд бол 10 сая толгой малыг хэрэгцээлнэ. Энэ бол 340 мянган тонн болж байгаа. Экспортын боломжит 6 сая толгой малыг экспортод гаргана гэсэн тийм боломжит тооцоо судалгаа байна. Энэ бол 200 мянган тонн экспортлох бол бүрэн боломжтой гэсэн тийм тооцоо судалгаанууд бол гарсан байгаа.

Махны экспортын хамтын ажиллагаатай улсууд бол мах, махан бүтээгдэхүүнийг экспортлохоор БНХАУ, Узбекистан, Иран, Ирак, Казахстан, ОХУ гээд байна. Мах, махан бүтээгдэхүүний экспорт эхэлж байгаа улсууд нь бол Кувейт, Азербайжан, Киргизстан, Вьетнам сая бол Вьетнамтай бас 2, 3 аж ахуйн нэгжүүд бол хоорондын санамж бичгүүд нэлээн тохирчихсон. Одоо БНХАУ-ын дамжин өнгөрүүлэх асуудлаа шийдвэрлэх юм бол Вьетнам улс руу экспорт нэлээн түлхүү гарах тийм таатай мэдээ бол гарч ирж байгаа. Сая бас 10 хоногийн өмнө бол Армен улсад 20 тонн мах экспортод гарч, шинэ гарц гарч ирсэн байгаа байгаад байгаа.

Мөн мал эмнэлгийн салбарт хамтын ажиллагаа эхлэхээр Герман, Латви, Франц, Чех, Швейцар, Норвег гээд эдгээр улсууд бол манайхаас бас мах, махан бүтээгдэхүүн авахаар нэлээн тийм судалгаа хийгдэж байгаа асуудлууд бол байгаа.

Мах, махан бүтээгдэхүүний экспортын гүйцэтгэл 2017 онд 32,2 мянган тонн экспортод гарч байсан бол 2018 онд 70,4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн бол экспортод гарсан. Үүнээс хойш 2019 онд 58,6 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортлоод, ковидын нөхцөл байдлаас болж хил, гааль хаагдсан, тээврийн бас хүндрэлтэй асуудлаас болоод нэлээн бас 40 хэдэн хувиар буурсан үзүүлэлт

үзүүлээд, мах, махан бүтээгдэхүүн дээр экспортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоодог байсныг нь ХХААХҮЯ-аас болиулаад, тэгээд ямар ч байсан импортлогч орны шаардлагыг хангасан эрхтэй аж ахуйн нэгжүүд бол чөлөөтэй экспортлох боломж нь бол үүссэн. Энэ хүрээндээ бол 2023 онд 80,4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн буюу түүхий маханд шилжүүлэх юм бол 120 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортод гарсан. Үүний хүрээнд бол 360 гаруй сая долларын арилжаа бол хийгдсэн.

Одоо 2024 оны 12 сарын 5-ны байдлаар 63,8 тонн мах, махан бүтээгдэхүүн экспортод гарчихсан байна. Энэ нь бол хонь, ямааны түүхий мах 21,8 мянган тонн, адууны мах 21,9 мянган тонн, үхрийн мах 0,2 мянган тонн, дулааны аргаар боловсруулсан мах 18,4 мянган тонн, дайвар бүтээгдэхүүн 1,3 мянган тонныг экспортод бол гаргасан байгаа.

Мах, махан бүтээгдэхүүний экспортыг улсаар нь харах юм бол 2023 онд БНХАУ 80 хувийг нь эзэлж байсан бол одоо 2024 онд болохоор 61 хувь болоод Булангийн орнууд буюу Иран, Ирак булангийн орнууд дээр нь болохоор 32 хувийн экспорт эзлээд, булангийн орнууд руу хонь, ямааны мах бас нэлээн түлхүү экспортод гарч байгаатай холбоотой байгаад байгаа юм. Мөн мах, махан бүтээгдэхүүн экспортын гүйцэтгэлээр нь харах юм бол хонины мах яг энэ 2024 онд нэлээн бас нэмэгдсэн тийм зураглал бол харагдаж байна. Та бүхэнд анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Мэдээллийг танилцуулсан Довчинсүрэн даргадаа баярлалаа. Нөөцийн махтай холбоотой мэдээллийг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Эрдэнэбилэг танилцуулна. Энэ бүх мэдээллийг бид нар гишүүдэд тараасан байгаа шүү. Товчлоод ярихгүй бол бас нэлээн хугацаа алдчих байх. 2 номерын микрофон. Энхбаяр сайд 6 номер.

Ж.Энхбаяр: Сая үндсэндээ нийслэл дээр хэрэгжүүлж байгаа юм хамт танилцуулагдсан тул асуултын явцад ярья. Одоо цаг хэмнээд энэ ЖДҮХС-ийн тухай танилцуулгаа хийчхээд, нэгдсэн маягаар хариулж болох уу.

Б.Бейсен: Одоо зүгээр махны асуудал дээр асуулт хариулт явъя. Сая мэдээлэлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Ганхүлэг гишүүн, Отгонбаяр гишүүн, Идэрбат гишүүнээр тасалъя. Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Өглөөний мэнд. Энэ малын даац хэтэрсэн байгаа асуудлыг эхлээд асуучихъя гэж бодож байна. Энэ болохоор ер нь дандаа л яригддаг л даа. Монгол Улсад одоогийн байдлаар 2024 оны танай танилцуулгаас харахаар 66 сая толгой мал тоолуулсан байна. Тэгчхээд НҮБ болон ХХААБ болон бусад судлаачид болохоор бэлчээрийн даацыг 25-30 сая толгой малаар хэтэрсэн тухай дүгнэлт гарсан гээд бичсэн байна. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор ХХААХҮЯ-аас ямар үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх гэж байна вэ. Ингээд хэтэрсэн байна гэсэн дүгнэлтүүд жил болгон явдаг мөртөө дорвитой арга хэмжээ авч байгаа зүйл харагдахгүй юм. Байгаль хамгаалах бүлгэм гээд байдаг. Тэр дээр Байгаль орчны яамныхны танилцуулсан танилцуулга дээр энэ цөлжилттэй холбоотой асуудлыг энэ малын тоо толгой даац хэтэрсэнтэй холбож бас тайлбарлаад байсан. Тэгэхээр манай Байнгын хороо яг энэ асуудлыг бүхэлд нь хариуцах учраас энэ дээр дорвитой арга хэмжээ авмаар байна. Ер нь энэ танилцуулгууд одоо бодит байдлаа сайн

тайлбарлах юм. Тэгээд нөхцөл байдлаа тодорхойлчих юм. Тэгчхээд шийдэл нь юу байгаагаа ерөөсөө дурдахгүй байгаа учраас асууж байгаа шүү. Тэгээд яг тодорхой хариулаад өгөөрэй.

Б.Бейсен: 6 номер. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Гишүүний асуултад хариулъя. Үнэхээр малын даац бэлчээрт харьцуулахад 25-30 сая толгой малаар хэтэрсэн гэдэг ийм дүн гараад байгаа. Энэ глобал цаг уурын өөрчлөлт Монгол улсын ургамлын бүрхэвчинд нэлээн томоохон нөлөө үзүүлж байгаа. Нөгөө талаас малын тоо өөрөө бэлчээрийг сэргэх, ургах үндсэн потенциалгаа өгөхөд бас нэлээн хязгаарлагддаг ийм механик хүчин зүйл болсон. Иймд бид экспорт гэдэг дээр л бүх анхаарлыг тавьж байгаа. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг хүчтэй нэмэгдүүлэхийн тулд бүх талын зах зээлийг нээх, гэрээ хэлэлцээрүүдийг баталгаажуулах, мал эмнэлгийн чиглэлээр хамтран ажиллах ажлуудыг зохион байгуулж байна. Ингэж байж 1 дүгээрт малын тоо толгойг зохистой хэмжээнд авчрах, нөгөө талаас экспортод мал мах эрчимтэй гарснаар малчдын орлого нэмэгдэх, энэ дээрээ тулгуурлаад малчид маань олон мал дээр биш ашиг шимтэй цөөн мал дээр экспортын чиг баримжаатай энэ чиглэлээр мал аж ахуйгаа хөтлөн явуулах ийм арга ухаанд их том хөшүүрэг болж байна. Тэгэхээр гол зүйл бол экспорт, экспорт, экспорт гэдэг зүйл дээр бид гол хүчийг хаяж байгаа.

Нөгөө тал дээр мөн энэ бэлчээрийн даацад нөлөөлж байгаа их томоохон асуудал бол ямаа буюу ноолуурын асуудал байгаа. Мөн ноолуурын гол үйлдвэрлэгч эцсийн зах зээл нийлүүлж байгаа дэлхийн томоохон компаниудтай хамтарч мөн мал аж ахуйг зохистой эрхлэх, чанарлаг, цөөн нарийн ширхэгт ямаан сүрэг дээр онцгойлон анхаарах, бэлчээрээ хамгаалах, мал маллах арга ухаандаа бодлогын өөрчлөлт оруулах гээд энэ олон зүйл энэ хүрээнд хийгдэж байгаа.

Тэгэхээр 1 дүгээрт экспорт, 2 дугаарт эрчимтэй тэжээлийн баазыг нэлээн сайн бий болгох, тэр дээрээ тулгуурласан үр ашигтай ийм маллагааг нэмэгдүүлэх, ингэснээр тоо толгойг нэлээн зохистой хэмжээнд нь авчрах гол шийд нь энэ юм болов уу гэсэн ийм бодлого явагдаж байгаа.

Б.Бейсен: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Ойлголоо. Экспортыг ерөнхийд нь дэмжиж явах нь. Тэгээд олон ч гэрээ хэлэлцээрүүд хийгдэж байгаа байх. Энэ ажил нь тэгээд сайн явагдах байх гэж найдаж байна. Өөр бас энд тодорхойгүй, тэгэхдээ байнга танай яамны танилцуулгууд дээр явж байдаг нэг өгүүлбэр болохоороо эрчимжсэн, төрөлжсөн аж ахуйг бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн төрөлжсөн аж ахуйтай хослуулан хөгжүүлнэ гэсэн өгүүлбэрүүд байх юм. Энэ нь яг юуг хэлээд байгаа юм. Энэ дээр 2025 онд яг юу юу төлөвлөсөн байгаа вэ.

Б.Бейсен: 6 номер. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Эрчимжсэн аж ахуй гэдэг бол үндсэндээ байнгын байран малгайтай аж ахуйнуудыг хэлж байгаа. Гахай, тахиа, шувуу, тэгээд сүүний фермүүдийг хэлнэ. Энэ бол байнгын малгайтай, байнгын жилийн 4 улирлын тэжээлийн нормтой байгаа аж ахуйг эрчимжинэ гэж ойлгоно.

Бид бол энэ төрөлжсөн буюу хосолсон аж ахуйнууд дээр их гол хүч тавьж байгаа. Энэ нь манай уламжлалт мал аж ахуй маань хавар, зун, намрын таатай үед бэлчээрээ ашиглаад, өвлийн бэлчээрийн дутагдалтай үед бол хүчжүүлэн тэжээх, нэмэлт тэжээлээр хангах, ингэхийн тулд тэр тэжээлийн бааз суурийг нь бий болгох, төвлөрүүлэн өсвөр малыг өсгөх, бордох ийм арга ухаантай хослуулах нь өөрөө ингэж явж байгаа.

Төрөлжүүлнэ гэж бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд төвийн бүсийг хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэе гэдэг ийм үүрэг өгсөн. Энэ дээр жишээлбэл.../минут дуусав/

Б.Бейсен: Бид нар өнөөдрийн энэ сонсгол дээр зөвхөн мал махны бэлтгэн нийлүүлэлт, нөөцийн мах, экспортын талаар тодорхой мэдээлэл сонсъё гэсэн. Тэр бэлчээрийн даац хэтрэлт, хадлан тэжээл бэлтгэлийн асуудал, малын эрчимжсэн асуудлыг хөдөө аж ахуйн сайдтай ярьж байгаад бид нар тусдаа асуудал болгоод ингээд ярих гэж байгаа. Тийм учраас өнөөдөр зөвхөн мах бэлтгэлийн талаар асуувал яасан юм бэ гээд гишүүдээс ганц хүсэлт байна. Отгонбаяр гишүүн.

У.Отгонбаяр: Өглөөний мэнд хүргэе. Мал, мах бэлтгэн нийлүүлэх талаар мэдээлэл сонслоо. Надад саяын мэдээллийн чиглэлээр ганц нэг асуулт байна.

Малчдын орлогыг нэмэгдүүлнэ гэж ярьж байна. Мах бэлтгэн нийлүүлнэ. Ер нь нэлээн л мал, мах бэлтгэх дүр зураг харагдаж байна л даа. Тэгээд үүнтэй холбогдуулаад ер нь яам малчдын орлогыг тодорхой яг яаж нэмэгдүүлэх гээд байгаа юм бэ. Энэ мал, мах бэлтгэх чиглэлээр.

Дараагийн бас нэг бодох ёстой асуултын тэмдэгтэй асуудал бол махны үнэ. Өнөөдөр малчдын хотон дээр байгаа үнэ, Дэнжийн 1000 дээр байгаа үнэ, экспортод гарч байгаа үнийн хооронд ямар зааг ялгаанууд байгаад байгаа юм. Энэ дээр бас тодорхой та бүгд маань мэдээлэл өгөөч.

Яагаад гэвэл өнгөрсөн жил улсын хэмжээнд бас нэлээдгүй малын хорогдолтой байсан. Тэр дундаа манай зүүн бүс нутаг Хэнтий, Дорнод, Сүхбаатар 4 орчим сая мал хорогдсон. Улсын хэмжээнд чинь 9,1 орчим мал хорогдсоны тэрний үндсэндээ бараг тал хувь нь зүүн бүсэд хорогдсон. Зүүн бүсдээ Сүхбаатар аймаг бол бүүр илүү 1,8 бараг 2 сая орчим мал хорогдсон. Тийм учраас одоо мал, мах бэлтгэх чиглэл рүү тооноос чанарт шилжих зайлшгүй шаардлага байгаа. Тэгэхийн тулд үнийн асуудал яригдана. Энэ чиглэлээр яам ямар бодлого барьж ажиллаж байгаа вэ гэдгийг би бас тодруулъя.

Сая нэлээн сүрдэн даржин Кувейт улс руу бас түүхий нойтон мах гарсан. Тэгээд энэ нь цаашаа ер нь үргэлжлэх боломж байна уу, байхгүй байна уу. Манай Сэргэлэн сайд нэлээн лайв хийгээд л, бичлэг явуулаад л, үнэ ханшийг нь гаргаад л нэлээн л юм болсон. Тэгээд сураг дуулах нь ээ энэ бол цаашаагаа бас төдийлөн явах ийм боломж бололцоо тааруу болсон гэж сонсогдсон. Тэгээд энэ дээр бас та бүгд маань тодорхой мэдээлэл өгөөч.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр мал аж ахуй маань нөгөө байгалийн эрсдэлд нэлээн их эмзэг байгаа нь өнгөрсөн зуднаар тодорхой болсон. 8.1 сая мал толгой хорогдсон.

Үндсэндээ хорогдлын хэмжээ тэрбум долларт хүрч, хохирол тооцогдож байгаа юм. Тэгэхээр малчдын орлогыг нэмэгдүүлэх гол зүйл бол мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулах. Нэмүү өртөг нэмэх тэр үйлдвэрлэлийг бий болгох. Энийг бол бид “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах. Мөн экспорт. Махны экспортыг л бүх түвшинд л урамшуулах. Мах, ноолуурын экспортыг. Экспортоо дагаад экспорт маань нэг үеэ бодвол улам л үнэтэй зах зээлд, шинэ шинэ зах зээлд Монголын мах, ноолуур гарч эхэлж байна. Монголын ноолуур дэлхийн хамгийн топ брэндүүдийн түүхий эд болж, бүтээгдэхүүн болж байна. Мах маань Араб, Ойрх Дорнод, Зүүн өмнөд Ази гээд үнэтэй махны зах зээл рүү гарч эхэлж байгаа. Тэгэхээр экспорт нэмэгдэж байж л тэрийг дагасан малчдын орлогын асуудал шийдэгдэнэ гэж үзэж, экспорт дээр бүх талын дэмжлэг зохион байгуулалтыг хийж байгаа.

Махны үнэ дээр дотоодын махны үнийг тогтооход бүх үнэ үндсэндээ зах зээлийнхээ эрэлт нийлүүлэлтээр явж байгаа. Төрийн оролцоо буюу нөөцийн мах бэлтгэх хэмжээнд үнийн ерөнхий чигийг гаргаж оролцож байгаа буюу та бүхэнд танилцуулсан үхрийн махыг бол 9400 төгрөгөөр, хонины махыг 8800 төгрөгөөр ястай махыг бэлтгэн авч, энэ маань бас тооны хувьд хязгаартай 5100 гаруй орчим мах бэлдэж, нийслэлийнхээ иргэдийн хаврын хэрэгцээнд зориулж байгаа. Энэ нь бол зөвхөн төрийн оролцох дээд оролцоо нь энэ. Тэрнээс махны үнийг барих, тогтворжуулах өөр бусад ямар нэгэн бололцоо байхгүй. Гэхдээ ер нь үнэ боломж нь байнгын өсөж байгаа. Мах бол нэг үеэ бодвол үнэтэй бүтээгдэхүүн болсон. Экспортын бүтээгдэхүүн болсон. Бид бол энэ жил чадвал 100 мянган тоннд хүргэж экспортыг бүх талаар урамшуулаадахъя. Энийгээ дагаад бол ихээхэн хэмжээний валют орлого нийт экспортын гарч байгаа махны нийт орлогын бараг 60, 70 хувь нь малчдын гар дээр очиж байгаа зүйл байхгүй юу. Тэгэхээр энэ өөрөө их сайн орлого.

Нөгөө талаар энэ сайн малчны бодлогыг нэлээн бас эргэж харах зайлшгүй шаардлага, тоо толгойны хойноос биш. Бид ашиг шимт байдал, чанарын асуудал, үржил селекцийн гэх мэтийн дараагийн түвшин рүүгээ гарахгүй бол сая Сүхбаатар аймагт болсон олон мянган малтай малчид мал, махаа борлуулахгүй аажуулж хүлээж байж үндсэндээ нийт малынхаа 60 гаруй хувийг алдаж байгаа ийм байдал ганц Сүхбаатар биш олон аймгуудад ийм байдал үүссэн. Тэгэхээр ер нь сүргийн бүтцийг зөв болгоё. Зөвхөн эх малаа өвөлдөө авч өвөлждөг, бусад өсвөр малаа ер нь намар цагт эртхэн бойжуулаад л ер нь дараагийн өсвөр мал бордох, өсгөх, тэгээд экспортын чиг баримжаатай энэ шинэ шинэ мал бордох аж ахуйнуудыг олон 10-аар нь бий болгож байж экспорт маань их тогтвортой явна.

Нөгөө талаар манай мал аж ахуйн экспортын сул тал нь жилийн 2 сар мал бэлдээд л бусад үед мал маань байнгын жингээ алдаж, хүндэрч байгаа. Үр ашигт байдал их муу. Иймд газар тариалангийнхаа тэжээлийнхээ давуу тал дээр тулгуурлаад, тэжээлийн массыг олон мянган тонноор нэмэгдүүлэх, үүн дээр тулгуурлаж өсвөр малыг бордох, тэгээд зах зээлд тасралтгүй өвлийн хүйтэн улиралд байнгын тэжээсэн мал махыг экспортод гаргадаг энэ чадавхыг бид нар бүрдүүлж чадвал Монгол Улсын мал аж ахуй зохистой буюу үр ашигтай байдал нь эрс дээшлэх, энийгээ дагаад малчдын маань орлого бас эрс дээшлэх, бэлчээрийн асуудлаа зохицуулах, ер нь маш олон асуудлыг шийдэхэд бол экспорт, шийдвэрлэх үүрэг, экспортын бодлого нэмэх нь тэжээлийн бодлого.

Мэдээж мал эмнэлгийн асуудлыг онцгой анхаарах ёстой .../минут дуусав/

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Тэгэхдээ ийм асуудал байна сайд аа. Яг бид нар өвлийн мах бэлтгэлийн асуудал ярьж байгаа учраас одоо хөдөө тийм бүсээс ч юм уу, аймгаас одоогийн байдлаар яг ийм тооны мах бэлдчихээд байна. Таван хошуу малын мах ийм тонн бэлдсэн. Гахайн мах ийм тонн, тахиа мах ийм гээд тодорхой хариулт өгөхгүй бол болохгүй болчхоод байна.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Би яг сая Бейсен гишүүний хэлснийг л тодруулах гээд байна. Жишээ нь яг бүсүүдээр яг зүүн бүс, баруун бүс, эдгээр бүсүүдээс, аймгуудаас яг хэчнээн тонн мах бэлтгэхээр төлөвлөж байна. Энэ мэдээллийг нэлээн тодорхой өгөөч гэдгийг бас хэлье.

Тэгээд түрүүн бас асуусан асуулт бас үлдэж байх шиг байна. Малчны хотон дахь үнэ, ченжийн гараар дамжаад, Дэнжийн мянга дээр очиж байгаа үнэ. Энэ 3 үнийн гол дахь хэчнээн төгрөгийн зөрүү хаана яваад байна. Энийг бас нэг тодруулж өгөөч. Яг үүгээр хийсэн тооцоо судалгаа байна уу, үгүй юу.

Б.Бейсен: 3 номер хариулъя.

Б.Эрдэнэчимэг: Би Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний газрын дарга Эрдэнэчимэг гэж хүн байгаа юм. 2023 онд Монгол Улсын Засгийн газрын 344 дүгээр тогтоолоор аймаг, нийслэлийн Засаг дарга хүнснийхээ нөөцийг бүрдүүлэх, худалдан борлуулах асуудлыг бүхэлд нь хариуцах болсон. Үүнээс хойш өнгөрсөн онд бид нар 6198 тонн мах бэлдээд, 6050 тонн махыг худалдаанд бол 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл бүр жижиглэнгээр ингэж гаргасан байж байгаа. Энэ онд бид нар 2025 оны хаврын хүнсний махны хэрэгцээг хангах зорилгоор 5100-5500 тонн мах бэлтгэхээр бол төлөвлөсөн. Үүнийхээ үр дүнд бид нар 2 удаа сонгон шалгаруулалт явуулаад, шалгуур үзүүлэлтийг хангасан 7 аж ахуйн нэр нэрсийг арилжааны банкнуудад нэрийг хүргүүлсэн. Үүнээс бол 3 аж ахуйн нэгжийн зээл бол шийдэгдчихсэн байж байгаа.../минут дуусав/

Б.Бейсен: 3 номер гэж гүйцээж хариулъя.

Б.Эрдэнэчимэг: Нийт 21 тэрбум төгрөгийн зээл шийдэгдчихсэн байж байна. Энэ аж ахуйн нэгжүүдийн маань бас нөгөө банканд очоод шалгуур үзүүлэлт нь орон нутгийн ялангуяа аймаг, орон нутагт үл хөдлөхтэй газруудын бас үл хөдлөхийг арай бага үнэлгээгээр үнэлснээс болоод нийт зээлийнх нь 80 хувь ч юм уу 70 хувь ч юм уу гарах ийм зүйл ажиглагдаж байгаа ийм нөхцөл.

Тэгээд Улаанбаатар хотын ерөнхий менежер бол энэ нөөцийн махны асуудлыг ахлаад ажиллаж байгаа. Хонины махыг 8800-аар бэлдье, үхрийн махыг 9400-аар бэлтгэхээр бид нар үнийг бэлтгэн нийлүүлэгч 7 аж ахуйн нэгжтэйгээ тохиролцоод, арилжааны банкнуудад саналыг хүргүүлсэн. Хавар ингээд мах махны үнэ бол нэлээн өндөр үнэд хүрдэг. Гэтэл энэ жил бол ерөөсөө махны үнэ буугаагүй. Ялангуяа энэ экспортод маш их хэмжээний мах гарч байгаа болохоороо хонины мах ер нь бол 8500-аас буусангүй. 9 мянган хооронд байлаа. Одоо бүүр 10 мянга руу орчхоод ингээд явж байгаа.

Б.Бейсен: Идэрбат гишүүн асуулт асууя. Сая аль бүсээс хэчнээн тонн мах бэлдсэн гээд асууж байна л даа. Уг нь яг одоогийн байдлаар ийм тооны дотоодын нөөц хотын хэмжээнд хэрэглэх хэдэн тонн мах бэлдсэн гэдгээ тодорхой хариул л даа. 3 номер.

Б.Эрдэнэчимэг: Бид нар энэ хавар өвлийн идэш арга хэмжээг бид нар бас зохион байгуулах гээд хоршоологчдоос хотынхондоо гээд уриандаа ороод ингээд зарлаж байна. Нийслэлийн хэмжээнд 8 байршилд бид нар байршлыг тогтоочихсон 12 сарын 12-ны өдрөөс энэ 4 дэх өдрөөс эхлээд худалдаа эхлэх гэж байгаа. Энэ дээр болбол ХХААХҮЯ болон Мал, эмнэлгийн газар манайхтай хамтраад явж байгаа. Одоогийн байдлаар бол 800 тонн махыг хоршоологчдоос нийлүүлэхээр бол бүртгэгдсэн байж байгаа. ХХАА хоршоодын холбоон дээр.

Б.Бейсен: Идэрбат гишүүнд асуулт асууя. Сайд хариулах гэж байна уу Энхбаяр сайд 6 номер.

Ж.Энхбаяр: Ер нь нийслэлийн иргэдийн хэрэглээнд өдөрт 120 тонн мах байхад хэрэглээгээ бүрэн барьдаг. Одоо энэ товчоо дээр манай постоор дамжин өнгөрч байгаа махны тоог харахад өдөрт 300-аас дээш тонн мах тасралтгүй орж ирж байна. Тэгэхээр махны нийлүүлэлт бол хангалттай байгаа. Нөгөө талаас сая энэ хоршоодоос нийслэлийнхэнд зориулсан энэ идэш арга хэмжээний хүрээнд улсын хэмжээнд байгаа бүх хоршоодод уриалга очсон. Тэнд бэлтгэн нийлүүлэлт, боловсруулалт хийгдээд наашийгаа Улаанбаатар хот руу нийлүүлэлтийн арга хэмжээг намрын өдрүүд, Алтан намар гээд бид нар ногооны хангалт хийгээд ард иргэдээ нөөцлөх бололцоог бүрдүүлдэгтэй адилхан энэ жил мөн махыг иргэддээ бас идэш хэмжээнд уламжлалт аргаараа нөөцлөх бололцоог бүрдүүлэх ажлыг хийж байгаа. Одоо ирэх 7 хоногийн хугацаанд энэ арга хэмжээ нийслэлийн хэмжээнд 8 байрлал дээр үргэлжилнэ. Улсын хэмжээнд энэ зохион байгуулалт явагдаж байгаа. Яагаад гэвэл .../минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Өглөөний мэнд хүргэе. Хүнс, хөдөө аж ахуйн яамны танилцуулгыг сонслоо. Яах вэ дотооддоо тэгээд нөөцийн мах бүрдүүлээд ингээд бид олон жил яваад л ирсэн. Тэгээд л жил болгон л нэг энийг Их Хурал дээр ярьдаг. Тийм л зүйл яригдаж байна л даа. Тэгэхээр яах вэ хөдөө аж ахуйн салбарт энэ мал маллаж байгаа малчдын орлогыг нэмэгдүүлэхэд махны экспортын асуудал бас туйлын чухал. Тэгээд өнгөрсөн хугацаанд энэ Болорчулуун сайд байхдаа квот юмыг нь байхгүй болгоод, тэгээд тэрний үр дүнд энэ олон аж ахуйн нэгжүүд бас гадагш нь экспорт хийгээд, өнөөдөр бид нар тэр дүнг нь та бүхэнд танилцуулж байх шиг байна. Тэгэхээр би ХААЯ-аас ер нь экспортод гаргаж байгаа, яах вэ улсын тоо нэмэгдэж байна. Хэмжээ нэмэгдэж байна. Одоо ХААЯ-ны дараагийн зорилго яг юу юм. Эзэнгүй энэ нөгөө мал маань үрждэг, өсдөг тулдаа тэгээд жилээ нөхөөд ингээд яваад байна шүү дээ. Гэхдээ бид гаргаж байгаа энэ баялгаа үнэд хүргэх тал дээр яг юу авч хэрэгжүүлж байгаа юм. Энэ гаргаж эхэлсэн цагаас хойш Монгол махны үнэ дэлхийн зах зээл дээр манай гаргаж байгаа энэ газруудад орнуудад яаж нэмэгдэж байгаа юм. Эндээс экспорт хийж байгаа аж ахуйн нэгжүүд нь яаж үнээ нэмж, яг малчин дээр үнэ нь яаж нэмэгдэж очиж байгаа вэ. Энэ бол энэ удаагийн яамны та бүхний хийх дараагийн ажил болов уу гэж би бодож байгаа юм. Экспортод гаргаж байна. Одоо үнэ нь яаж нэмэгдэж байна вэ. Хэрвээ надад та бүхэн хонины мах нь ингэж өсөж байна. Үхрийн мах нь ингэж

өсөж байна. Адууны мах нь ингэж өсөж байна. Хэрвээ өсөхгүй байгаа бол ямар учир шалтгаан байгаа гэж та бүхэн тооцож байгаа вэ. Учир шалтгааныг нь тодорхойлсон бол дараагийн тэр учир шалтгаанаа арилгах ямар зүйлийг бас төлөөлж байгаа вэ.

Бүстэй холбоотой асуудал ярихад Халх голын бүтээн байгуулалтын бүс гээд байна. Өнгөрсөн 2024 онд 600 гаруй сая төгрөг зарцуулжээ. Яг юу хийсэн, ямар бүтэц тэнд байгаа юм бэ. Халх гол сумаар явахад газрын бөөн хэрүүл байгаа шүү дээ. Тэрийгээ ч цэгцэлж чадаагүй. Аль Бурмаа сайдын үеэс эхэлсэн энэ нэг юм ингээд л яваад байдаг. Тэгээд бас дээрээс нь төсөв тавиад яваад байдаг. Энэ ер нь яг ямар учиртай юм. Энэ хөдөө аж ахуйн бүс нутаг, зүүн бүсийнхэнд ер нь ямар нэмэртэй юм болох гээд ингээд яваад байгаа юм. Энэ ужгирсан асуудал тэр болгоныг нь та нар шийдсэн юм уу. Очиж уулзсан юм уу. Халхгол сум дээр очиход бол тэр Бурмаа сайдыг тосож байсан тэр нөхцөл байдал арилаагүй л байгаа шүү дээ. Энэ 2 дээр би тодорхой хариулт авъя гэж бодож байна.

Б.Бейсен: 6 номер. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр өмнөх Засгийн газар, өмнөх Хүнс, хөдөө аж ахуйн яам, сайд Болорчулуун их чухал шийдвэр гаргасан буюу яг л энэ бодлого экспортыг л чөлөөлье гэдэг энэ шийдвэрийг гаргасан. Бидний үед энийг эрчимжүүлэх хэрэгжүүлэх, энэ шийдвэрийг ажил хэрэг болгох чиглэл дээр гол төвлөрч ажиллаж байна. Аль болох олон шинэ зах зээлийг, үүн дотроо үнэтэй зах зээлийг мах махан бүтээгдэхүүндээ нээх чиглэлээр ажиллаж байна. Үндсэндээ манай махны экспорт бараг 100 хувь 2 хөршдөө чиглэсэн. Үүний дотор БНХАУ бараг 90 гаруй хувь нь байсан. Энэ бүтэц их бодитой их томоохон өөрчлөгдөж, булангийн орнууд, Ойрх Дорнодын орнууд, жишээлбэл энэ жилийн байдлаар гэхэд л Ираны зах зээл 15855 орж ирж байна. Иракийн зах зээл орж ирж байна. Ингээд Зүүн Өмнөд Азийн зах зээл рүү орж байна. Булангийн орнуудын 4 оронтой бид нар энэ мал эмнэлгийн, хорио цээрийн бүх гэрээ хэлэлцээрүүдийг хийгдээд, эхний туршилтын ачилтууд хийгдээд очсон. Монгол мах ердөө 3 хоногийн дотор л 4 сүлжээ дэлгүүр дээр борлуулсан. Дуусаж байх жишээтэй. Төлөөлөгч нь ирэх 7 хоногт ирэх гэж байна. 7 хоногт 3 онгоц буулгана. Мах авъя гэж байна. Одоо ганц асуудал байна. Та бүгд тогтвортой нийлүүлэлтийг хангаж чадах уу л гэдэг. Гэтэл бид нар мал аж ахуйн байдал маань тогтвортой нийлүүлэлтийг хангахад учир дутагдалтай. 2 сарын бэлтгэн нийлүүлэлтийн ид үед ингээд л цаашдаа мал бол байнгын жингийн алдагдал, тэжээлийн дутагдал. Тэгэхээр энийг нөхөх гол бодлогыг бид Атрын 4 дүгээр аяны хүрээнд 200 гаруй мянган га.талбайгаар энэ тэжээлийн таримлын уруу талбайг эрс нэмэгдүүлэх, тэжээлийн том баазыг бий болгох. Ингэж байж малаа бид тэр жингийн алдагдлыг алдагдуулахгүйгээр энэ өвлийн хүнд үеийг давдаг, байнгын экспортод гаргах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр бас бодлогуудаа хийж байна. Төсөв батлагдах юм бол энэ бол нэлээн их бодитой ахиц гарна. Энэ бодлогоо Байнгын хорооныхоо гишүүдийг Дархан-Уул аймаг дахь яам дээр очиж танилцаасай гэж хүсэж, урьж байгаа юм. Энэ дээр бүгдээрээ нийт хөдөө аж ахуй хэрхэн орлоготой болох вэ, эрчимжүүлэх вэ, үүнийгээ дагаад малчин тариаланчдын ажил амьдралыг сайжруулах гэсэн бодлогоо бид нар иж бүрнээр танилцуулна.

Халх голын бүсийн асуудал үндсэндээ юу ч хийгдээгүй. Улс төржөөд, гацаад, шүүхдээд ийм байдалтай. 400 гаруй мянган га.талбай улсын нөөцөд Хөдөө аж ахуйн яамны мэдэлд байна. Энэ дээр шинээр сонгогдсон Бадамсүрэн гишүүн шинэ

аймгийн удирдлагуудтай энэ асуудлыг бид нар нэлээн тойрч нэгдсэн бодлогыг бас оруулж ирнэ. Энэ маань Монгол Улсын ер нь ирээдүйн гол нөөц ХАА-н нөөцийн нутаг. Тэгэхээр энд бас хаа хамаагүй сэтгэл хөдлөлөөр хандаж болохгүй, ултай суурьтай ийм бодлогыг бид нар орон нутагтайгаа хамтраад оруулж ирнэ. Орон нутагтайгаа ойлголцох зөвшилцөх ажлыг нэлээн бас урагшлуулж байгаа. Энийг тэгээд та бүгддээ танилцуулна гэдгийг хэлье.

Тэгээд нөгөө талаас мал эмнэлэг, мах, мал, махны экспортыг хангах гол суурь бол мал эмнэлгийг чадавхжуулах, мал эмнэлгийн шаардлагатай эм бэлдмэл вакциныг эх орондоо үйлдвэрлэх Био комбинатыг иж бүрэн шинэчлэх том зорилт байгаа. Энэ бодлогыг мөн гишүүддээ танилцуулна.

Нөгөө талаас ХААЯ-ны гол үүрэг бол гадаад харилцаа буюу зах зээлийг нээх. Энэ дэлхийн бусад оронтой худалдаанд ерөөсөө л нэг бол мал аж ахуйн гаралтай түүхий эд, нэг бол ургамлын гаралтай түүхий эд. Энэ 2-ыг л авч гарах нь гадаад гол ажил байдаг. Үндсэндээ ХААЯ-ны гол ажил бол гадаад ажил, гадаад бодлогын гадаад хамтын ажиллагаа байдаг. Харамсалтай нь ХААЯ нь гадаад харилцаа хэрэггүй гээд манай төсвийг үндсэндээ 0 болгож байгаа. Тэгэхээр дэлхийн бүх худалдаа Мал эмнэлгийн ерөнхий газар, Ургамал хамгааллын ерөнхий газар гэсэн энэ 2 байгууллагын хариуцсан мэргэжлийн гэрээ хэлэлцээр, гэрээ протоколын үр дүнд л явдаг гэдгийг гишүүд маань сайн .../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя гэж байна.

Ж.Энхбаяр: Ингээд гишүүд маань ойлгохгүй. Байгаль орчны яаманд байгаа Ойн газар, Хөдөө аж ахуйн, Ургамал хамгааллын газар 2 ямар ялгаатай юм гэж асуугаад байгаа юм. Ургамал хамгааллын газар бол үндсэндээ сая гишүүддээ бид нар мэдээллийг тараасан. Та бүхэн анхааралтай уншаарай. Үнэхээр дэлхийн гадаад худалдааг зохицуулах гол үүрэг бол энэ Мал эмнэлэг, ургамал хамгааллын 2 байгууллагаар дамжиж явагддаг. Нийт хүнсний 70 хувь ургамлын гаралтай, 30 хувь нь мал аж ахуйн гаралтай. Эдгээр байгууллагууд эдгээр системд дэлхийн хэмжээнд ажилладаг. Дэлхийн НҮБ-ын дэргэд ХАА-н байгууллага ийм 2 том, баруун, зүүн 2 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Энэ дээр би бас энэ төсвийг нь бас хасаад Ургамал хамгааллын агентлагийг байхгүй болгох хэрэгтэй гэдэг зүйл бас яваад байх шиг байна. Ингэж болохгүй ээ. Энэ бол гадаад худалдааг бид нар бий болгоё гэвэл энэ олон улсын шаардлагатай, НҮБ-ын хүлээсэн гэрээ конвенцод Монгол Улсын хүлээсэн үүргийн дагуу худалдаанд орж байгаа 130 гаруй орон ийм байгууллага.../минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм Энхбаяр сайдад сануулаад хэлчихэд зүүн бүсээс 7 гишүүн сонгогдсон шүү гэдгийг хэлье. 2 дугаарт ер нь энэ махны экспортын асуудал дээр би ер нь үе үеийн сайд нарт л хэлж байгаа асуудал энэ дээ. Бид ингээд махаа гаргах нь нэг хэрэг. Үнийн асуудал дээр л онцгой анхаарах нь зүйтэй хэрэг юм байна. Эндээс маш хямд үнээр гарсан мах тэнд тийм үнээр хүрч байна гээд ингээд юм яригдаад байдаг энийг л ойртуулах энэ тал дээр энэ яамны ажил бас чиглэж байгаа юм байна. Чиглүүлээрэй л гэж ингэж бас би хэлье.

Халх голын бүтээн байгуулалтын бүс дээр юу ч хийгдээгүй юм бол өнгөрсөн оны тэр 700 сая төгрөг хаашаа юунд зарцуулагдсан юм. Тэрийг бид бас анхаарах

хэрэгтэй. 2 дугаарт энэ оны төсөв дээр дахиад л мөнгө тавигдаж байгаа юм байна лээ. Тэгэхээр тэр бүс нутагт байгаа тэр үржил шимтэй тэр газрыг бид яг энэ улсын хэрэгцээнд хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын экспортод гаргах, экспорт руу чиглэсэн тэр мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх, газар тариалан хөгжүүлэх .../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулах юм уу. Энхбаяр сайд хариулъя. 6 номер.

Ж.Энхбаяр: Үнэхээр энэ Халх голын бүсийн захиргаа гээд 23 хүнтэй ийм бүтэн бүтэц, алба ажиллаад таны саяын хэлдэг энэ 500, 600 сая төгрөгийн урсгал зардалтай ажиллалчихсан байна лээ. Үндсэндээ ямар нэгэн бүтээмж урагшаа ахиж чадаагүй. Би Дорнод аймгийг дурдаад байгаа нь орон нутагтайгаа ойлголцож чадаагүй. Асуудлаа шийдэж чадаагүй ингээд улс төржчихсэн. Тэгэхээр энэ асуудлыг хойш тавиад хэрхэн хамтрах ажилд тэр орон нутгийн гишүүдтэй нэлээн сайн ойлголцсон. Мэдээж зүүн бүсийнхээ гишүүддээ энэ асуудлыг Дорнод аймагтайгаа хамтраад танилцуулна. Энэ 23 хүнтэй албыг нэлээн цомхотгоод, шийдвэр гаргаад, 5 хүнтэй болгоод өөрчилсөн. Ийм үргүй зардал гаргаад ажил шийдэгдээгүй бодлого тодорхой болоогүй байхад ийм бүтэц байх шаардлагагүй гэж үзээд зөвхөн яг санхүү, захиргааны 5 хүнийг үлдээд, бусдыг нь чөлөөлсөн.

Б.Бейсен: Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Малын экспорт, малын махны экспорт нэмэгдэж байгаа нь сайшаалтай хэрэг байна. Гэхдээ энэ махыг бэлтгэн нийлүүлж байгаа компаниуд ямар улсын компани билээ. 1 дүгээрт энийг асуумаар байна.

2 дугаарт Мал эмнэлгийн газарт бид нар очоод сонсгол хийсэн. Мал эмнэлгийн газрынхан тэр үед бол малын хил дамнасан халдварт өвчин байна, тэгээд дээрээс нь вакцин, тариа хяналтгүй байна, тэгээд хүч дутмаг байна. Хүн хүч гэсэн мэргэжилтэн гэсэн тийм асуудал тавьж байсан. Тэрэнд ямар арга хэмжээ авч байна вэ.

3 дугаарт бол малын түүхий эд, малын махыг борлуулж байгаа юм байна. Сайн байна. Тэгэхдээ малын түүхий эд гээд маш үнэтэй маш юу байгаа шүү дээ. Тэрнийг үнэгүйдүүлж болохгүй. Хажуугаас нь бас тэрнийг эцсийн бүтээгдэхүүн гаргах тал дээр ямар арга хэмжээ авч байна вэ. Энэ нь нэг талаас нь эцсийн бүтээгдэхүүн гаргах боловч нөгөө талаас нь ЖДҮ-г хөгжүүлэх гол ач холбогдолтой юм.

Тэгээд 4 дүгээрт 1 санал байна. Малыг эрүүлжүүлэх, малын махны үнийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах ёстой юм болов уу гээд бодож байна. Ийм 3 асуултад хариу авмаар байна.

Б.Бейсен: ХААЯ-ныхан хариулъя. Сайд хариулах юм уу. 6 номер.

Ж.Энхбаяр: Замира гишүүнтэй санал нэг байна. Үнэхээр мах экспорт нь гарч байж л малчдын орлого нэмэгдэнэ. Тэгэхийн тулд бид нар малын эрүүл мэндийн асуудал онцгой чухал. Амаргүй байгаа. Нийт шаардлагатай төсвийн 10-15 хувийг л бид хүлээж авч байгаа юм. Уг нь Монгол Улс бүх нутаг орноо нэг сайхан аюулгүй бүс болгоод, бүрэн вакцинжуулаад, 3-5 жилийн ийм хөтөлбөр хэрэгжүүлэхэд бол манай махны экспортын чадавх эрс шинэ түвшинд гарах ийм учиртай.

Хүний нөөцийн бодлого маш хүнд байна. Жилдээ 15 мянган мэргэжлийн боловсон хүчин бэлдэж байсан ХААИС маань 3000 хүрэхгүй оюутантай болсон. Салбарын боловсон хүчний бодлого яамандаа хамаарахаа больсон. Судалгааны Их сургууль хөгжүүлнэ гэж явсан. Үр дүн ийм. Тэнд бол хөдөө аж ахуйн аялал жуулчлал, хөдөө аж ахуйн менежмент, хөдөө аж ахуйн маркетинг гэсэн анги салбар их. Үндсэн малын зоо, агрономи, малын эмч хүрэлцэхгүй байгаа. Хүнгүй байгаа үндсэндээ. Бид ийм хүсэлт тавьсан. Аргаа бараад малын эмч, зоо техникч 2-ыг 1 мэргэжил гэж үзээд 45 хоногийн давтан сургалтаар шинэ мэдээллийг нь мэдлэгийг нь олгоод ингээд ажиллуулахгүй бол орон нутагт хүний нөөц хүрэлцэхгүй. Их олон сум мал аж ахуйн чиглэлийн мэргэжилтэн боловсон хүчингүй болж байгаа. Харин энэ мал эмнэлгийн үйлчилгээ хувьд 100 хувь шилжсэн байгаа. Бүх орон нутагт. Энэ энэ дээр л нэг жоохон тулгуурлаад, манай ахмадууд зүтгэж байна. Үндсэндээ тэтгэвэртээ гарсан малын эмч нар, зоотехникч нар энэ малын угаалга, туулга, вакцинжуулалтын ажлыг нуруундаа үүрээд зүтгэж байна. Халаа залгамж дутагдалтай байна. Энэ бодлого хэрэгтэй байгаа. Иймд вакцинаа дотоодод үйлдвэрлэх Био комбинатыг иж бүрэн шинэчлэх зайлшгүй том шаардлага, зорилт бидэнд байна. Тэгээд энэ мэтчилэн салбарын зовлонгууд их байгаа. Гэхдээ өөдрөг байна. Өөдрөг тал байгаа болохоор бид яаралтай энэ суурь уул уурхайн таатай үнийн өсөлтийн үед суурь болсон хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрүүдээ л яаралтай босгоод авмаар байгаа юм. Энэ хүрээнд л бодлого нь базагдаад, энэ Атрын 4 дүгээр аян малчдаа хоршоолох, ингээд “Цагаан алт” хүнсний хувьсгал гэсэн энэ 4 хөтөлбөр маань энэ хоорондоо уялдаатай нэг багц, тэр зорилго руу л тэмүүлж байгаа ийм хөтөлбөр байгаа юм. Тэгээд энэ тус бүрд нь бид нар дутагдаж байгаа эрх зүй орчин, дутагдаж байгаа санхүүжилт, хүний нөөц бодлогын асуудал гээд энэ бүгдээ би Байнгын хорооныхоо гишүүдэд нэг урьж байгаад танилцуулъя. Тэгээд энд хариулах 1 минутад үнэхээр амжихгүй байна.

Б.Бейсен: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Мах нийлүүлж байгаа үйлдвэрүүд хаанахынх вэ гэж асуусан. 1 дүгээрт. Тэгээд малын түүхий эд эцсийн бүтээгдэхүүн гаргах тал дээр ямар арга хэмжээ авч байна гэсэн 2 асуулт байна.

Б.Бейсен: 5 Номер Довчинсүрэн.

Г.Довчинсүрэн: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн байна. Мах, махан бүтээгдэхүүн экспортолж байгаа аж ахуйн нэгжүүд бол ер нь ихэвчлэн Монгол Улсын аж ахуйн нэгжүүд бол байгаа. Импортлогч орны шаардлагад нийцсэн, тухайн орныхоо цахим бүртгэлд бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүд л экспортод бол гарч байгаа. Ер нь Монгол Улсад бас хяналт шалгалтад орж, эрсдэлийн ангиллаараа бага эрсдэлтэй үнэлэгдсэн болон тухайн орныхоо цахим бүртгэлд бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүд бол байгаа.

БНХАУ-д бол адууны мах экспортлох эрхтэй үйлдвэр гэвэл 11 үйлдвэр байна. Жишээ нь гэхэд бол Монгол мах экспо, Монгол эко мах, Тэс шим энэ тэр гээд гэх мэтчилэн ер нь Монголын аж ахуйн нэгжүүд бол байгаа. Харин Иран, Ирак, Булангийн орнууд руу бас зарим аж ахуйн нэгжүүд бол тухайн эрхтэй үйлдвэрт нь бол гэрээ хэлэлцээр хийгээд, тэнд бэлтгээд махыг бол экспортод гаргаж байгаа бол асуудлууд бол байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. 2, 3 асуудлууд байна. Тэр ХААИС дээр бол санал нэгтэй байна. Энэ ХААИС чинь би сүүлдээ ойлгохоо байсан шүү дээ. Энэ аялал жуулчлалын маркетингийн чиглэлээр ингээд ангитай болчихсон явж байдаг. Тэнд аялал жуулчлал юугаа ч хийж явдаг юм. ХААИС-ийн бодлогыг нь жоохон цэгцлэх гэдэг дээр бол Энхбаяр сайдтай үнэхээр санал нэгтэй байна. Мэргэшсэн хүмүүсээ тэнд бэлдэж байх ёстой ийм газар. Ёстой болдог бол ХААЯ-аа дагуулаад тэр Дархан руу нүүлгэчихмээр юм шиг байгаа юм. Хотод юу ч хийх юм энэ ХААИС. Тэгэхээр энэ ХААИС-д бол яамны бодлого бас оролцоосой гэж хүсэж байгаа.

Мах нядалгаа, мах бэлтгэлтэй холбоотой асуудал дээр бол яах вэ, тэгээд бэлдэж байгаа. Энэ эрүүл ахуйн асуудлаа хэдүүлээ яах вэ. Мал нь өөрөө амьд байхдаа эрүүл байдаг. Нядалгаа бэлтгэл нөөцийн хэлбэр лүүгээ орохоороо өвчлөлийн асуудал, нян вирусийн асуудал их хэмжээгээр хөндөгдөж байгаа. Тэгээд энэ Эмээлтийн бойноос авхуулаад маш том асуудалтай газрууд их л байна л даа. Мэдээж аж ахуйн нэгжүүд өөрсдөө тендерт ороод, тодорхой төсөв мөнгийг нь зээлээр аваад, мах бэлтгэл нөөц дээр бол ажиллаж байгаа байх. Гэхдээ энэ махны эрүүл ахуйн байдалтай холбоотой асуудал дээр ХААЯ ямар байдалтай анхаарч ажиллаж байгаа вэ. Нийслэл энэ дээрээ хэр түвшинд анхаарч байгаа вэ гэдгийг асуух гэж байгаа юм.

2 дугаар асуулт махны экспорттой холбоотой асуудал байна. Ер нь бол яах вэ экспорт гараад байх боломжтой. Гэхдээ бид нар мах, мал, экспорт дээр бид нар хүссэн ч эс хүссэн ч бид нар бэлчээрийнхээ асуудлыг ярина. Эрчимжүүлсэн болон хосолмол, төрөлжүүлсэн бүгдийг нь л ярихаас өөр аргагүй хэлбэр лүү орно. Энийг ярьж байж бид нар мал, махны экспортын асуудлыг хөндөнө. Бид нар эндээс экспортолно л гээд байдаг. Хил, хорио цээрийн асуудлууд байдаг. Нөгөө талдаа 2 шаардлага л байгаа шүү дээ. Цаад талаасаа эрүүл ахуйн шаардлага хангасан байх ёстой. 2 дугаарт тасралтгүй нийлүүлэлттэй байх ёстой. Тасалдаж болохгүй. Тасалдвал дараагийн түвшин дээр тухайн махыг манай орноос авах хэлбэр өөрчлөгдөнө. Тэгэхээр энэ дээр тасралтгүй нийлүүлэхэд буюу мах экспортын боломжийг нэмэгдүүлэх стратегийг та бүхэн маань өөрсдөө яаж харж байгаа вэ.

3 дугаар асуулт. Махны үйлдвэртэй холбоотой асуудлууд байна. Ер нь энэ махны үйлдвэрлэл дээр ямар ямар бэрхшээлүүд тулгарч байгаа юм. Энэ махны үйлдвэрлэлтэй холбоотой асуудал дээр ХХААХҮЯ цаашдаа ямар бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж байгаа юм. Зөвхөн тендер хэлбэр сонгон шалгаруулалт зарлаад, тэндээсээ нийлүүлсэн махыг авдаг хэлбэр дээр байх юм уу эсвэл энэ эрүүл ахуй чиглэлтэй нь холбоод махны үйлдвэрүүд дээр тавих стандарттай холбоотой асуудлаа мөрдүүлэхийг давхар анхаарах юм уу. Хуучин мэргэжлийн хяналтын байгууллага гэж тусдаа байсан. Одоо салбарын хяналт бол яам дээр оччихсон байгаа шүү дээ. Энэ дээр хариулт авъя.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр стандартыг ялангуяа махны үйлдвэр бол онцгой анхаардаг. Ялангуяа экспортод гаргаж байгаа мал, мах бэлдэж байгаа аж ахуйн нэгжүүд, тэр үйлдвэрийг бол тухайн орны мэргэжлийн хорио цээрийн, мал эмнэлгийн байгууллагууд, тэдний экспертийн бүрэлдэхүүн өөрсдөө ирээд хянаад,

шалгаад, магадлан итгэмжлээд, улс орныхоо холбогдох стандартаа тэнд нэвтрүүлээд, түүний үндсэн дээр экспорт авагдаж байгаа юм. Иймд экспортын махны чанар стандартын асуудлууд боломжийн. Сая гэхэд л Катар, Кувейт, Оман гээд энэ булангийн орнуудын халал стандартыг Монголын үйлдвэрүүд магадлан итгэмжлэгдээд нэр бүхий үйлдвэрүүдээс аваад энэ экспортыг эхэлж байгаа жишээ байна. Мэдээж тасралтгүй гаргах л гол шаардлага. Монгол махны чанар, амт, асуудал алга байна. Сайн байна. Тасралтгүй нийлүүлэхэд бидний гол дутагдал бол өвлийн сэрүүн улирлын энэ жингийн алдалтыг нөхөх, баталгаатай тэжээлийн баазыг бий болгох. Энэ дээр Атрын 4 дүгээр аяны хүрээнд бид нар тэжээлийн таримлын талбайгаа 200 мянган га-аар нэмэгдүүлэхээр оруулж ирж байгаа. Одоо бид Атрын 1, 2 дугаар аяны хүрээнд хүн ам 1 сая гаруй байхад эзэмшсэн 900 гаруй мянган га талбайтай. Энийгээ ядахдаа 20 хувь 200 мянган га-аар нэмэгдүүлэе. Энэ нь бол тэжээлийн бодлого дээр нэлээн тулгуурлая. Нүүдлийн мал аж ахуйгаас бас эрсдэлээс, үүнээсээ хамгаалъя. Мөн экспортын мах, малаа энэ тэжээл дээрээ тулгуурлаж, өвлийн жингийн алдагдлыг нөхөх ийм бодлого тасралтгүй явуулъя гэж. Энийгээ л төрөлжсөн, хосолмол энэ аж ахуйнууд дээрээ тулгуурлаж явагдана.

Бат-Эрдэнэ гишүүн сургуулийн асуудлыг хөндсөнд их баяртай байна. Үнэхээр хүний нөөцийн гүн дутагдалд орж байна. Бид иж бүрэн дүгнэлт хийж бодлого гаргахгүй бол болохоо байлаа.

Хамгийн сүүлд энэ ХААИС-ийн харьяанд байсан 6 хүрээлэн, хөдөө аж ахуйн гол судалгааны хүрээлэнгүүд их сургуулиа хаясан. Их сургуулийнхаа харьяаллаас нь гараад, Эдийн засаг, хөгжлийн яамны бүтцэд сая шилжчихсэн. Ингээд сургууль маань салбарын боловсон хүчин ч үгүй, судалгаа шинжилгээний байгууллага ч үгүй, тэгээд л ийм л байдалд орж байгаа. Тэгэхээр хөдөө аж ахуйн энэ суурь 600 мянган хүн ажиллаж байгаа салбар шүү дээ. Монголын 2 хүний 1 ажлын байраар хангаж байгаа, нийгмийн хамгийн тогтвортой байдлыг хангаж байгаа энэ салбарын хүний нөөц, боловсон хүчин, шинжлэх ухааны бодлого үйлдвэрлэлээсээ холдож байгаа энэ зүйлийг яаралтай засаж залруулах нь манай энэ Их Хурлын Байнгын хороо, яамны бидний хамтын ажиллагаанаас их юм шалтгаалах байх.

Дахиад хэлье гишүүд ээ урьж байна. Бүгдээрээ бүтэн 2 өдөр вакумжиж энэ салбарын бодлогыг хаана байрлуулах вэ, хаана аж ахуйнуудаа төрөлжүүлэх вэ, хаана үйлдвэрлэлээ хийх вэ, эрх зүйн бодлогоо яаж гаргах вэ, гадаад зах зээлийн хандлага ямар байна, гадаад аюулгүй байдал, геополитикийн орчин юу болж байна, хүнсний аюулгүй байдалтай холбоотой Монголд учрах эрсдэлүүд юу байна, дотроо юуг үйлдвэрлэх вэ гэсэн ийм зүйлээр 2 өдөр сайхан ярилцах ийм танилцуулгуудаа сонсоод, хамтран ажиллахыг урьж байна.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Гадаадынх бол угаасаа ойлгомжтой. Хил, хорио цээрээрээ шийдвэрлэгдчихэж байгаа. Эрүүл ахуйн асуудал. Тэр дотоодынхоо хариулт авмаар байна. Тэгээд би дараа нь тодруулга авъя.

Б.Бейсен: Дотоодын тэр хүнсний махны эрүүл ахуйн асуудал дээр 4 номер хариулах юм байна. Дараа нь энэ Болдбаатар уу Мал эмнэлгийн ерөнхий газрын. Дараа нь энэ Нийслэлийн ХХААГ-ын Хүнсний үйлдвэрийн хэлтсийн дарга Ундармаа энэ дээр бас эрүүл ахуйн асуудал дээр хариулаарай.

Б.Болдбаатар: Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Болдбаатар байна. 2022 онд махны техникийн зохицуулалт гэж эрүүл ахуйн хамгийн том стандартаа Засгийн газраар албан ёсоор батлуулсан. Махны техникийн зохицуулалтыг үе шаттай хэрэгжүүлэхээр тавьсан байгаа. Яагаад гэхээр тухайн үед бол нэлээн өндөр шаардлага тавиад ороод ирсэн учраас үйлдвэрүүд үүний бэлтгэлийг хангах ийм боломжийг үлдээсэн. 2025 оны 1 сарын 1-ээс эхлээд улсын хэмжээнд худалдаа үйлдвэрлэлд ашиглагдах бүх мах бол үйлдвэрийн аргаар эрүүл ахуй ариун цэврийн шаардлага хангасан үйлдвэрийн аргаар бэлтгэгдсэн байна гэдэг ийм шаардлага нь 2025 оны 1 сарын 1-ээс эхлээд мөрдөх нь. Үүнтэй холбоотойгоор Мал эмнэлгийн ерөнхий газраас үйлдвэрүүдийг хариуцсан улсын байцаагч нарыг үйлдвэр дээр нь ажиллуулж, энэ эрүүл ахуйн шаардлага хангуулах энэ ажлыг мэргэжил арга зүйн хувьд хангах чиг үүрэгтэйгээр ажиллуулж байна.

Б.Бейсен: 2 номер. Ундармаа.

Р.Ундармаа: Нийслэлийн ХХААГ-ын Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ундармаа байна. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа махны үйлдвэрүүдийн хувьд бол нийтдээ ер нь мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, цех бол нийт 379 ийм үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байгаа. Үүнээс бол мал төхөөрөх 43 үйлдвэр, мах боловсруулах 115 үйлдвэр. Үлдсэн нь дандаа цехүүд гэсэн ангилал дотор явж байгаа. Энэ үйлдвэрүүд дээр бол эрүүл ахуй болон эрүүл ахуйн хяналтыг бол нөгөө мэргэжлийн хяналт тарснаас холбогдолтойгоор эрүүл ахуйн хяналтыг НЭМГ-аас тавьж ажиллаж байгаа. Яг малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн болох мах, сүүн дээр бол Нийслэлийн мал эмнэлгийн газар холбогдох байцаагч нар бас мөн хяналтаа тавиад ажиллаж байгаа.

2025 оноос бол манай нийслэл бол .../минут дуусав/

Б.Бейсен: 2 номер гүйцээж хариулъя.

Р.Ундармаа: 2025 онд бол нийслэлээс эдгээр мах боловсруулах үйлдвэрүүд дээр мониторингийн шалгалт нэгдсэн журмаар явуулахаар төлөвлөж байгаа. Мөн техникийн зохицуулалт хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор ингээд энэ хяналт шалгалтыг хийхээр төлөвлөж байна.

Б.Бейсен: Үйлдвэр дээр тэгээд эрүүл ахуйн байцаагч ч юм уу тийм юм байдаггүй юм уу.

Р.Ундармаа: НЭМГ дээр эрүүл ахуйн байцаагч нар ажиллаж байгаа. Нийслэлийн мал эмнэлгийн газар дээр бас махны чанар стандартын хяналтын улсын байцаагч нар ажиллаж байгаа. Үйлдвэр өөрийнхөө бүтцэд бол бүх эрүүл ахуйч яг орон тоогоороо ажиллаж байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм. Одоо ингээд л нөгөө гөлөг төөрүүлж байгаа юм шиг л бие бие рүүгээ чихээд л дуусдаг юм л даа. Ер нь бол энэ махны яг бэлтгэлийн эрүүл ахуйн нөхцөл байдал бол маш хангалтгүй байгаа шүү дээ. Би өөрөө бас ШӨХТГ-ын даргаар ажиллаж байсан. Ямар нөхцөл байдалтай байдгийг

нь мэдэж байгаа. Та нар ингээд л нэг хариулт ийм байдалтай яваад л өнгөрч байгаа юм.

Тэр Ургамал хамгааллын үндэсний байгууллагатай болох нь зөв байх. Одоо энэ чинь би буруу сонсоогүй бол энэ ургамлын ялангуяа энэ малын идэж байгаа өвс тэжээл ургамалтай холбоотой асуудал дээр шим тэжээлийн дутагдалд орох бог мал 3-7кг, бод мал 7-14кг амьдын жин буурсан гэдэг ийм тооцоо судалгаа байдаг юм байна лээ. Тэгээд энэ бэлчээрийн асуудал дээр ер нь цаашдаа хэдүүлээ нэлээн сайн анхаарахгүй бол бид нар цаашдаа экспортод гарч байгаа махны, малын асуудлаа шийдвэрлэхэд бас хэцүү л дээ.../минут дуусав/

Б.Бейсен: Санал хэллээ. Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Би буруу санаагүй бол энэ 2024-2028 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрт нөөцийн мах бэлдэхгүй гэж орсон шиг санах юм. Анх мөрийн хөтөлбөрийн төсөл явж байхад тийм санал орж ирж байсан юм даа. Хэн нь, хаанаас нь, мөрийн хөтөлбөрөөс нь хасаад хаячхав. Ер нь нөөцийн мах бэлтгэх, экспортод гаргах тухай яриа чинь бол их эсрэг тэсрэг зүйл шүү дээ. Ер нь аливаа барааны үнэд төрөөс оролцохыг бол би эсрэг байдаг хүн. Энэ нөөцийн мах гэдэг чинь бол үндсэндээ бол төрөөс бас үнийг хянах, зохицуулах гэж байгаа оролдлого байхгүй юу. Бид нар өнгөрсөн өчнөөн олон жил нөөцийн мах бэлтгээд ямар үр дүн авчирсан юм. Тэгээд одоо дээрээс нь ирэх жил үхрийн махыг 9400, хонины махыг 8800-аар бэлдэх юм байна л даа. Ирэх хавар 20 мянга хүрэхэд 50 хувиар нь төрөөс ингээд хүчээр хатуу бариад байна гэдэг чинь нэг талдаа малчдыг орлогожуулна, дэмжинэ гэж байгаа чинь эсрэгээрээ болчхож байгаа байхгүй юу. Экспортолно гэдэг чинь бүр эсрэг яриа. Одоо бид 2 эсрэг юмыг нэг дор яриад байж байна шүү дээ. Үнэхээрийн малчдыг орлогожуулах гэж байгаа бол нөөцийн махаар чөлөөт зах зээл дээр хавар 20 мянга хүрдэг махыг нь 9400-д бариад байхаар чинь малчид яаж орлоготой байх юм. Малчид чинь хавартаа жоохон ноолуур зарж, намартаа жоохон мах зарж л орлоготой байдаг байхгүй юу. Тэгэхээр энэ аргаа ер нь яваандаа яам бол бодлого л барих ёстой. Өөрчлөх ёстой шүү дээ. Ойлгож байгаа. Нэг талдаа малчдаа орлогожуулах, нөгөө талдаа нийслэлийнхээ хүн амыг мах, махан бүтээгдэхүүн хямдаар хангах гэдэг ийм 2 хайчин дотор байдгийг чинь ойлгож байгаа юм. Гэхдээ дэлхий даяар энийг чинь шийдчихсэн зөндөө гарц байна. Төв суурин газраа тэр бордооны аж ахуй болоод хямд аргаар тэжээдэг ялангуяа эрдэнэ шишийн аргаар тэжээдэг үхрийн аж ахуйнууд олноор байгуулаад төв суурин газрынхаа өдөртөө нийслэлийн хэрэгцээ чинь 120 тонн мах л байдаг юм байна шүү дээ. Иймэрхүү бодлогын юмаа ярих болоогүй юм уу. Дэлхий даяар өнөөдөр граспед, гринпед, корнпед гээд 3 төрлийн мах байна. Бид хамгийн үнэтэй граспедээ өнөөдөр 9400 төгрөгөөр хатуу үнийг нь барих гээд яриад байж байна шүү дээ. Үнэтэй махаа үнэтэй зарчхаад, харин энэ төв суурин газраа хямд махаар хангах бодлого энэ чинь та нар өчнөөн олон жил ийм юмаа хийсэнгүй шүү дээ ХААЯ. Энэ дээр тэр хариултаа өгчхөөрэй. Ер нь ямар бодлого барих юм.

Говийн бүсэд өсвөр насны мал бордох аж ахуйнуудыг олноор байгуулбал харин энэ экспорт чинь түрүүнээс хойш Энхбаяр сайдын яриад байгаа тогтвортой нийлүүлэх асуудал чинь бий болно шүү дээ. Дулааны нийлбэр ихтэй говийн бүсэд бол үндсэндээ 45 хоног л хүйтэрч байна. Бусад үед бол харьцангуй гайгүй байгаа үед говийн бүсэд тэр өсвөр насны мал бордох аж ахуй дээр яам ямар бодлого баримталдаг юм бэ гэж.

3 дахь нь энэ нэг.../минут дуусав/

Б.Бейсен: Ганбаатар гишүүнд 1 минут нэмж олгоё.

Г.Ганбаатар: Ургамал хамгааллын агентлаг байгуулах шаардлагатай тухай энэ дөнгөж сая орж ирж байна л даа. Яг үндсэндээ Ургамал хамгааллын хүрээлэн гээд 3 хүрээлэн байна шүү дээ. Эдийн засаг, хөгжлийн яаман дээр 1 байж байна. ХААИС дээр байж байна. Ахиад хаана ч билээ. Би сая бүх хүрээлэнгүүдийн материалыг татаад үзсэн юм. Монгол Улсад 35 хүрээлэнд 2081 ажилтан байж байна. 3 ийм ургамал хамгааллын хүрээлэн байж байхад ахиад төсвийн 500 сая төгрөгөөр 50 хүнтэй ийм байгууллага байгуулах шаардлага байгаа юу. Эсвэл тэр 3 хүрээлэнгээ яах ёстой юм. Энийгээ бас тодорхой ярих нь зөв байх гэсэн ийм бодол байна. Хариулт авъя.

Б.Бейсен: 6 номер.

Ж.Энхбаяр: Нийтдээ бид 16 сая толгой малыг хэрэгцээлгэх бололцоо байгаа юм. Нөөц нийт 1 543 мянган тонн мал, мах дотоодын хүнсний хэрэглээ болон экспортод. Өнөөдөр дотооддоо 340 мянга, экспортод 200 мянга гэсэн боломж байна. 200000-ын бололцооны энэ жил чадвал 100 мянгад нь хүргэчих гэсэн ийм зорилт тавиад ажиллаж байгаа. Хүнсний тухай хуулиар энэ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатын Засаг дарга авч хэрэгжүүлэхээр ингээд заачихсан. Хуучин бол яам бэлдээд бөөн юм болдог байсан юм. Ирэх квот болгоод л зүгээр янз янзын юм болдог. Тийм зүйл байхгүй болсон. Үндсэндээ тооцоо хийгээд нийслэлийн хэмжээнд гэхэд л үндсэндээ 5100 тонн мах стратегийн нөөц гэж юу ч болоо билээ. Ямар нэгэн тодорхой эрсдэл байхад тогтвортой нийлүүлэлтийг хангах 5100 тонн нийт бид нарын бэлдэж байгаа 500 мянган тонны хажууд 1 хувь ч хүрэхгүй хэмжээний л нөөц байгаа. Энэ бол яг тийм стратегийн нөөцөө бэлдэж Хүнсний тухай хуулиараа яам хийхээ больсон6 Нийслэл хийдэг болсон. Орон нутгууд хариуцдаг болсон. Тэгэхээрээ бодлогын их том өөрчлөлт явчхаад ингээд хэрэгжээд эхэлж байгаа гэдгийг бас Ганбаатар гишүүн ээ ойлгоорой.

Ер нь дэлхий нийт тэр чигээрээ л глобал цаг уурын өөрчлөлт, үүнээс үүдэж байгаа хүнсний дутагдлыг л тойрч ирж байна. Яаж хангах вэ л гэж. Энэ хүнс дээр эгч дүү 3 конвенц гээд хатуу 3 бодлого зохицуулалт дэлхийн хэмжээнд үйлчилж байгаа. Хүнсний аюулгүй байдлын код, Ургамал хамгааллын олон улсын конвенц, ДМАЭМБ гэсэн. Бид бол Мал эмнэлгийн ерөнхий газартай.

Хүнсний аюулгүй байдлын асуудал үндсэндээ Мэргэжлийн хяналтын газар байж байгаад задарчихсан. Хүнсний бэлтгэл нийлүүлэлт, худалдаа сүлжээ бүр энэ бүх үйл явцыг Мэргэжлийн хяналтын газар задарснаар бодлогын гэгдэж байсан яамнууд үндсэндээ үйл ажиллагааны яам болоод хувирчихсан. Энэ айхтар том өөрчлөлт явчихсан. Энийг бид бас сайн ойлгох хэрэгтэй. Одоо бид энэ салбарын бүхий л үйл ажиллагаа, бодлого, үйл ажиллагаа, тэгээд хэрэгжилт, салбарын хяналт, хариуцлагыг яамнууд хүлээдэг. Үндсэндээ үйл ажиллагааны яам болж хувирчихсан шүү. Тэгэхээрээ бидний бүтэц, бодлого, үйл ажиллагаа хүртэл их өөр байхаас аргагүй. Бид чинь бүх яамнууд ер нь бодлогын яам байна гээд бүтэц болгоод тэр чигтээ саваад нэг өөр хэм хэмжээнд оччихсон. Мэргэжлийн хяналт татан буугдсантай холбоотойгоор маш олон чиг үүргүүд ирсэн. Ингээд маш олон

салбарын хяналт зохицуулалт хаягдаж байгаа. Ялангуяа хүнсний аюулгүй байдлын асуудал бол туйлын асуудалтай сая гишүүд хөндөөд байна.

Ургамал хамгааллын олон улсын энэ конвенцод дэлхийн бүх орон орсон. Монгол Улс мөн элсэн орсон. Энд дэлхийн бүх худалдаа мал, амьтны гаралтай, ургамлын гаралтай бүх хүнсний худалдааг хийхэд энэ 3 конвенцоо бариад л энэ ургамал хамгааллын ОУБ, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагууд хийх учиртай шүү. Энийг судалгаа шинжилгээний хүрээлэнгүүдтэй Ганбаатар гишүүн ээ андуурч болохгүй. Бид цаашдаа гадаад худалдаанд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, хүнс экспортлогч орон болох зорилт тавьж байна. Нөгөө талаас бид жилдээ тэрбум долларын 1 тэрбум 100 сая орчим долларын хүнсийг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг импортоор авч байгаа энэ улсын хувьд энэ хүн амынхаа хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд энэ байх ёстой байгууллагууд энэ шаардлагуудыг хийнэ. Тэрнээс яам дэлхийн Мал эмнэлгийн байгууллагатай .../минут дуусав

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Тэр Хүнсний тухай хуулиар нь яам биш, нийслэл нөөцийн мах бэлддэг болсон юм байна л даа. Тэгээд үндсэндээ яах вэ, миний гол агуулга нь ер нь ингээд үнийг төрөөс зохицуулах гээд байгаа зүйл чинь ер нь үр дүн авчирдаггүй юм шүү дээ. Бид нар чөлөөт зах зээл дээр явж байгаа юм. Бид нар нэг талдаа ингээд малчдаа дэмжинэ гээд байгаа боловч, нөгөө талд нь ингээд үнийг нь хатуу хянаад байгаа чинь энэ оролдлого чинь малчдын амьдралыг, малчдын орлогыг улам бууруулаад байгаа байхгүй юу. Энэ талаас л хэлж байгаа юм. Тэр юун дээр бол яах вэ, тэр ургамал хамгааллын. Тэгвэл энэ 3 Ургамал хамгааллын хүрээлэн нэгтгээд юу яахгүй бол нэг хууль гаргаад л нэг ийм агентлаг байгуулдаг. Тэнд 3 ургамал хамгааллын хүрээлэн байгаа байхгүй юу. Ер нь энэ хүрээлэнгүүд чинь би түрүүнд хэллээ шүү дээ. 35 хүрээлэн байна. Бүгдийг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас татаж үзээд би юу яагаад байна л даа. Хууль гаргаад л нэг ийм шинэ байгууллага ингээд .../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя. 6 номер.

Ж.Энхбаяр: Ганбаатар гишүүн ээ, та бид 2 үнэхээр яг нэг байр суурьтай. Хөдөө аж ахуйн салбарыг үнийг чөлөөлж байж, экспортод чиглэсэн чиг баримжаатай хөгжүүлж байж л манай малчдын амьдрал, манай хөнгөн хүнсний үйлдвэрүүд босож ирнэ. Тэгэхээр махны энэ жилийн 540 мянган тонн мах бэлтгэл бол яг ийм зарчим дээр. Стратегийн гэж байгаа юм. Стратегийн нөөц бүрдүүлэх хэмжээнд бид энэ 543 мянган бэлтгэгдэж байгаа махнаас 5100 махыг нийслэлийн аюулгүй нөөц, стратегийн нөөц болгон авч байгаа. Энийг авахдаа байгаа төсвийнхөө хүрээнд тэр зах зээлийнхээ үнийнх нь тооцоо дээр л тулгуурлаад, тэр 9 мянга, 8 мянга гэсэн үнэ гараад, зах зээлээсээ л адилхан худалдаж авч байгаа шүү дээ. Тэрнээс хатуу үнэ тогтоох, хязгаарлах ямар ч оролдлого байхгүй. Байж ч болохгүй. Ахиад хэлье. Хөдөөг хөгжүүлэхийн тулд бид хөдөө аж ахуйн экспортыг л босгож байж малчдын маань.../минут дуусав/

Б.Бейсен: Ундраа гишүүн асуулт асууя.

А.Ундраа: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Гишүүд маань бас л маш чухал асуултууд асууж байна л даа. Тэгээд харж байхад ер нь хариулт бол тун

хангалтгүй л санагдаж байна. Яг бодитой тоон дээр тулгуурласан, бодлогоо тайлбарласан хариулт биш, ерөнхийдөө ийм бөөрөнхийлсөн байдлаар хариулаад байгаа л гэж надад бол тэгж буугаад байна. Би дутуу ойлгоод байж магадгүй юм.

Миний асуух асуулт болохоор ер нь бол өвөлжилт өнгөрсөн жил хүндэрсэнтэй холбоотой зүүн бүсээс сонгогдсон гишүүд хэд хэдэн асуулт асуулаа. Тэгээд ер нь бол энэ Засгийн газрын бүтэц зурагдсаны дараа Хүнс, хөдөө аж ахуйн яам тариалангийн бүс нутагт нүүсэн нь бол зарчмын хувьд би буруу байсан гэж боддог. Тэгээд үнэндээ тариалангийн асуудлаа чухалчилж ингэж ийм үйлдэл хийснээрээ мал аж ахуйтай холбоотой бодлого алдагдаж байгаа нь энэ асуултуудаас, энэ хариултуудаас бол аль хэзээ харагдаад эхэлсэн байна. Тэгэхээр танаас асуух асуулт, Энхбаяр сайдаас асуух л асуулт бол нэг талдаа бол дотооддоо мах бэлтгэл эсвэл дотоодын махны хэрэгцээ хангахад бол аль болох үнийг хэт өндөр биш барьж хэрэглэгчээ бодсон тийм бодлого баримтлах, нөгөө талдаа экспортольё гэвэл аль болох өндөр үнээр экспортлох гээд энэ 2 хувьсагч чинь бол нэг нь доошоо үнийг дарж, нөгөөдөх нь үнийг дээшээ дарсан ийм хандлагатай хувьсагчид. Тэгэхээр энэ дээр та бодлогын зүгээс ер нь ямар тооцоолол, эдийн засгийн тооцоолол, судалгаа загварчлал хийж байгаа юм бэ. Энэ асуудалдаа шинжлэх ухаанч хандахад яаманд байгаа бодлогын нөөцөө ер нь хэр зэрэг зориулж, хэр зэрэг ашиглаж чадаж байгаа юм бэ гэдгийг чинь тодруулмаар байна.

2 дугаарт бол хэд хэдэн удаа сонслоо л доо. Энэ ХААИС-ийг ахиад яам руугаа татаж авах. Одоо магадгүй нүүлгэх. Байршлаас үл хамааран энэ боловсрол олгох процессыг яам руугаа татаж авна гэдэг нь өөрөө зарчим нь буруу юм. Тэгвэл Уул уурхайн яам ШУТИС-ийг харьяандаа аваад, Анагаахын сургуулийг ЭМЯ харьяанд аваад гээд энэ боловсрол олгох процессыг бүгдийг нь боловсролын төв байгууллагаас татаж холдуулах, угаасаа Засгийн газрын бүтэц зурагдахдаа шинжлэх ухааныг бас боловсролоос салгаж, анх удаагаа тэр нь энэ шинжлэх ухааныг нэг шоовдор байдалд оруулсан. Тэгээд эндээсээ болоод аливаа асуудалд ямар ч тооцоо судалгаагүй, шинжлэх ухаанч бусаар хандаж байгаа чинь ингээд үйлдэл болгон дээрээсээ тодорхой болж байна л даа. Тэгэхээр эхний ээлжид ямартай ч энэ бодлогын асуудлууддаа ямар байдлаар, ямар тооцоолол судалгаатай ханддаг юм бэ гэдгийг бодлого толгойлж байгаа хүнээс асуумаар байна.

Б.Бейсен: 6 номер. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Би тантай олон зүйл дээр санал нийлэхгүй байна. ХААИС-ийг яам авах асуудал биш, тэнд 15 мянган оюутан энэ салбарт бэлтгэгдэж байсан. Ийм хүний нөөцийн хэрэгцээ байсан тэр салбар өнөөдөр 3 мянга хүрэхгүй оюутантай, оюутныхаа дийлэнх нь өөр мэргэжлээр бэлтгэгдэж байгаа байдалд мэргэжлийн Байнгын хороо анхаарал тавиач ээ, салбар чинь боловсон хүчингүй болчихлоо. Таны хэлдгээр судалгааны сургууль болоод таны хэлдгээр ингээд хөгжсөн. Үр дагавар эсрэгээр гарчихлаа. Дээрээс нь ХААЯ-ыг бодлого гаргахад нь шинжлэх ухааны үндэстэй тусалж дэмжиж, зөвлөгөө өгөөд, хажууд нь байх ёстой шинжлэх ухааны байгууллагууд чинь мөн байхгүй болчихлоо. Тэгэхээр мэргэжлийн Байнгын хороо Их Хурал бодлого гаргаж, тэнд нь үүрэг даалгавар чиглэлээ өгөөч ээ, туслаач ээ л гэж би хүсээд байгаа юм.

Манайд юу байна. 120 төрийн албан хаагч байна. Тэгээд хувийн хэвшил байна. Тэд нар дээрээ л тулгуурлаж бид нар ажил үйл ажиллагаа явуулж байна. Нөгөө хүний нөөц, боловсон хүчний бодлого, шинжлэх ухааны бодлого чинь хаана яваад байна вэ гэдэг нь маш олон жишээ хэлж болно. Дараа нь би тэр тариалалт юман дээр.

Яам Дархан руу нүүсэн нь буруу гэж та үзэж байгаа юм байна. Монгол Улс 20 жил ярьсан шүү дээ. Төвлөрлийг сааруулъя. Төрийн захиргааны байгууллагуудыг нийслэлээс гаргая гэж л ярьцгаасан. Их Хурлын шийдвэрүүд гаргасан. Их Хурал ч шийдвэр гаргасан. Энэ буруу гэж үзэж байвал та санал гаргаад буруу гээд л надаа дахиад л Их Хурал шийдвэрээ гаргаад өг. Бид нар бол шийдвэр биелүүлдэг хүмүүс шүү дээ. Их Хурал нүү гэсэн. Нүүсэн. Буцаад ир гэвэл буцаад л ирье. Асуудал байхгүй шүү дээ. Яагаад төвийн бүс гээд байгаа юм. Яагаад бүсчилсэн хөгжил нь хөгжүүлнэ гээд байгаа юм. Төвийн бүс чинь манай хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чинь 70-90 хувь нь тэнд байна шүү дээ. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн чинь 90 хувь, аж ахуйнуудын чинь 90 хэдэн хувь нь, тариа ногооны чинь 90 хэдэн хувь. Тэр бүх бодлого хэрэгжих тэр тэжээлийн таримлын нөөц бололцоо, ургадаг биологи цаг уурын газар нь тэндээ байна л даа. Тэр газарт очиж байж тэр бодлогоо хэрэгжүүл гэдэг л үүрэг даалгавар Их Хурлаас өгөгдөөд л явж байна шүү дээ. Тэгээд тэрийг л биелүүлж байгаа. Буруу гэж үзэж байгаа бол та буруу гэдэг үндэслэлээ гаргаад, тэгээд асуудал оруулж болно.

Та үнэхээр өвөлжилтийн хохирол ярилаа. Амаргүй байна. Ингээд байлгаж байгаад тоо толгой хөөж аваад, жилдээ 8, 9 саяар нь байгаль дэлхийд өргөөд байж болохгүй байна шүү дээ. Тэрний цаана чинь маш их хохирол, малчдын амьдрал унаж байна. Иймд тэр хохирлыг даван туулахын тулд бид нарт тэжээл хэрэгтэй байна. Тэр тэжээлийн үйлдвэрлэл чинь энэ төвийн бүсэд чинь явж байна. Улаанбаатараас энэ 2-ын хооронд чинь томилолт аваад ажил явахгүй байна шүү дээ. Яг бүс нутагт нь очиж байж энэ эрчимжүүлэлтийг, энэ тэжээлийн тариалалтыг, энэ үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажилд яваад байна. Хуучин бодлогын яам байхад Нийслэл хотод суугаад бид нар бодлого хийгээд, цаас хийгээд байсан байхгүй юу. Би хэлсэн шүү дээ. Салбарын хяналт, салбарын үүрэг хариуцлага 100 хувь яамдуудад шилжсэн. Яамдууд чинь үйл ажиллагааны яам болоод хувирчхаад байна. Одоо байгаа бүтэц, төсөв чинь тэндээ хүрэхгүй байна. Яаманд хүч хэрэгсэл хэрэгтэй байна. Мэргэжлийн боловсон хүчин бэлддэг сургуультайгаа, дүн шинжилгээ гаргадаг хүрээлэнтэйгээ ингээд үйлдвэрлэлтэйгээ бодлого нэг цогц байгаад салбарын хяналтаа хэрэгжүүлэх ийм зайлшгүй байдал руу оруулчихсан байна шүү дээ Их Хурлын шийдвэр маань. Ингээд дутуу хийчихсэн. Ингээд салбар чинь доороо дэвхцээд эхэлж байна шүү дээ. Би тэрийг л хэлж байгаа юм.

Нэг бол төр бодлого гаргана гэвэл бодлогоо гарга. Тэгээд тэр хяналтынх нь чиг үүргүүд нь тусдаа байх ёстой байхгүй юу. Гэтэл тэр мах бэлтгэлээс авхуулаад л таны хэлдэг тэжээлийн асуудал, хяналтын асуудал, хүнсний аюулгүй байдлын асуудал бүх юм яаман дээр.../минут дуусав/

Б.Бейсен: Ундраа гишүүнд тодруулъя.

А.Ундраа: Надад бол асуулт алга. Зүгээр санал, коммент л нэмж хэлье. Ер нь бол яам тийшээ нүүсэн асуудал ч нэг их тэр тариалал, та өөрөө ямар тариалан хийх гэж байгаа биш. Та өөрөө тэжээл тарих гэж байгаа биш. Бодлого гаргаж байгаа үед төрийн захиргааны төв байгууллага нийслэл хотдоо байх нь өөрөө

Үндсэн хуулиараа бичигдсэн зүйл шүү дээ. Тэгэхээр тэрийг тайлбарлуулаад байх юу байх вэ.

2 дугаарт бол энэ бодлогоор зохицуулах ёстой асуудлууд бол үндсэндээ хийгдэхгүй байгаа юм байна. Шинжлэх ухаанчаар хандахгүй байгаа гэдгээ бас хэллээ. Тэгэхээр Засгийн газрын хувьд бол хүний нөөцөө бэлтгэх асуудал боловсролын асуудал чинь танай засаг шүү дээ. Нэг кабинетад байж байж яагаад өөрөө боловсролын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнтэйгээ энэ талаар Засгийн газар өөрөө шийдвэр гаргаад ажилладаггүй юм бэ.

Тэгээд мал аж ахуйн бодлого алдагдаж байгаа гэдэг нь бол би биш энэ олон гишүүд бас давхар давхар хэлж байна. Тэгэхээр энэ төрөөс нэгэнт татвараас мөнгө зарцуулж байгаа, төсвийн зарцуулалт хийгдэж байгаа бол үүгээрээ дамжуулаад худалдан авалт хийж, энэ өвөлжилтийн хүндрэлийг давж гарахад нь туслалцаа үзүүлэх ёстой юм.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Өдрийн мэнд хүргэе. Хүнс, хөдөө аж ахуйн яамны танилцуулга, мэдээллийг сонслоо. Хэд хэдэн бас саналууд хэлье. Өнөөдөр яах вэ, нөөцийн махтай холбогдолтой асуудлыг бид нар өнгөрсөн Засгийн газрын үед бол шийдвэрлэчихсэн байгаа. Тэгэхдээ ингээд хамт орж ирээд хамгаалаад яг хуучин шигээ явахаар болохгүй байгаад байна л даа. Тэгэхээр ер нь бол Хүнс, хөдөө аж ахуйн яам бодлогын хувьд бол нөөцийн мах бэлтгэх энэ ажлыг бол яг аймаг, шат шатны удирдлагууд нь хариуцаад, яам бол малчдын орлогыг нэмэгдүүлэх энэ чиглэл рүүгээ анхаарна гэдэг энэ бодлого цаасан дээрээ салсан боловч ингээд яг л хуучнаараа явж байгаа юм шиг ийм мэдрэмжүүд бас төрөөд байна. Өнгөрсөн хугацаанд бас нэлээн зоримог зоримог алхмууд хийсний 1 нь бас энэ байгаа. Тэгээд цаашдаа бол яг одоо нийслэл тухайлсан нийслэлийнхээ хүрээндээ л энэ асуудлаа яриад, ингээд үндсэн улсын бодлогод бол энэ мал, махны үнийг нэмэгдүүлэх чиглэл дээрээ анхаарлаа хандуулаад явах нь бол зөв шүү гэдгийг би бас хэлчихье.

Өнөөдрийн бид нарын хамгийн гол анхаарах тоо бол энэ өнгөрсөн 2023 онд экспортод бид нар 80,4 мянган тонн мах экспортод гаргасан. Нөхцөл байдлууд үндэсний хувьсгалын том хөтөлбөрүүд үргэлжилж байгаа. Хөдөө аж ахуйн салбарт томоохон хөрөнгө оруулалтууд нэмэгдэж байгаа. Энэ тоо буурах үндэс байхгүй. Уг үндсийн хувьд бол. Экспортын 1 цонхны системтэй болсон. Дахиад энэ аж ахуйн нэгж, үйлдвэрүүд мал төхөөрөх болон энэ чиглэлийн олон аж ахуйн нэгжүүд хөнгөлөлттэй зээлүүдэд хамрагдсан. Гол шалтгаан энэ 63,8 мянган тонн гэдэг энэ дүн өнөөдрийн байдлаар гарч байгаа юм байна. Одоо ингээд он дуусах гэж байна. Үсрээд 70 хүрэхтэй, үгүйтэй болох юм байна. Тэгээд энэ байдлыг цаашдаа улам эрчийг нь алдагдуулахгүй нэмэгдүүлэх энэ тал дээрээ ямар дүгнэлтүүд хэдүүлээ хийх вэ. Энэ дулааны аргаар боловсруулсан гэдэг 90 орчим хувь нь гэж тооцох юм бол 100 гаруй мянган тонн махыг бас бид бүхэн экспортод гаргасан ийм амжилттай байгаа. Энийг нэмэгдүүлэхгүй юм гэхэд ядаж бариад явах тал дээр анхаармаар байна.

Детальчлаад 2, 3 зүйлүүд байгаа. Бид нар 1997 оноос хойш Дэлхийн худалдааны байгууллагын нэг болж олон олон улсуудтай харилцаж байгаа. Яг Хүнс, хөдөө аж ахуйн энэ бүтээгдэхүүнийг экспортод гаргах чиглэлийн нэгж

боловсон хүчин, бодлого бол хаанаа яаж явах нь бас тодорхойгүй байгаа асуудал бас байгаа. Яам дээр байгаа гадаад харилцааны цөөхөн хэдэн хүн ажиллах хүчний одоогийн нөөц бололцоо бол энэ бүх улсуудын энэ протоколын хойноос, бүх улсуудтай хэлэлцээр хийгээд явж чадахгүй байгаад байгаа. Ковидоос хойш 2 жил тутам БНХАУ-тай хийдэг дэд сайдуудын энэ хэлэлцээр өнөөдрийг хүртэл хийгдээгүй байгаа. Энэ хэлэлцээр хийгдсэнээрээ малын түүхий эд бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн, яс, зөгийн бал гээд олон экспортод гарах боломжтой асуудлууд бас яригдах ёстой байгаа. Тэгээд .../минут дуусав/

Б.Бейсен: 6 номер хариулъя. Сайд.

Ж.Энхбаяр: Махны экспорт идэвхтэй байна. Тун боломжийн байна. Үнэхээр энэ зохицуулалтын арга хэмжээнүүд, хорио квот олголтыг тэглэсэн, зөвшөөрлийг 1 цонхны бодлогоор олгодог болсон гээд үнэхээр сайн буюу зах зээлийг идэвхжихэд их том үүрэг гүйцэтгэсэн. Тэгэхээр энийгээ барихын тулд бид нар 2 их том зүйл байна.

1 дүгээрт тасралтгүй нийлүүлэлтээ түрүүний хэлдэг тэжээл дээр суурилж яаж явах вэ.

2 дугаарт Мал эмнэлгийнхээ чадавхыг яаж сайжруулах вэ. Үнэхээр хийх ажил байна. Төсвийн хүрэлцээ, батлагдсан хэмжээ бага байна. Батлагдсан хэмжээ нь сая гэхэд л манай яам төсөв чинь 120-оод тэрбумаар хасагдаж байна шүү дээ. Энэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг идэвхжүүлэх яамны гол ажил бол гадаад харилцаа. Хөдөө аж ахуйн яамны ажлын бараг 50 хувь нь гадаад харилцаа байх ёстой. Гадаад зах зээл, тэр олон улсын гэрээ хэлэлцээрийг тохирох, тэр Засгийн газар хоорондын хэлэлцээрийг бэлтгэх гээд олон зүйлийг хийх ёстой. Харамсалтай нь Хөдөө аж ахуйн яам бол гадаад харилцаа хийх хэрэггүй гэж үзэж төсөв байхгүй байгаа шүү дээ. Боломж байгаад байдаг. Нөгөө талаар ажиллах тэр хөлийг нь тушчихаад, гуядаад байх хэрэг ийм л болчихоод байна л даа. Саяын төсвийн хасалт бол үнэхээр яаманд бол нэлээн үйл ажиллагааг нэлээн хумина. Зөвхөн баялаг бүтээж байгаа аж ахуйн нэгжүүд дээр очих 1 их наяд гаруй төгрөгийн зээл олгогдохоо болино гэсэн үг шүү дээ. Тэр зээл, хүүгийн бүх дэмжлэгүүд үндсэндээ нэлээн багасаж орж ирж байгаа юм. Харамсалтай л юм байгаа юм.

Тэгэхдээ яах вэ, байгаа хэмжээнд нь чамлахаар чанга атга гээд л ингээд л явцгаана. Тэгэхээр Байнгын хорооны дэмжлэг маш чухал байна. Би бодит байдлыг танилцуулна. Арга шийдэл дээр та бүхэн маань бас бодлого дээр гаргаач ээ. Зүгээр шүүмжлэхийн төлөө шүүмжлээд явахгүй шүү дээ. Нэг нь хамгаалаад нэг нь шүүмжлээд биш, тэгээд шийдэл нь юу байгаа юм бэ. Ямар шийдэл байна. Ингэж шийдье, ингэж урагшилъя, ийм бололцоог ашиглая гэдэг дээр л ярьж байвал илүү хэрэгтэй юм болов уу гэж боддог юм.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Тэгэхээр энэ экспортын тоо хэмжээ өмнөх оныхоос нэмэгдэж байна уу, буурч байна уу гэдэг дээр хэдүүлээ бас анхаарах ёстой юм байна. Шалтгаан юу байна вэ гэдгээ бас тодорхой болгоё. Байнгын хороогоор яг энэ хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдолтой асуудлыг нэлээн задалж, энэ дээр тодорхой шийдэл гаргаж ярья гэдэг энэ сайдын санал

бол маш зөв. Ингэж байж бид бүхэн энэ асуудлыг мэргэжлийн холбоодоороо дамжуулах юм уу, бусад энэ байдлаараа яаж явах юм бэ гэдгийг бол анхаарах нь зөв. Мал, махны бэлтгэхтэй холбогдолтой асуудал дээр бол энэ техникийн зохицуулалт чухал байгаа. 2025 оны 1 сарын 1 гэдэг том бас зорилт тавьчихсан байгаа. Энэ яах юм бэ. Хэдхэн хоногийн дараа техникийн зохицуулалт нь мөрдөгдөх юм уу. Одоогоороо бол сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хүрээнд бол явж байгаа. Ингээд 2025 оны 1 сарын 1-ээс дэлгүүр хоршоо орж ирэх ёстой.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Техникийн зохицуулалт буюу үйлдвэрлэлийн аргаар бэлдсэн мах, махан бүтээгдэхүүн нийтийн худалдаа, нийтийн хэрэглээнд очно гэсэн агуулгатай зохицуулалт. Энэ их сайн зохицуулалт. Эхлээд бид нар саяын хэлдэг цэцэрлэг, сургууль гээд нэвтэрнэ. Нэг үеэ бодвол иргэдийн маань худалдан авах хандлага их өөр болж байна. Ингээд том томоор нь авахаа биш, илүү бэлтгэсэн, ангилсан ийм мах руу орж эхэлж байна. Худалдааны сүлжээнүүд маань махны тасаг борлуулалтынхаа чанар стандартыг сайжруулж байна. Махны үйлдвэрүүд маань өөрөө яг энэ чиглэлээр ангилдаг, янзалдаг түгээдэг системүүд нь бий болж байна. Хамгийн гол өөрчлөлт гарч байгаа нь мал борддог, үйлдвэрт нийлүүлдэг ийм мал бордох аж ахуйн нэгжүүд олон арваар санаачилга гарч, бий болж байгаа нь их чухал. Ингээд бид ямар ч байсан алхам алхмаар энийгээ шахаад, шаардаад ингээд цаашдаа явна. Яах аргагүй уламжлалт баяр ёслол, Монгол цагаан сар, ууц тавих .../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Цагаан сарын хүрээнд яах аргагүй ууц, өвчүү гээд ингээд томоор нь тавьдаг, хэрэглэдэг нэг ийм соёл байгаа. Энэ хүрээнд бол бас зохицуулалтын арга хэмжээг хийгээд, тухайн үед нь бас өнөөдрийн идэш гэдэг арга хэмжээ шиг ийм маягаар нэг богино хугацааны арга хэмжээ хийгдээд, нийлүүлэлтийг хангаад явж бололцоотой болов уу. 1 сарын 1-ээс мөрдүүлнэ, шаардана, шахна. Ингээд алхам алхмаар дараа жилийн өдийд гэхэд нэлээн бодитой ахиц гарчихсан, ялангуяа иргэдийн хэрэглэж байгаа мах, махан бүтээгдэхүүний ариун цэврийн чанар, стандарт нэлээн сайжирчихсан ийм үр дүнтэй байх байх гэж бодож байна.

Б.Бейсен: Аубакир гишүүн асуулт асууя.

Т.Аубакир: Баярлалаа. 3, 4 асуулт байна. Энэ 2023 онд шийдсэн 1 цонхны үйлчилгээ одоо ажлаа хийж байгаа юу. 2023 онд миний бие мал, махны экспортын ажлын хэсгийг ахалж ажилласан. Энэ үед бас нэг яамнуудтайгаа, Засгийн газартай хамтарч байж гаргасан шийдвэрүүдийн 1 бол 1 цонхны үйлчилгээтэй байя. 7 төрлийн байгууллагаас 40 гаруй төрлийн бичиг баримт бүрдүүлдэг байсныг ХААЯ дээр төвлөрүүлээд, Ганхүлэг гишүүнийг дэд сайд байх үед бид хамтраад хийсэн нэг ийм ажил. Яг одоо энэ нэг цонхны үйлчилгээ үзүүлж байгаа бусад байгууллагуудаас авдаг олон төрлийн бичиг баримтыг ХААЯ дээрээс 1 цонхноос авдаг болгоё гэсэн шийдвэр гаргасан байсан. Энэ нэг цонхны үйлчилгээгээрээ ажиллаж эхэлснээс хойш яг хэдэн байгууллагад үйлчилсэн бэ. Энэ маань өөрөө эргээд мах экспортлогч хувь хүн болоод аж ахуйн нэгжүүдэд нэлээн тийм ажлыг нь хөөцөлдлөгөөг нь хөнгөвчилсэн ийм оновчтой ажил байсан. Яг энэ ажил үйлчилгээ хэвээрээ явж байгаа юу. Хэчнээн байгууллага үйлчлүүлсэн бэ. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуултад болохоор үхрийн мах квоттой байгаа. Хязгаартай. Өөрөө манай үхэр маань өөрөө нийт сүрэгт эзлэх хэмжээгээрээ, хэмжээнээсээ шалтгаалаад ер нь үхрийн махыг квоттой байлгая. Адуу, хонь, ямааны махыг бол ямар нэгэн квот хязгаарлалтгүйгээр экспортолдог байя гэсэн нь бол үр дүнд хүрсэн. Тийм ч учраас энэ 2023 оны сая гаргасан ХААЯ-ны танилцуулга дээр 2023 оны мах экспорт нэлээн сайн явсны 1 үр дүн нь бол энэ квотыг байхгүй болгосон. Тэгээд энэ үхрийн махны квот авах гэж хөөцөлддөг, хүн амьтнаар яриулдаг байдал чинь хэвээрээ байгаа юм биш биз дээ. Энэ дээр сайд маань яг яаж ажиллаж байгаа вэ. Бүс бүсэд нь шууд хуваарилаад л одоо тэр бүсийн мах экспортлогч нар маань шууд квотоо аваад л аймагт нь хуваарилсан квотоороо явчхаж байгаа юу гэсэн 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт маань эрчимжсэн буюу хагас эрчимжсэн чиглэлээр бүсчлэх маягтай. Хангайн бүс бол үндсэндээ эрчимжсэн мал аж ахуй, түүн рүүгээ чиглэсэн тэжээлийн ургамал тариалах ийм л чиг хандлагатай ажиллая гэснийг сая Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч бид нар ярьсан. Энэ хөтөлбөрийг нь бас батлаад өгчихсөн шүү дээ. Тийм учраас эрчимжсэн буюу хагас эрчимжсэн байдлаар ажиллахад 2018 онд гарсан Засгийн газрын тогтоол их чухал юм. Энэ газар тариалангийн бүс гэж хуваарилаад, түүнтэйгээ уялдуулаад малын хөлийн татварыг бид нар бас дээд хязгаарыг нь 2000 төгрөг гэж тавьж өгсөн шүү дээ. Энэ Засгийн газрын хөтөлбөртэйгөө уялдаад яг газар тариалангийн буюу эрчимжсэн хагас эрчимжсэн мал аж ахуйн эрхлэх бүсүүд дээрээ малын хөлийн татварыг 2000-д нь тулгаж тавих хүртэл асуудлууд яригдаж байсан. Бид нар энэ яг бүсчилж хуваарилахгүйгээр эрчимжсэн мал аж ахуй, хагас эрчимжсэн мал аж ахуйг ярих ямар ч боломж байхгүй. Эрчимжсэн мал аж ахуй нь нөгөө бэлчээрийнхээ мал аж ахуйдаа холилчихсон. Эрчимжсэн байдлаар ажиллаж байгаа тэр фермерүүддээ нөгөө бэлчээрийн мал аж ахуйн нь одоо тэр фермерүүддээ .../минут дуусав/

Б.Бейсен: Сайд хариулъя. 6 номер.

Ж.Энхбаяр: Төрийн 7 байгууллага, 54 төрлийн зөвшөөрөл олгогдож, тэгээд квот аваад махны экспорт ярьдаг байсан. Тэр цаг хойно хоцорсон. Одоо ямар нэгэн квот үхэр дээр ч байхгүй. Бүх төрлийн мал, мах чөлөөтэй гэрээ хэлэлцээр хийгээд, зах зээлээ олж чадсан аж ахуйн нэгжүүдийг 1 цонхны бодлогоор зөвшөөрлөөр дамжуулан экспортыг нь дэмжиж байгаа. Экспортын зөвшөөрөл авахад 2 цаг зарцуулж байгаа. Энд ямар нэгэн квот, хүндрэл, экспорт гэдэг юм байхгүй болчихсоныг та бүхэн анзаарч байгаа биз. Хамгийн их хэл ам дагуулдаг, авлига асуудал үүсдэг байсан. Энэ цэгцэрсэн. Энэ квотгүй байх бодлого 2025 оны 10 сар хүртэл үргэлжилнэ буюу энэ жилийн мал бэлтгэл ирэх онтойгоо хамт явна.

Яагаад гэвэл мал сүргийн тоог зохистой хэмжээнд авчрах зайлшгүй шаардлага байна. Үхэр дээр жоохон бодлого барьж байсан. Энэ гол экспортын гол массыг сарлаг үүрч байгаа тул бид квотын хязгаарлалтгүйгээр бүх талаар дэмжиж байгаа. Газар тариалангийн бүсийг тогтоосон ийм бодлого шийдвэр явсан. Хангалттай хэрэгжиж чадахгүй байгаа. Энэ таны яг малын хөлийн татварын дээд хэмжээг хязгаарласантай холбоотойгоор. Энийг мөн Байнгын хороо маань онцгой анхаараад, энэ хуулийн өөрчлөлтийг хийж өгөх зайлшгүй шаардлагатай буюу малын хөлийн татварын дээд хэмжээг тогтоох эрхийг нь орон нутгийн байгууллага өөрт нь хязгаарлалтгүй болгомоор байгаа юм. Энийгээ дагаад ялангуяа бүс нутаг болгон өөр өөр бодлогоо хэрэгжүүлнэ. Ялангуяа газар тариалангийн бүс нутаг буюу Монголын газар нутгийн 0,6 хувийг эзэлж байгаа нүдний цөцгий шиг хайрлах

ёстой тэр жоохон газар дээр бид нүүдлийн мал аж ахуйгаар талхалж байгаа, гишгэлж байгаа, тарьсан нийт таримлынхаа 20, 30 хувийг идүүлж байгаа байдал бол туйлын хариуцлагагүй бөгөөд байж боломгүй. Бидний яриад байгаа энэ экспорт хөгжлийн бодлого хангахад энэ бол шууд харшилж байгаа. Иймд тэр 0,6 хувьд нэлээн хатуу, нэлээн захиргааны тийм бодлогын өөрчлөлтийг хийгээд, тэнд байгаа мал аж ахуйг хагас эрчимжсэн, бүтэн эрчимжсэн ийм аж ахуйн хэлбэрт шилжихэд нь бүхий л санхүү, зээлийн бодлогоор бас бид дэмжиж байгаа.

Та малаа цөөл. Та малынхаа оронд сүүний, махны ашиг шимт мал аж ахуй, энэ хагас эрчимжсэн аж ахуй, тэжээл дээр суурилсан аж ахуйнуудыг хөгжүүл. Тэгэхгүй бол 3,5 сая хүний хүнсний аюулгүй байдал ноцтой байдалд орж байна. Тэнд мал бүхий 5 мянган иргэдийн асуудал биш, 3,5 сая ард түмнээ эрүүл аюулгүй хүнсээр хангах гол хүнс үйлдвэрлэж байгаа тэр бүс нутгийн таримал тэжээл, газар тариалангийн байдал бол туйлын амаргүй байгаа байдал байгаа. Энийг бол үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Тэгэхээр ахиад эрх зүйн орчин дээр Байнгын хороодоо бид нар танилцуулгын хүрээнд оруулна. Энийгээ бүгдээрээ ямар ямар хууль өөрчлөх хэрэгтэй байна, ямар ямар бодлогын өөрчлөлт хийх ёстой байна гэдгээ хамтдаа шийдээд, тэр арга хэмжээ дээр танилцуулъя.

Б.Бейсен: Аубакир гишүүн тодруулъя.

Т.Аубакир: Тэгвэл үхрийн мах ч гэсэн хязгаарлалтгүй болсон гэж ойлголоо шүү дээ. Ингээд үндсэндээ хонь, ямаа, адуу, үхэр бол хязгаарлалтгүй гарах юм байна. 5 хошуу мал. Энэ бол сайн л даа. Яах вэ, тэгээд энэ дээр 4 дэх асуулт маань малыг эрүүлжүүлэхгүйгээр мал, махны экспортыг ярих ямар ч боломж байхгүй л дээ. Тийм учраас ирэх жилүүдэд ХААЯ-аас мал эрүүлжүүлэх тал дээр яг ямар бодлого хэрэгжүүлэх гэж байгаа юу. Улсын төсөв хэлэлцэж байгаа үед малыг эрүүлжүүлэхтэй холбоотой хэдий хэмжээний төсөв суусан бэ гэсэн 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт нь, сүүлийн үед яригдаад байгаа энэ Евро Азийн худалдааны хэлэлцээрт нэгдэх тухай асуудал дээр яг ХААЯ-аас хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импорт, экспорт дээр яг ямар бодлого барьж байгаа вэ. Янз бүрийн мэдээллүүд хэвлэл мэдээллээр яваад байна л даа. Энэ дээр яг албан ёсоор та бас нэг өөрийнхөө байр суурийг хэлчхээч. Дотооддоо үйлдвэрлэж болж байгаа, чадаж байгаа, арай гэж босож ирж байгаа үйлдвэрүүдээ импортыг нь нэмэгдүүлээд унагаачих юм биш биз дээ гэсэн ийм болгоомжлолууд яваад байгаа. Ийм 2 .../минут дуусав/

Ж.Энхбаяр: Евро Азийн эдийн засгийн холбоотой 2 талын түр туршилтын гэрээ хийгдэхээр хэлэлцээр хийгдэж байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаж байгаа юм байна лээ. Манай яамны тухайд бол энэ их мөнгө, хөрөнгө, бодлого гаргаж хийж байгаа хүнсний аюулгүй байдлаа хангахын тулд энэ 19 нэр төрлийн 54 энэ вакцин, хүнсний үйлдвэрлэлийг бүх талаар өнгөрсөн 3 жил дэмжиж ирсэн. Энэ үйлдвэрүүдээ бид нар хамгаална. Энэ нэр төрлийн барааг тэр 300, 400 нэр төрөлдөө оруулж болохгүй шүү. Манай яам бол энийг тэр гэрээний нэг бүрэлдэхүүн хэсэг болгож болохгүй гэсэн ийм байр суурьтай байгаа. Энийгээ Хөгжлийн яам болон холбогдох ОХУ-ын талд илэрхийлсэн байгаа. Арай гэж босож байгаа бид жишээлбэл, зөвхөн өндөг дээр жишээлье л дээ. Бараг 95 хувь нь импортолсон өндөг өнөөдөр 80 хувь дотооддоо үйлдвэрлээд, дотооддоо хангаад

босоод ирж байна. Зөвхөн өндөгний үйлдвэр бий болохлоор Монгол Улсын газар тариаланд маш .../минут дуусав/

Б.Бейсен: Аубакир гишүүн тодруулъя.

Т.Аубакир: Энэ дээр малыг эрүүлжүүлэхгүйгээр нөгөө мал, махныхаа экспортыг хэдүүлээ ярих боломжгүй л дээ. Тийм учраас ирэх жилийн улсын төсөв дээр ирэх жилүүдийн малын эрүүл мэндтэй холбоотой яг ямар төсөв юмнууд суусан бэ. Энэ дээр манай Байнгын хороодын гишүүд ч гэсэн энэ ХААЯ-ныхаа мал эрүүлжүүлэхтэй холбоотой төсвүүдийг хэлэлцэх үед төсөв дээр дэмжих байх гэж найдаж байна. Яагаад гэвэл мал махны экспортыг хэдий бид нар дотооддоо 5 хошуу малыг экспортолно гэхихсэн боловч нөгөө хүлээн авагч улсууд маань бид нарт эргээд малын эрүүл ахуйн шаардлага тавьдаг. Манай Монгол Улсын мал, махны экспорт бол ганц унаж байгаа явдал маань энэ шүү дээ. Тийм учраас энэ төсөв дээр хэдий хэмжээний юм тавигдсан бэ.

Тэгээд с ярих юм их байна даа. Энэ хүрээлэнгийн асуудлууд байж байна. Яг материаллаг бааз, туршлага, боловсон хүчин нь байгаа яамнууд нь энэ хүрээлэнгүүдээ аваад явчихвал уг нь зүгээр. Одоо бүр сүүлдээ Эдийн засаг, хөгжлийн яам руу явчихсан юм уу. Өмнө нь Боловсролын яам дээр оччихсон байсан. Тийм учраас энийг бас ярих л асуудал.

Б.Бейсен: Энхбаяр сайд. 6 номер хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр төсөв хангалтгүй байгаа. Нийт шаардлагатай арга хэмжээний дөнгөж 20 хувь нь л чүү ай санхүүжиж байгаа. Тэгэхээр энэ талаар манай мал эмнэлгийн бодлого хариуцаж байгаа Болдбаатар яг тоо хэмжээтэй нь яриадахъя. Сая дахиад дээрээс нь тодотголоор бас нэлээн хасуулчихсан.

Б.Бейсен: 4 номер хариулъя. Уг нь төсөв дээр бас хэлсэн шүү дээ.

Б.Болдбаатар: Гишүүний асуултад хариулъя. Улсын төсвийн санал бол мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөлд өмнөх оныхыг бууруулахгүйгээр 69,9 тэрбум байхаар санал өгсөн. Энэ нь нэлээн хасагдчихсан. Энэ хүрээ маань өөрөө бид нар яг импортлогчийн тавиад байгаа худалдааны хоригтой бүх өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж байсан төсөв бол биш. Тухайлбал бид нар зөвхөн шүлхий гэхэд зөвхөн үхрээ жилд 2 удаа вакцинжуулаад л, үүгээрээ бид нар хаагаад яваад байдаг. Гэтэл импортлогч бол ерөөсөө бүх өвчлөмтгий 50 сая салаа туурайтнаа бүгдийг нь вакцинжуул гэдэг шаардлага тавьдаг. Тэгэхээр бид нар бол маш багахан хэсгийг нь вакцинжуулж байгаа. Бог малын мялзан гэхэд бид нар 27 саяыг төлөвлөөд, ерөөсөө 22 саяыг л вакцинжуулж хамгаалж байгаа. Тэгээд энэ жилийн төсөв бол нэлээн хасагдаж байх шиг байна. Тэгэхээр бид нар бол нэлээн хүнд байдалд орж байна.

Дотоодын халдварт өвчнөөс 19 нэрийн био комбинат үйлдвэрлэдэг .../минут дуусав/

Б.Бейсен: Мэндсайхан гишүүний асуулт асууя.

3.Мэндсайхан: Өнөөдөр мал, махны нөөц бэлтгэлийн асуудал ярьж байна л даа. Тэгэхээр Байнгын хорооны даргад ч гэсэн би бас санал хэлмээр л байна. Ер нь энэ мал, махны нөөцийн асуудлыг бид ярих ёстой биш байхгүй юу. Бид экспортыг хэрхэн нэмэгдүүлэх вэ, цаашдаа бид ямар бодлогоор энэ хөдөө аж ахуйн салбарыг дэмжих юм бэ гэдэг асуудлыг ярих ёстой болохоос биш өнөөдөр хэчнээн тонн мах бэлтгэж гэдгийг Хөдөө аж ахуйн сайдаас нэхээд сууж байх асуудал биш ээ. Хөдөө аж ахуйн сайдын хийдэг ч асуудал биш. Энэ малчин, мах бэлтгэлийн компани 2-ын л асуудал. Энэ дээрээ бас цаашдаа бид нар бодлогын хувьд өөрчлөлт хийж явах ёстой.

Ер нь зүгээр малын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Энхбаяр сайд аа, бид нар хамгийн том тулгардаг асуудал бол малын эрүүл мэндийн асуудал. Энийг бол бид нар жил бүр төсөвт сууж байгаа вакцины мөнгөөр шийдээд явж чадахгүй байгаа. Тэгэхээр энэ тусгаарлагдсан эрүүл бүсүүдийг бүс нутгуудад байгуулах асуудал маань ер нь яаж байна. Энэ Боомтын сайд гэж хилээр нэвтрүүлэх асуудлуудыг бүрэн хариуцаж байгаа Монгол Улсын экспортыг нэмэгдүүлнэ гээд яриад байдаг сайд байдаг. Үгүй ээ, тэгээд энэ сайдтай хамтраад энэ мал, махны экспортыг нэмэгдүүлэх чиглэл дээр ялангуяа тэр боомтууд дээр малын тусгаарлагдсан эрүүл бүсийг байгуулах асуудлыг шийдэж болохгүй юу. Энэ дээр хамтраад ажиллах хэрэгтэй байна гэж үзэж байна.

Нөгөө талдаа бид нар махны техникийн зохицуулалтыг 2 жилийн өмнө, 3 жилийн өмнө баталсан. Энэ төв суурин газрын иргэд маань эрүүл ахуйн шаардлага хангасан махны хэрэглээтэй байх ёстой. Энэ үйлдвэрийн зохицуулалт байх ёстой. Тэгэхээр энэ дээр үйлдвэрүүд маань 2025 оны 1 сарын 1-ээс эхлээд хэрэгжээд эхлэхээр Улаанбаатар хот, аймгуудад нийлүүлэгдэх махыг боловсруулах тэр үйлдвэрүүдийн маань хүчин чадал бэлэн үү. Энэ дээр яам маань хэрхэн анхаарч байна. Иргэдийнхээ эрүүл хүнс хэрэглэх тал дээр.

Эрчимжсэн мал аж ахуйг бид нар газар тариалангаа хөгжүүлээд, бүс нутагтаа дагуулаад шийднэ гээд бодлого гараад явж байгаа. Мөн ялгаа байхгүй эрчимжсэн мал аж ахуй бол Дархан, Сэлэнгийн төвийн бүсэд л бий болно. Гэтэл цаана чинь бэлчээрийн мал аж ахуй маань тоо толгой нь нэмэгдэж байна гээд сая Их Хурлын гишүүд ч хэлээд байна. Бэлчээрийн даац дийлэхгүй байна гээд. Энэ бүгдийг шийдэх асуудал ерөөсөө л экспортын асуудал шүү дээ эргээд. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ тэр тусгаарлагдсан бүсүүдийн асуудлаа илүү түлхүү гаргаж ярих ёстой гэж би бодож байна. Энэ дээр ямар асуудал гаргаж ирэх гэж байна.

Мөн тэр малын мөшгөх систем маань хэрэгжилт хэр байгаа вэ. Бид мал, мах үнэтэй байна, хямдхан байна гэж ярихаас илүүтэй, хүнсний аюулгүй байдал буюу мал, махны маань эрүүл ахуйн шаардлага яаж хангаж байна. Гарал үүслийн асуудал гэдэг дээрээ түлхүү анхаарах юм бол энэ экспорт чинь явчихна.

Сүүлд, төгсгөлд нь хэлэхэд энэ хүрээлэнгийн асуудал дээр Энхбаяр сайд аа, дараагийн Байнгын хороо дээр саналаа оруулж ирээч гэж хүсмээр байна танаас. Энэ асуудлыг би сайдаар ажиллаж байхдаа Байнгын хорооноос бас тогтоол гаргаад, яаманд шилжүүлнэ гэсэн тухайн .../минут дуусав/

Б.Бейсен: Мэндсайхан гишүүнд 1 минут олгоё.

З.Мэндсайхан: Хүрээлэнгүүдийн асуудал огт шийдэгдэхгүй яваад байгаа. Тэгэхээр Байнгын хороо энэ дээр бас асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн яамд нь харьяалуулах чиглэл дээр нь дэмжиж ажиллах ёстой гэж бодож байгаа. Энэ яам чинь 1990 оноос хойш шинжлэх ухаан дээр суурилсан бодлогогүй яваад ирж байгаа. Яамны төрийн захиргааны албан хаагч нар ажлынхаа хажуугаар яамны эрдэм шинжилгээний ажлыг хийнэ гэдэг ийм ойлголт байхгүй шүү дээ. Тэгээд тэр хүрээлэн нь очоод өөр газар төвлөрчихсөн. Одоо Эдийн засгийн яам руу явчихсан юм байна. Тийм ээ. Тэнд очоод хүрээлэнгийн төсөв дээр тавьдаг эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл гээд ингээд байж байдаг. Тухайн салбартайгаа уялдаатай юм огт байхгүй. Тэгээд салбар нь өөрийнхөө суурь шинжилгээ, судалгааны ажлаа хүрээлэндээ биш, өөр газруудаар захиалга өгч хийлгэдэг ийм байдал руу орох гэж байна шүү дээ. Тэгээд энэ асуудлуудыг бид нар цэгцлэх ёстой. Тэгээд би асуултаа асуухдаа тодруулчихъя.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Мэндсайхан гишүүн ээ, та манай салбарыг удирдаж байсан сайд хүн. Үндсэндээ асуудлыг сайн ойлгож, бидний санаа бодол, хийх ажил нэг байна. Үнэхээр экспортыг хийхийн тулд байгаа төсвийн хүрээнд бид нар Монгол Улсаа тэр чигт нь 100 хувь эрүүлжүүлэх бололцоогүй байгаа ийм үед бид хамгаалагдсан бүс, тусгаарлагдсан бүс, хамгаалагдсан аж ахуй, тусгаарлагдсан аж ахуй, тэр дээрээ тулгуурласан экспортын нийлүүлэлтийг хангах гэдэг ийм зүйлийг хийхээс өөр аргагүй байдалд байгаа. Тэгэхээр бид хэд хэдэн хувилбаруудыг бэлтгэсэн. Дахиад гишүүдийг очиход энийгээ нэг ярина. Энэ дээр бас эрх зүйн зохицуулалтууд, нэлээн дэмжлэг, хэрэг болох нь. Яагаад гэвэл хамгаалагдсан, тусгаарлагдсан бүс үүсэхээр тэр бүс рүү орж байгаа мал, амьтны хөдөлгөөн нэлээн хяналттай, хязгаарлалттай болж хувирна. Энэ маань бас өөрөө нийгмийн зарим хэсгийн эрх ашигт хөндөгдөнө. Ялангуяа манай нөгөө баяр наадам, адуу мал зөөдгөөс авхуулаад, нөгөө тусгаарлагдсан эрүүл бүсэд маань өөрөө гаднаас халдварт өвчин тээгдэх боломж үүсдэг тул үүнтэй холбоотой нэг юм ярина. Ингээд мөшгөх системтэй холбоотой манай мал эмнэлэг хэрхэн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг малчны хотноос нь авхуулаад яаж орон нутгаас үйлдвэрлэл хооронд нь мөшгөж экспортод хүргэж байгаа талаар. Энэ систем бол нэлээн боловсронгуй болоод нэлээн олон улсын түвшинд бид нар хүрч чадсан ийм систем мөрдөгдөж байгаа. 4 номерын микрофон өгөөч Болдбаатар дарга.

Б.Бейсен: 4 номерын микрофон хариулъя.

Б.Болдбаатар: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Мөшгөх систем маань нэлээн сайн идэвхтэй явж байгаа. Мөшгөх системээр малчны хотноос бэлтгэгдсэн мал үйлдвэрт нядлагдаад, мах нь нөгөө нэг цонхны системээр ороод яг экспортод явахад бол яг 100 хувь мөшгөлтийнхөө системээр явж байгаа. Өнөөдрийн байдлаар зөвхөн зах зээлд нийлүүлэгдсэн 300 мянган тонн маханд бол яг энэ мөшгөх системээр анхан шатын гарал үүслийн гэрчилгээ олгогдоод явсан байна. Өөрөөр хэлбэл малчны хотонд өөрсдөд нь хэрэглэгдэж байгаагаас бусад зах зээлд гарч байгаа бүх мах, махан бүтээгдэхүүнд болбол 100 хувь хэрэгжээд явж байгаа.../минут дуусав/

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулъя гэж байна.

З.Мэндсайхан: Махны техник зохицуулалт бол энэ ААН-үүд чинь бэлэн үү. Төв суурин газрын иргэд чинь үйлдвэрийн аргаар бэлтгэсэн эрүүл ахуйн шаардлага хангасан мах, хүнсэндээ хэрэглэхэд та бүгд маань бэлэн байдлыг хангаж чадсан уу.

2 дугаарт Боомтын сайдтай хэрхэн хамтарч ажиллаж байна. Тэр тусгаарлагдсан эрүүл бүсийг хийхгүйгээр бид нар экспортыг нэмэгдүүлнэ гэж байхгүй шүү дээ. Одоо гишүүд байнга л яриад байгаа. Хувийн хэвшлийн хийх ажлыг яам хийх гээд байна гээд байгаа. Тэгэхээр салбарын яамны хийх ажил бол ерөөсөө л бодлого гаргах шүү дээ. Тийм ээ. Энэ эрүүл бүсийг хийх эрх зүйн орчин болон боломжийг нь бид нар бодлогын хүрээнд яаж гаргаж өгөх гээд байна. Энэ боомттой хамтраад энэ эрхэлсэн сайдтай болчихсон шүү дээ. Боомтын асуудал хил нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ. Монгол Улсын экспортыг нэмэгдүүлнэ гээд бүхэл бүтэн нэг салбар удирдаж байгаа сайд байгаа. Тэгээд үүнтэй Энхбаяр сайд маань хамтарч ажиллаач ээ. Энэ асуудлыг хурдан оруулж ирэх хэрэгтэй байна.

Б.Бейсен: Үг хэллээ. Түрүүчийн техникийн зохицуулалтын талаар 5 номер.

Г.Довчинсүрэн: Гишүүний асуултад хариулъя. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, худалдааны техник зохицуулалт 2023 оны 1 сарын 1-ээс сургууль, цэцэрлэг болон хүүхдийн хоол үйлдвэр, үйлчилгээ, эмнэлгийн хоол үйлдвэр, үйлчилгээнд бол үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүн хэрэглэнэ гэж заагдсан. Яг энэ хэмжээгээр бол явагдаж байгаа. Яг энэ дээр бас 2025 оны 1 сарын 1-ээс бүх нийтийн хоол үйлдвэрлэлийн худалдаанд ерөөсөө үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүн байна гэж заагдсан. Тийм учраас яг энэ төхөөрөх үйлдвэрийн хүчин чадал нэлээн бага байгаад байгаа. Та бас мэдэж байгаа байх. Нийтдээ бол бог мал 75 мянган толгой хоногт, бод мал гэхэд 14 мянган толгойг бол яг төхөөрөх 150 орчим төхөөрөх үйлдвэрүүд бол байна. Тэгээд энэ нэг асуудлууд байгаа. Тэгээд энэ асуудлын хүрээнд бол хүнсний хувьсгалыг хэрэгжүүлэх хүрээнд хөнгөлөлттэй зээл олгож байгаа. Энэ хүрээндээ болохоор төхөөрөх үйлдвэрүүд дээр нэлээн зээлийн бодлогоор бол дэмжиж явж байгаа. Яг энэ хүрээндээ бас нэлээн тэр хуучин байсан асуудлыг бол 2024 онд төхөөрөхийн хүчин чадлууд бол бас нэлээн нэмэгдэж орж ирж байгаа. Тийм учраас одоо яг энэ 2025 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлэхэд бол ер нь бэлэн гэж л үзэж байна.

Б.Бейсен: Гишүүд мэдээлэлтэй холбоотой асуулт асууж, хариулт авч дууслаа. Мэдээлэлтэй холбоотой үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна.

Тэгэхээр энэ дээр нэг юм тодруулаад бас хэлээд явчихъя. Сая Энхбаяр сайд ч ярьж байна. Зарим гишүүд ч ярьж байна. Салбарын сургуулийг салбарын яамд нь өгөх асуудал байгаа. Тэр ХААИС, АШИУС-ийн сургууль байж байгаа. Тэрэнтэй бол захирагдахгүй яамандаа захирагддаггүй олон хувийн сургууль бий болсон гэх мэт асуудал байна. Энийг бас дараа нь тусад нь гишүүд санал гаргаад ярихгүй бол ер нь энэ 2 салбар бол нэлээн хүнд байдалтай байгаа шүү гэдгийг та бүгдэд бас сонордуулаад хэлчихье.

12.31 цаг.

Дараагийн асуудал. 2025 оны төсөв асуудлыг хэлэлцье. Ажлын хэсгийг оруулъя. Сангийн сайдыг дуудаарай.

2 дугаар асуудал. **Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг хэлэлцэнэ.**

Сангийн сайдыг иртэл ажлын хэсгээ танилцуулж байя.

Жавхлан Сангийн сайд, Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас. Оюунсанаа Ойн газрын дарга, Оюунжаргал ЦУОШГ-ын дарга, Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн дарга, Батцогт Тусгай хамгаалалттай газрын бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Нямхүү Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Мөнхтогтох Салбарын хяналтын газрын дарга, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас. Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилт зохицуулалтын газрын дарга, Тулга Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга.

Сангийн сайд Сангийн сайд манай Байнгын хороог хүндлэхгүй байгаа юм уу. Өглөөнөөс хойш хүлээлээ шүү дээ. Яагаад хүнд суртал гаргаад байна. Энхбаяр сайд. Одонтуяа сайд танилцуулах юм у. Засгийн газрын гишүүнд танилцуулж болох заалт байгаа биз дээ. Байнгын хорооны дэг зөрчинө гээд юм ярьж байна. Тэгэхдээ энэ Засгийн газрын гишүүн танилцуулж болно гэсэн заалт байгаа билүү. Байхгүй. Сангийн сайд танилцуулна л гэсэн дэг байгаа. Одонтуяа сайд танилцуулна

С.Одонтуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан боловч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж дахин өргөн барьсан. Төсвийн төсөлд зардлыг бууруулахад дараах зарчим баримтлав.

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад 1 удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос төсвийг нь хянаж жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн шүүхийн байгууллагууд болон Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагуудын урсгал зардлыг тус тус бууруулахгүй.

2. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-100 хувь бууруулна.

А. Салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь бууруулах,

Б. Соёлын эрхийн бичиг, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино урлагийг дэмжих сан, Засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулах,

В. Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал, Төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатын төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл, худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулах.

Улсын төсвийн хөрөнгөөр шинээр гүйцэтгэх геологийн хайгуул, судалгааны ажлын зардлыг 50 хувь бууруулах. Дээр дурдсан 50-100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан, ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгана.

4.Гэрээ байгуулаагүй, ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж хойшлуулна.

5.Зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойшлуулна.

6.Гадаад зээлийн ашиглалтыг бууруулж хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг хойшлуулна.

7.ХСҮТ 2 хөрөнгө бууралтыг нэмж тусгалаа.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394,8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн дүн 33,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35,2 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35,2 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл ДНБ-ий 3,3 хувийн ашигтай болохоор байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Сангийн сайдын мэдээллийг танилцуулсан Одонтуяа сайдад баярлалаа. Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2005 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч Самбууням танилцуулна. Загджав гуай чөлөө авсан байгаа. 3 номер.

Я.Самбууням: Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн, аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй,

алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр бүхэлд нь хориг тавьсан нь ач холбогдолтой болсон байна.

Иймд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, дахин өргөн барьжээ.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод нийцсэн эсэхийг хянаж дүгнэлт гаргахад чиглэсэн болно.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн төвлөрүүлэх орлогыг 49,2 тэрбум, зарлагыг 726,2 тэрбум төгрөгөөр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн төвлөрүүлэх орлогыг 2,3 тэрбум, төсвийн зарлагыг 309,4 тэрбум төгрөгөөр тус тус төсөвлөжээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй байна.

1 дүгээрт. Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл, уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай байна.

2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

3. Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэйд тооцож үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4. Төсвийн урсгал зардал, зарлагыг хумьж, зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын ДНБ-д эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 оны төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг хумих эрсдэл үүсэх магадлалтай байна.

5. Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна.

6. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн

этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно гэж тусгасан нь Улсын Их Хурлын Засгийн газарт тавих хяналтыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлсэн бусад хуультай нийцэхгүй байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Бейсен: Хуулийн төсөлтэй холбоотой аудитын дүгнэлт танилцуулсан Самбууням аудиторт баярлалаа.

Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн байгаа. Сая танилцуулсан хуулийн төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Отгонбаяр гишүүнээр тасаллаа. Отгонбаяр гишүүн асуулт асууя.

У.Отгонбаяр: Байгаль орчны сайдын багцаас нэг ганц нэг зүйл тодруулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцаас. Энэ дээр тэр Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төсөл гээд 1 дүгээр төсөл нь бол маш амжилттай хэрэгжсэн. 2 дугаар төсөл 2024 онд 3 тэрбум төгрөг тавиад явж байсан. Эндээс миний харж байгаагаар энэ пропорцлоод 10 хувиар хасчихсан юм шиг байна. Энэ 3 тэрбум төгрөгийн энэ бол нэг их тийм айхтар том дүн биш шүү дээ. Энэ дээр заавал энэ 10 хувь гээд 200 гаруй сая төгрөгийг нь хасах зайлшгүй бас шаардлага байсан юм уу. Эхний 2024 онд тавигдсан 1,5 тэрбум, үлдсэн 2025 онд 1,5 тэрбум гээд 2 хувааж л хэрэгжих мөнгөн дүн нь тавигдсан юм уг нь. Тэгээд энэ чинь нэлээн ажлууд төлөвлөчихсөн, нэлээн нарийн календарьчилсан төлөвлөгөө гарчихсан уг нь яваа юм.

Би бас өнгөрсөн намар Дарьганга сумд ажиллаад, энэ Ганга нуур дээр яг энэ жилийн энэ 2 дугаар төслийн хүрээнд хийгдэх ажлуудыг нь бүр нэг бүрчлэн нарийн үзсэн юм. Тэгээд нарийвчлаад нэлээн төлөвлөгөө зоочихсон байсан. Тэгээд энийг бас сайдын багц дотроо зохицуулаад, энийг 3 тэрбум болгоод гүйцээчих ийм боломж бололцоо байдаг юм болов уу. Тэрнээс биш энэ тэрний өөр ажлуудаас бас татахад бол 200 хэдэн сая төгрөг бол бас арай л болов уу гэж би бодож байна. Тийм учраас энийг Одонтуяа сайд та бас өөрийнхөө багцад зохицуулаад, энэ 3 тэрбум төгрөгийг нь гүйцээчих ийм боломж байна уу.

Б.Бейсен: Байгаль орчны сайд хариулъя. 5 номер.

С.Одонтуяа: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр манай салбарт энэ жил хөрөнгө оруулалт бол бараг тавигдаагүй гэж хэлэхэд болохоор ийм байгаа. Энэ Ганга нуурын бохирдол дээр бол уг нь 2,7 гэж батлагдсан байсан. Сая бол хасагдаад 2025 онд санхүүжих дүн нь 1,2 болоод ороод ирчихсэн юм. Тэгэхээр та 2025 онд санхүүжих дүнг нь нэмэгдүүлье гэж байна уу. Эсвэл нийт төсөвт өртгөө яая гэж байна уу. Тэгэхээр энэ 2025 онд бол ерөөсөө 1,2 санхүүжих дүн нь байгаа. Тэгэхээр энэ 2025 онд 1.2-оор л санхүүжүүлээд, тэгээд харъя л гэж бодож байна.

Тэгээд ер нь бол энэ манай энэ төсвүүд сая та бүхэн мэдэж байгаа. Маш яаралтайгаар орж ирээд, тэгээд бүх зүйлүүдээс л ер нь тэгшитгээд л нэлээн хасчихсан байгаа. Тэгэхээр зөвхөн Ганга нуураас биш бусад бүх төслүүдээс бүгдээс нь л хасагдчихсан орж ирсэн.

Б.Бат-Эрдэнэ: Ухнаагийн Отгонбаяр гишүүн тодруулж асууя.

У.Отгонбаяр: Уг нь 2025 онд бол 1,5 тэрбумаар л санхүүжигдэх ёстой юм. Уг нь энэ Ганга нуурын асуудал бол өөрөө маш чухал асуудал шүү. Зүүн бүсийг бол түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болгосон. Ганга нуур, Алтан-Овоо, Шилийн богд, Талын агуй гээд энэ түүхэн аялал жуулчлалын маршрутад бол орсон ийм газар. Одоо жишээ нь 2015, 2016 оны үед Ганга нуур бол бүр гамшгийн хэмжээнд очсон шүү дээ. Ширгээд, мал ороод, бүр үгүй болох хэмжээнд очсон. Харин тэр үед Засгийн газрын нөөц хөрөнгөөс тодорхой санхүүжилтийн асуудлыг нь шийдэж, энэ асуудлуудыг нь үе шаттай төсөл хэрэгжсэний улмаас өнөөдөр бол бас эвтэйхэн хэвийн хэмжээнд очсон байгаа. Гэхдээ одоо энэ 2024, 2025 онд энэ төслөө дуусгаад, тэр хашаа хороо татаад, элсний нүүдлээс ... /минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: Отгонбаяр гишүүн санал хэллээ. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя. Тодруулга өгөх юм уу. Санал хэллээ гэж ойлголоо шүү дээ. Одонтуяа сайд 5 номер.

С.Одонтуяа: Тэгэхээр Отгонбаяр гишүүн ээ, энэ Ганга нуурын төсөл бол үнэхээр бас амжилттай хэрэгжсэн төсөл бол яах аргагүй мөн гэж салбарынхан ярьж байгаа. Тэгэхээр энэ ердөө 200 хэд л 2025 оныхыг нь хийвэл яг төсөл нь бүрэн дуусах гээд байгаа юм байна. Энийг нь би тантай ярьж байгаад аль болохоор зохицуулалт хийж өгье.

Б.Бат-Эрдэнэ: Салдангийн Одонтуяа сайдад баярлалаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Төсвийн төсөлтэй танилцсан. 2, 3 асуулт байна.

1 дүгээрт энэ хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд. Мал эмнэлгийн энэ хөдөө аж ахуйн салбарын төсөв танагдсанаар ер нь мал эмнэлгийн салбарт энэ тарилга, Био комбинат гээд ингээд малаа эрүүлжүүлэх, махаа үнэд хүргэх, хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүнээ экспортлох гол хүчин зүйлүүд болоод байгаа энэ салбарын хөрөнгө оруулалтууд бас хэр танагдаж байгаа вэ. Зүгээр тоон үзүүлэлтээрээ харахад бол өнгөрсөн 2024 оны үзүүлэлтээс бол нэг их айхтар багасахгүй. Гэхдээ тодотгол энэ тэртэй нэмэгдсэн зардлаасаа бол хассан ийм дүр зурагтай харагдаж байгаа юм. Тэгэхээр Байнгын хорооны гишүүд Хөдөө аж ахуйн яам, энэ Мал эмнэлгийн ерөнхий газар дээр очиж ажиллахад мал эмнэлгийн салбарт бас нэлээдгүй зүйлүүдийг хийхээр төлөвлөж байгаа гэж ингэж бас ярьж байсан. Тэгээд тэр төлөвлөж байгаа ажлыг хийх, хэрэгжүүлэх энэ төсөв хөрөнгө ер нь ямархуу багцаатай болж байна вэ. 1 дүгээрт.

2 дугаарт Зүүн бүсийн Мал эмнэлгийн төв лаборатори Хэнтий аймагт байгуулна гэдэг зүйл аль 2021 оноос хойш л яригдаад л байгаа, яригдаад л байгаа. Үүний үйл явц бас ямар байгаа вэ гэдэг ийм 2 асуулт байна.

Энэ хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд дээр аудитын тайланг бас сонслоо. Хэнтий аймгийн төв Хэрлэн сум, Хэрлэн голын хөвөө дээр 700 га дээр усалгааны систем хийнэ гэж Азийн хөгжлийн банкнаас 5,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх, Жинсийн овоо гэдэг компани өнөөдрийг хүртэл олигтой хийсэн юм байхгүй ингээд явж байгаа. Гэрээ байгуулаад, хугацаа нь дуусчихсан. Энэ дээр яам тэр сонгон шалгаруулсан компаниа шахаж ажиллуулах, ажлыг нь дуусгах, хүлээж авах энэ тал дээр та бүхэн ямар бодолтой байна вэ гэдгийг бас би асууя.

Дараагийн ээлжид нэг зүйлийг бас онцгой асууж, хэлэхийг хүсэж байгаа юм. Яагаад гэхээр энэ төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлууд дээр би өмнө нь ч бас Байнгын хороон дээр хэлж байсан. Хөрөнгө шаардахгүйгээр зүгээр бодлогоо хэрэгжүүлэхэд хууль, эрх зүйн орчныг сайжруулах ийм зүйлүүд ер нь ХААЯ-аас юу гарч байна. Ялангуяа энэ зүүн бүсийн малчдын ярьдаг зүүн бүс бол Монголын хөдөө аж ахуйн салбар, ялангуяа бэлчээрийн аж ахуйн отрын бүс нутаг болчихоод байгаа шүү дээ. Тэгээд маш их хэмжээний мал отроор орж ирдэг. Тэгээд тухайн орон нутагтаа 1 ч төгрөгийн татвар төлдөггүй ийм сөрөг зүйлүүд маш их гардаг. Тэгээд иргэд, олон нийттэй уулзахад ядаж бид нар тэр отроор ирсэн хүмүүсээс, малчдаас малын хөлгийнх нь татварыг нутагтаа авдаг болмоор байна гэдэг зүйлийг бас олон жил ярьж байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ ХААЯ-ны газрын дарга нар та бүхэн бас олон жил ажиллаж байгаа хүмүүс. Энэ тал дээр ер нь ямархуу санал санаачилга гаргаж үзэв. Энэ өнөөдрийн 2025 оны төсөв дээр дагасан хууль юмнууд дээр ийм зүйлүүд бас байна уу гэдэг дээр би нэг тодорхой хариулт авъя гэж бодож байна. Баярлалаа

Б.Бат-Эрдэнэ: Идэрбат гишүүнд баярлалаа. ХХААХҮЯ-аас хэн хариулах вэ. 6 номер. Жадамбын Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр улс орны хэмжээнд малын хөдөлгөөн нэлээн замбараагүй байгаа. Энийг зохицуулахад малын хөлийн татварыг, энэ тухай зохицуулсан хуулийг өөрчлөхгүйгээр явахгүй нь тодорхой. Тэгэхээр хуулийн төсөл үндсэндээ бэлэн болж байгаа. Байнгын хорооныхоо гишүүддээ өгнө. Ингээд та бүхэн маань өргөн барих талд нь дэмжлэг үзүүлээрэй. Тэгэхгүй бол нөгөө газар тариалангийн газар, мал аж ахуйн хоорондын зөрчил, ингээд нутаг оронд их хэмжээний мал очиж газар нутгийг талхилдаг асуудал, тэгээд отрын бүс нутгийн зохион байгуулалт, зохицуулалт, хөрөнгө оруулалт гээд олон зүйлүүд ер нь энэ хуультай холбоотойгоор жоохон зохицуулалт сул яваад байгаа.

Мал эмнэлгийн ерөнхий газрын төсөв 69 тэрбумаас 61 буюу нийт 8.9 бараг 9 тэрбум төгрөг хасагдсан. Энэ хэмжээний вакцин тарилга дутуу хийгдэнэ л гэсэн үг. Энэ хэмжээний мал эмнэлгийн үйлчилгээ багасна л гэсэн үг буюу тэгшитгэн хассан 10 хувийн хүрээнд л ингээд хасагдаад явж байгаа. Тэгэхээр улам л бид нар нөгөө малын өвчинтэй тэмцэх тактикаа улам нарийсгах, тэр голомт бүс нутаг, тэр хүрээ цээрийн тогтоох юмнуудаа л тодорхой хэмжээнд хязгаарлахаас аргагүй жоохон юмнууд гарна. Гэхдээ яах вэ байгаа хүрээндээ ингээд зохицуулаад явна. Ер нь цаашдаа экспорт хийе гэвэл малаа эрүүл байлгаж байж л явна. Энд бол иж бүрэн 3-5 жилийн цогцолбор хөтөлбөр Био комбинатын иж бүрэн шинэчлэл гэсэн ийм бодлогыг бид нар шийдэж байж ер нь цаашдаа тогтвортой экспортоо хангах байх.

Хэрлэн дэх 700 га Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн явцын талаар 7 номер дээр микрофон өгөөд, манай бодлогын газар яг энэ төслийг хариуцсан нэгжийн удирдлага Болорчулуун хариу хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Болорчулуун даргыг 7 номерын микрофонд урьж байна.

Ц.Болорчулуун: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Тэр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр нийт 42 сая долларын санхүүжилтээр 12 байршилд 7 мянган га-ийн услалтын систем байгуулах ажил яваад одоо 3 дахь жил рүүгээ орж байгаа. Энд бол Хэнтий аймгийн Дулааны талд бол Жинсийн орой гээд компани гүйцэтгэгчээр ажиллаад, энэ услалтын систем байгуулах ажил дээр бол ажиллаж байгаа. Нийт ажлын явц нь болбол 56 хувьтай гэж гарсан. Энэ ажил дээр услалтын системийн гүйцэтгэлд бол Барилга захиалагчийн төвөөс бол хяналт тавьж, манай төслийн нэгжтэй яамтай гэрээ байгуулаад, хяналт тавиад ажиллаж байгаа. Энэ жилийн тухайд бол ажил нь төдийлөн яваагүй. Ялангуяа цахилгааны ажил бол эхлээгүй. Энэ нь бол толгойн барилгыг барьж байгуулахад энэ жил үер ус ихтэй байснаас болоод энэ ажил нь явагдаагүй. Тэгэхдээ энэ дээр бол бид нар тодорхой гэрээг нь сунгаад, ирэх жил энэ ажлыг шахаж дуусгах тал дээр бол ажиллаж байгаа гэдгийг бас хэлье. Хэрвээ бид нийтдээ энэ төслийг амжилттай хэрэгжүүлээд 700 га-ийн услалтын системийг барьж байгуулснаар тэнд .../минут дуусав/

Б.Бейсен: 3 номер нэмж хариулъя. Аудит.

Я.Самбууням. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар биш, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа учраас яам нь хариулна. Манай дээр энэ үзэгдээгүй.

Б.Бейсен: Болорчулуун дарга гүйцээж хариулъя.

Ц.Болорчулуун: Төсөл хэрэгжсэнээр тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ногоочдын асуудал бүрэн шийдэгдэх ийм боломжтой гэж харж байгаа. Анх бол Азийн хөгжлийн банкны гаргасан судалгаа хийгдээд, энд бол төрийн болон орон нутгийн өмчтэй энэ газар дээр энэ төслүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн ийм судалгаа гарч, энэ судалгааны үндсэн дээр бол төсөл хэрэгжүүлж эхэлсэн байгаа.

Оторт энэ асуудлууд бол гардаг. Тэгээд отроор явж байгаа малчдын татварын малын толгойн албан татварыг бол тухайн орон нутагт нь авъя гэдэг ийм зохицуулалтыг тухайн отроор явж байгаа малчдаас орон нутгаас бол нэлээдгүй гардаг байгаа. Тэгэхээр энэ жилийн төсвийг дагаад энэ дээр ямар нэгэн зохицуулалт хийх хууль бол яваагүй байгаа. Ер нь цаашдаа бас энийг яг отор ихтэй жил бол тухайн орон нутагт энэ отрыг авах, тэгэхдээ энэ хуулийн ганц зохицуулалт нь бол тухайн татварын асуудлыг хэрхэн авах, яаж зарцуулах шийдвэрийг нь бол.../минут дуусав/

Б.Бейсен: Мал эмнэлгийн бүсийн асуудлаар Хөдөө аж ахуйн сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Ямар нэгэн шинэ хөрөнгө оруулалт хийхийг хязгаарласан. Сайдын үндсэн багц дээр байгаа 5,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бол худаг

усан дээр 1,6 орчим байгаа. Нийт харьяа 34 байгууллагын засвар үйлчилгээнд 1 тэрбум гаруй, харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж 1 тэрбум гаруй. Ингээд л ирэх оны хөрөнгө оруулалтын хэмжээ байгаа нь энэ. Ямар нэгэн хөрөнгө оруулалт хийх зүйл байхгүй. Өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөр дотор энэ лабораторийн барилга байхгүй. Тэгээд өнгөрсөн дээр 40 орчим тэрбум төгрөгийн гүйцээн дуусах ийм төсөл батлагдаж байгаа.

Тэгэхээр шинээр ямар нэгэн хөрөнгө оруулалт тусаж чадаагүй. Үнэхээр мал эмнэлэг, малын эрүүл мэнд гээд яривал лабораторийн чадавх зайлшгүй, ер нь нөгөө бүх л юм цогцоор нь л холбоотой. Хөдөө аж ахуйн салбар бол бүх юм хоорондоо уялдаатай, цогц иж бүрнээр нь авч үзэхгүй бол ер нь нэг талаас нь ингээд сорчилж аваад шийднэ гээд .../минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Болорчулуун дарга аа, тэр төслийн ажил руу бас нэлээн анхаараарай. Таны хэлж байгаа, амьдрал дээр байгаа 2 чинь бас жоохон зөрүүтэй л байна. Нөгөө компани чинь бол 80 хувьтай гэсэн юм яриад л явж байгаа юм байна лээ.

Отрын бүс нутгийн асуудал, тэр татварын асуудлууд бас хууль нь орж ирж байгаа юм байна. Энэ бол бас зүйтэй. Тэгээд одоо бид дэмжинэ. Сайдаас 2 асуулт байгаа юм. Энэ яах вэ, манай бүсээс олон хүмүүс анхаарлаа хандуулаач ээ гэсэн ийм юм яриад байгаа юм. Ер нь бол энэ Монгол Улсад энэ экспортын үржлийн адуу ХААЯ-ны зөвшөөрлөөр орж ирдэг. Хэдэн мянгаараа орж ирж байсан юм билээ. Болорчулуун сайд байхдаа хэдэн 100 болгосон юм билээ. Үүний ер нь ач холбогдол ямар юм байдаг юм бол. Цаашдаа энэ асуудал ер нь энэ чигээрээ ингээд л яваад байх уу. Эсвэл зориулалт юмыг нь тодорхой болгоод, тодорхой хориг юмнууд тавигдах уу. Энэ нөгөө адууг эрлийзжүүлэх тэр юмны гол үндэс байна гээд саяхан энд уяачид ирсэн. Бас энэ л асуудлыг бас ярьж байгаад л одоо.../минут дуусав/

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд. 6 номер хариулъя.

Ж.Энхбаяр: Адуу олон мянгаар оруулсан зүйл байхгүй. Ер нь хүсэлт бол олон мянгаар ирдэг. Хамгийн дээд хэмжээ нь 500-аар л квот хязгаарлалт тогтоож ирсэн юм байна лээ. Тэгэхээр 2025 онд тэр хүрээндээ л явна. Зайлшгүй бас махны чиглэлийн, адууны хурдыг сайжруулах, үржил селекц хийх, мөн Монголоор дамжин экспортод гаргах гээд янз янзын л чиглэлийн аж ахуйн нэгжүүд ийм хүсэлт тавьдаг юм байна лээ. Тэгээд 2025 ондоо бол энэ 2024 оныхоо түвшиндээ л байна. Ер нь тоог нэмэхгүй гэж бодож байгаа. Нийт Монгол Улс 5 сая адуутай. Тэгээд 5 сая адуунд жилдээ 500 адууны импортын зөвшөөрлийн хэмжээнд байхад бол сүргийн бүтцэд, малын удмын санд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байгаа.

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Ойлголоо. Тэгэхдээ янз янзын зорилгоор л орж ирж байгаа гэж байна. Яг 500 адууг аль нь хурдных юм. Аль нь махных юм. Энэ зөвшөөрлүүд аль нь яг эрээн экспортоор гараад байгаа юм гэдгийг. Яг энэ 500 дээрээ ер нь ангилсан, ялгасан хяналт тавьдаг тийм зүйл байна уу.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя. 6 номер.

Ж.Энхбаяр: Энэ малын гаралтай, мал аж ахуйн гаралтай, ургамлын гаралтай энэ зүйлийн гарал үүсэл мөшгөх систем гээд дэлхийн хэмжээнд нэлээн хатуу дүрэм журмаар зохицуулчихсан байдаг. Бүх юм чинь өөрийн гаралтай, үүсэлтэй, квоттой. Гаалиар хүртэл тэр чинь махных нь, хурдных нь, үржлийнх нь, гоёлынх нь гээд тус тусдаа их нарийн зохицуулалттай тэр хүрээндээ л орж ирнэ. Энэ жилийн тухайд 500 гэсэн зөвшөөрөл, квот олгогдсон. Одоогийн байдлаар орж ирсэн нь 460 орчим тооны адуу орж ирсэн байгаа юм байна лээ. Нэлээд нь бас Монгол Улсаар дамжаад, БНХАУ руу дамжин өнгөрч гарч байгаа ийм байна тоо байдаг юм байна.

Б.Бейсен: Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Аудитын газраас асууя. Монгол Улсын Ерөнхий аудитор гэдэг хүн энэ маш чухал цаг үед төсөвт дахиад ингээд хэлэлцэгдэж байгаа, Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавиад, Монголын ард түмэн тэр чигээрээ нүд чихээ тавиад, энэ төсвийг чинь бараг цагаан толгойн үсэг шиг мэддэг болчихлоо шүү дээ. Одоо энэ ард түмэнд ямар хүлээлт байгаа юм. Яаж энэ зардлыг, энэ алдагдалтай төсвөө Их Хурал яаж зөв баталж гаргаж ирэх вэ гээд ингээд бүгд хараад сууж байгаа юм. Тэгээд энэ хариуцлагатай үед Ерөнхий аудитор чөлөө авсан гэсэн нэрийдлээр байхгүй. Тэгээд орлогч 1 хүн ирж мэдээлэл хийж байгаа энэ явдалд бол би ч шүүмжлэлтэй хандаж байна. 1 дүгээрт.

Аудитын дүгнэлт харлаа би сая. 2017 оноос хойш төсвийн урсгал зардал тогтмол өсөж байгаа гэсэн. Төрийн албан хаагчдын тоо 2010 оноос хойш жил бүр өссөөр 2023 оны байдлаар 226,5 мянгад хүрчээ гэсэн ийм дүгнэлт гарсан байна. Энэ байдалд аудит ер нь цаашид эндээ ямар дүгнэлт хийх юм. Ингээд л жил болгон өсөөд л яваад байсныг нь мэдсээр байгаа мөртөө одоо энэ дээр яг шийдвэртэй ямар арга хэмжээ энэ удаагийн төсөв дээр бүр юу гэж оруулж ирж байгаа вэ. Үнэхээр ярьж байгаа шүү дээ. Энэ төрийн том данхар бүтэц, энэ төсвийн тэлэлт, тэрийг дагасан зардлууд. Энийг ерөөсөө үнэхээр их ярьж байна. Энэ дээр аудитын газар, аудит ер нь яг бодит ямар дүгнэлт хийж, энийг цаашид яаж цэгцлэх гэсэн ямар нэгэн шийдвэр байна уу.

Энэ улсын төсвийн үр ашигтай, үр нөлөөтэй байдал гээд энэ дүгнэлтэд ерөөсөө аудитын өөрийнх нь юунд байж байгаа юм. Гэтэл энэ үр ашигтай, үр нөлөөтэй гээд байгаа тэр төсвийн чинь байдал яг энэ танай дүгнэлтэд бодит байдлаар тусгагдсан юм уу. Юу нь үр ашигтай юм. Юу нь ямар үр нөлөөтэй юм. Энэ талаар нэг хариулт өгөөч.

Б.Бейсен: 3 номер. Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч хариулъя.

Я.Самбууням: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Ерөнхий аудиторовын орлогч Самбууням байна. Бид ер нь бол 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөхдөө урьд онуудын харьцуулсан судалгааг бол хийсэн байгаа. Сая Батчимэг гишүүн бол манай тайлантай сайн танилцсан байна. Тэгээд энэ дээр бол яг үнэхээр жил ирэх тусам төсвийн урсгал зардал нэмэгдэж байгаа. Мөн төрийн албан хаагчдын орон тоо нэмэгдэж байгаа. Үүнтэй холбогдуулаад жил бүхэн цалингийн зардал буюу урсгал зардалд голлох нөлөөллийг үзүүлж байгаа цалингийн зардал бол өсөж байгааг бол бид тайландаа тусгасан байж байгаа.

Мөн ер нь манай тайлан дүгнэлтэд ч орсон. Тэгээд бид бол Засгийн газарт энэ төсвийн төслийг төрийн мөнгөний бодлогод нийцүүлэх, төсвийн зардлын тэлэлтийг нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг нь үнэлж бууруулах арга хэмжээ авах шаардлагатай гэсэн зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлсэн байгаа. Баярлалаа.

Б.Бейсен: Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас асуулт асууна. Агаарын бохирдлыг бууруулах асуудал Засгийн газрын тухай хуулиараа, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиараа, Агаарын тухай хуулиараа танай яамны асуудал. Энэ ч утгаараа 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, тэгээд хөтөлбөрийн хүрэх дүн дээр хүрээлэн буй орчны бохирдол, доройтол гээд хэсэг дээрээ 2 ажил бичигдсэн байна. Улаанбаатар хотын агаар дахь пи эм 2,5 тоосонцрын агууламжийг 41 микро грамм метр кубаас 31 рүү буулгана буюу миний ойлгож байгаагаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан тийм 35 микро грамм метр куб байвал зохимжтой байна гэсэн тэр лүү дөхөж байгаа юм болов уу. Тааж ойлгоод байгаа шүү дээ.

2 дахь ажил нь болохоороо агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулсан аймаг суурины тоог 2-5 болгон нэмэгдүүлнэ гээд сууж. Тэгэхдээ төсөвт бол 2025 оны энэ төсөвт холбогдох ажлууд нь огт дурдагдаагүй байна. Тэгээд энийг яаж шийдвэрлэхээр төлөвлөж байгаа вэ. Энэ яамнаас хариулт авъя.

Нийслэл дээр бол Улаанбаатар хотын агаарын бохирдолтой холбоотой холбогдох зардал нь сууж байгаа гэж ойлгосон. Тэгээд энэ агаарын бохирдлын асуудал аймгийн төвүүдийн, сумын төвүүдийн асуудал мөн учраас холбогдох аймгууд нь өөрсдийнхөө төсөвт оруулах ёстой байх.

Тэгээд одоо сүүлийнх нь санал гэх юм уу. Тэртээ тэргүй хуулиудаараа танай яамны эрхлэх асуудал учраас хэрвээ энэ 2025 оны төсөвт төсөв нь суугаагүй бол магадгүй орон нутгийн төсвүүд батлагдахаас өмнө аймгууд руу, сумууд руу та чиглэл өгөх ёстой юм болов уу. Тэгээд ямартай ч энэ хөтөлбөрт пи эм 2,5 тоосонцрын хэмжээ буурна гэж орж ирсэн байгааг бол сайшааж харж байгаа боловч төсөв нь тавигдаагүй учраас энэ төлөвлөгөө хүрэхгүй байх вий дээ гэсэн ийм бодолтой байна. Хариулаад өгөөрэй.

Б.Бейсен: 5 номер. Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Чухал асуулт асуулаа. Тэгэхээр Уянга гишүүний асуусан асуултад хариулахад манай яам хэдийгээр нийслэл рүү агаарын бохирдлын асуудал шилжсэн ч гэсэн бид нар бодлогын хэмжээнд бодлогоор хангах үүрэгтэй гэж үздэг. Ингээд агаарын бохирдлын талаарх зөвлөлдөх уулзалтыг сая 11 дүгээр сарын 14-ний өдөр манай эрдэмтэд, судлаачид, бид хийж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нямбаатарт нийт 5 хуудас бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байгаа. Энэ бол богино хугацаанд юу хийх вэ. Дунд хугацаанд, урт хугацаанд гэсэн ийм тус тусдаа 10, 10 зүйлтэй зөвлөмжүүдийг хүргүүлсэн байгаа. Тэгэхээр өнөөдөр бас нэг эерэг мэдээ хэлье. Нийслэл нийтийн тээврийн хэрэгслүүдээ бүгдийг нь Евро 5 стандарт руу шилжүүлж байгаа юм байна. Тэгэхээр ингэснээрээ Евро 5 стандартын шатахуунаас бол автомат

хугацаанаас ялгарах тоосонцор бол 95 хувь буурч байгаа. Тэгэхээр нийт 1191 нийтийн тээврээс гэхэд бол нэлээд хэмжээгээр буурна. Нүүрс хүчил болон метан хийг 80 хувь, азотын ислийг 90 хувь бууруулах ийм боломжтой болж байгаа. Тэгэхээр Евро 2-оосоо илүү 200 дахин бага хүхрийн агууламжтай гээд энэ Евро 5 руугаа шилжиж байгаа. Төрийн үйлчилгээнд шилжүүлэхэд бол бага зэргийн хүндрэлүүд байгаа. Энийг бол бид нар бас яриад шийднэ гэж бодож байна. Хэдийгээр энэ дээр тавигдсан төсвүүд багассан ч гэсэн бид нар бол хүрэх үр дүнгээ биелүүлнэ гэж бодож байгаа. Манай газрын дарга яг одоо ямар ажлыг хийж, аль алийг нь хэдэн хувиар бууруулах вэ гэдгийг бас дэлгэрэнгүй хариулах боломжтой байгаа.

Ер нь яах вэ энэ саяын энэ харуулууд гэж байгаа агаарын чанар хэмжих энэ дээр л манай бүх аймгууд уг нь хамрагдвал зүгээр байгаа. Даанч төсөв хөрөнгийн асуудлаас болоод энэ бас хүндрэлтэй болоод байгаа юм. Энхмөнх дарга хариулчих.

Б.Бейсен: 9 номер Энхмөнх дарга нэмэлт хариулт өгье.

Г.Энхмөнх: Агаарын бохирдолтой холбоотой асуудлаар тайлбар мэдээлэл өгье. Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой асуудлаар 2002-2023 онд үндэсний хорооны үндсэн чиг үүрэг Эрчим хүчний яам дээр байсантай холбоотойгоор энд бол 4квт-ын цахилгаан дулаанаар хангах бүрэн боломж бололцоог бүрдүүлсэн байж байгаа. Энэ хүрээндээ 25 мянган айл өрхийг цахилгаан халаалтад шилжүүлэх, мөн хийн халаалтад бол 15 мянган айл өрхийг шилжүүлснээр энэ агаарын бохирдлыг бол 20-25 хувиар бууруулах бүрэн боломжтой гэдэг ийм судалгаа тооцоо байгаад, ажил нь хийгдээд явж байна.

2 дугаарт нь энэ төрийн байгууллагуудын буюу сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хороо, цэргийн анги, хорих анги нийлсэн энэ 117 усан халаалтын зуухнууд байж байгаа. Энэ усан халаалтын зуухнууд маань үндсэндээ түүхий нүүрс ашиглаж байна. Энэ одоо .../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбат гишүүд асуулт асууя.

Ц.Мөнхбат: Хөдөө аж ахуйн яамны төсөвтэй холбоотой ганц 2 юм асуух гэсэн юм. Манай Хөдөө аж ахуйн сайдын төсөв бол харьцангуй бас нэмэгдсэн юм байна. Өмнөх онтой харьцуулахад 716 байж байгаад, нийлбэр дүн нь сая багасаад 794 тэрбумаар, тэгээд тэр дотроо Хөдөө аж ахуйн сайдын шууд гээд ийм багц дээр өмнөх онд 398 байж байгаад 519 гээд нэмэгдсэн. Бас харьцангуй ийм ололттой салбар байна. Тэгээд энэ дотор ганц 2 ойлгомжгүй зүйл асуух гэсэн юм.

Энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ дотор хэд хэдэн юм байна. Энэ дотроо гэрээгээр гүйцэтгүүлэх, төрийн зарим чиг үүргийг бусдаар гүйцэтгүүлэх гээд хэд хэдэн дүнгүүд байдаг. Тэр дотроо дахиад Хөдөө аж ахуйн сайдын шууд гээд энэ 2,2 тэрбум төгрөг байдаг юм байна. Энэ яг юунд зарцуулагддаг төсөв юм бэ гэж асуух гэсэн юм 1 дүгээрт.

2 дугаарт нь мөн тэр бусдаар гүйцэтгүүлэх дотор хүнсний хангамж, аюулгүй байдал гээд 40 тэрбум төгрөг байдаг юм байна. Энийг бас юунд зарцуулдаг юм бэ гэж. Энэ дээ ойлголт авах гэсэн юм.

3 дугаарт энэ нэг Зээлийн батлан даалтын сан гээд 45 тэрбум төгрөг тавьдаг юм байна. Энэ ер нь яадаг юм бэ. Зээл авах гэж байгаа төслүүд дээр Батлан даалтын сангаас тодорхой хэмжээг нь хариуцдаг. Тэгээд жил жилд тавьдаг эд үү. Энэ ингээд нөгөө буцааж нөхөгдөөд, дахиад нэмэгдээд ингээд явдаг эд үү. Энэ талаар ойлголт авах гэсэн юм.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас бас нэг ийм юм асууя. Сая яах вэ Уянга гишүүн энэ агаарын бохирдолтой холбоотой асуучихлаа. Зүгээр дээрээс нь нэмж асуухад өнгөрсөн жил 24,5 тэрбум төгрөг байж байгаад, энэ жил 9,5 тэрбум болоод буурчихсан юм байна. Энэ агаарын бохирдлыг бууруулах мөнгө нь. Энэ дээр хамгийн гол асуудал бол энэ нийслэл дээр л бий болоод байна л даа. Тэгэхээр зэрэг энэ нийслэл энэ дээр ер нь хэр мөнгө тавьж байгаа юм бэ. Энэ дээр мэдээлэл байна уу. Энэ талаар нэг хэлж өгөөч.

Сая тэр газрын даргын ярьж байгаагаар цахилгааны халаалтаар 25 мянга орчим айлыг цахилгаанаар халаах боломжтой энэ тэр гээд ярилаа. Үүний нөгөө цахилгааны эх үүсвэр, тэр цахилгаан хангамжийнх нь найдвартай байдал нь хангагдсан байдаг юм уу. Орон нутагт бол .../минут дуусав/

Б.Бейсен: 1 минут нэмж олгоё. Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: Орон нутгуудад цахилгаанаар халаалгах гэхээр нөгөө цахилгааных нь эх үүсвэр хүрэлцдэггүй. Тэгээд тийм асуудлууд гарч ирээд л байдаг л даа. Тэгээд энэ дээр одоо ямар тооцоо байдаг юм.

Бас нэг зүйл сая тэр Уянга гишүүний хэлсэн дээр орон нутгийн төсвүүд батлагдаагүй байгаа. Энэ жил бас орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөв буюу өөрсдөө мэдээд шийддэг төсөв нь бас харьцангуй гайгүй нэмэгдсэн. Энэ ААНОАТ-ын 40 хувь тэр орон нутагтаа үлддэг болсонтой холбогдуулаад бас гайгүй нэмэгдсэн байна лээ. Өмнөх жилүүдтэй харьцуулахад. Тэгэхээр зэрэг тэндээс энэ агаарын бохирдол руугаа чиглүүлэх тийм чиглэл өгөөд явж болдог юм уу. Ер нь тэгэх шаардлагатай юм биш үү гэдэг ийм саналуудыг бас хэлэх гэсэн юм.

Б.Бейсен: Эхлээд Байгаль орчны сайд, дараа нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр манай яамны нийслэл яг одоогоор хэдийг агаарын зарцуулах гэж байгааг бас нарийн тодруулъя. Манай яам бол хөдөө аймгуудад бол аймгийн төвүүд бол бас маш их утаатай болоод эхэлсэн. Тэгэхээр энэ хөдөө аймгуудад, ялангуяа аймгийн төвүүдийг агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр бид бол нэлээд ажиллаж байгаа. Өмнөговь аймаг бол энэ дээр нэлээд сайн жишиг туршлага бол сая гаргаж ирсэн. Өнгөрсөн хугацаанд энэ Сэддорж гишүүн Засаг дарга байхдаа. Энийг манай яамныхан бид өөрсдийн биеэр Өмнөговь аймагт очиж үзээд, тэр хэмжилтүүдийг нь хийсэн юм. Тэр бол ямар зүйл байсан бэ гэхээр айлуудад ийм давхар шаталттай зуух тавьж өгсөн. Тэр нь бол ерөөсөө айл өрх угаартдаггүй, тэгээд угаараас болоод маш олон хүн нас барж байгаа учраас ерөөсөө угаартдаггүй. Тэгээд бүүр утаа гардаггүй. Тэгээд энийг бол олон хэмжилт хийгээд энэ нь их амжилттай, үр дүнтэй болсон учраас бид нар бусад аймгууд дээр энэ туршилтыг бол эхлүүлж байгаа. Тэгэхээр аймаг орон нутаг бол бас яг таны хэлж байгаа энэ төсөв хөрөнгөө агаарын бохирдолдоо зарцуулахгүй бол бас агаарын бохирдлууд бол нэлээд нэмэгдэж байгаа. Тэгээд бид нар бол аймгуудаа бүгдийг нь нарийн хэмжээд, энэ агаарын бохирдлын

хуулийг нь мөрдүүлье гэхээр нөгөө хэмжигчүүд нь бас байхгүй байгаад байгаа. Цахилгааны түрүүний халаалт бол ийм учиртай юм. Цахилгаан халаагуураар, хийн халаагуураар заримыг нь бол сэргээгдэх эрчим хүч гээд маш олон эх үүсвэр байгаа. Зарим урт хугацаандаа бол орон сууцжуулна төвийн дэд бүтцэд холбоно гэсэн маш олон цогц арга хэмжээний ердөө 1 хэсэг нь энэ цахилгаанаар хэсэг гаалийг халаах ийм тооцоо судалгаанууд бол гарчихсан байгаа. Энхмөнх дарга нэмээд хариулах уу.

Б.Бейсен: 9 номер нэмж хариулъя.

Г.Энхмөнх: Мөнхбат гишүүний асуултад хариулт өгье. 4квт-ын цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлсэн. Энэ дээр Эрчим хүчний яамнаас Орчны бохирдлын үндэсний хорооны санхүүжилтээр бол 12 багц ажил хийгдээд, 2023 онд бүрэн дууссан. Ингэснээрээ үндсэндээ энэ 10 мянган айлын 4квт-ын цахилгаан халаагуураар хангах тийм бүрэн боломж бүрдсэн гэсэн үг.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд.

Ж.Энхбаяр: Яамны нэлээн олон чиг үүрэг бусдаар гүйцэтгүүлдэг. Ялангуяа мал эмнэлгийн харьяа, ялангуяа хөдөө аж ахуйн бүх сумуудад байгаа мал эмнэлэг бол 100 хувь хувийн хэвшил үүрэг гүйцэтгэж байгаа. Мал эмнэлгийн төсөв 69 байж байгаад 61 боллоо. Үүний бараг 45, 46 тэрбум нь тэр орон нутагт байгаа мал эмнэлгүүдэд тэр малын угаалга, вакцинжуулалт, мал эмнэлгийн тэр гарал үүсэл мөшгөх тогтолцоог мөрдүүлсний төлөө өгөгдөж байгаа ийм зардлууд байдаг.

Тэр сайдын шууд 2,2 гэж байгаа. Тэр бусдаар гүйцэтгэх ажил дотор. Энд бол салбарын үйл ажиллагааг сурталчлахаас гадна нөгөө салбарт хэрэгжиж байгаа нийт цахим программ хангамжууд байгаа. Ургамал хамгааллын, мал хамгааллын, тэгээд мөшгөх тогтолцооны хэрэглэж байгаа программ хангамжуудын төлбөрүүд явж байгаа юм байна. Мөн .../минут дуусав/

Б.Бейсен: Сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ жил хэдэн жил тасарч байгаад хэрэгжих Монгол Хятадын бизнес эрхлэгчдийн экспо зохион байгуулагдана. Энэ арга хэмжээний хүрээнд бид нарт бас тодорхой төсөв энэ дотроо багтааж хийнэ. Энэ бол Монголын бизнес эрхлэгчид нэлээн том зах зээлээ нээдэг, гэрээ хэлэлцээрүүдээ явуулдаг, их томоохон ийм экспо болдог. Мөн Евро Азийн эдийн засгийн холбоотой гэрээ хэлэлцээр Хүнс, хөдөө аж ахуйн яамны хамт олон оролцож байгаа. Үүний гадаад арга хэмжээ, уулзалтын арга хэмжээний зардлууд тусаж байгаа. Ийм зүйлүүд л байна даа. Үндсэндээ салбарын хэмжээнд байгаа хэмжээ бол энэ 2,2. Мөн хууль гэж их том, хууль боловсруулах. Бидний дунд бараг 20-иод хууль шинэчлэн боловсруулах шаардлага үүсэж байгаа. Зөвхөн хүнсний хангамж аюулгүй байдал буюу хүнсний хувьсгалын хүрээнд нийт 10-аад хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах ийм үүрэг Их Хурлаас өгөгдсөн. Тэгээд саяын малын хөлийн татвараас авхуулаад энэ хөнгөн ... /минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбат гишүүн тодруулъя.

Ц.Мөнхбат: Тэр агаарын бохирдлыг бууруулах дээр төсөв бол хангалтгүй байна гэж харагдаж байна л даа. Тэгэхээр зэрэг энэ дээр та бүхэн, танай яам чинь

бас харьцангуй олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй нэлээн хамтарч ажилладаг. Тэр чиглэлийн нэмэлт эх үүсвэр гэдэг юм уу, хөрөнгө оруулалт байна уу гэж бас асуучихмаар байна.

Хүнс, хөдөө аж ахуйн сайд дээр тэр хүнсний хангамж аюулгүй байдал гээд бас 40 тэрбум байгаа юм. Тэр бас юунд зарцуулагддаг хөрөнгө вэ гэж асуух гэсэн юм.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Манай дээр үндсэндээ 4 том бодлого байгаа. Улсын Их Хурлаар батлагдсан Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атрын 4, Шинэ хоршоо. Төсөв нэмэгдсэн нь юунд харагдаж байна гэвэл Шинэ хоршоо хөдөлгөөн буюу энэ малчдыг хоршоолж болох, хөдөлмөрөөрөө хорших нь улсын хэмжээнд явж байгаа ажил шинээр манай дээр орж ирж байна. Мөн 2025 оноос цагаан алт үндэсний хөтөлбөр буюу арьс шир, ноос ноолуурын салбарын боловсруулалтын түвшнийг сайжруулах ийм 2 том бодлогын хөтөлбөр шинээр орж ирсэнтэй холбоотой төсөв өсөлттэй харагдаж байгаа.

Саяын тэр хүнсний хувьсгалын хүрээнд энд 3 төрлийн урамшуулал үйлдвэрт тушаагдсан улаан буудай тутамд 80 мянган төгрөг, хүнсний ногоон, нэр бүхий хүнсний ногоо тонн тутамд 100 мянган төгрөг, үйлдвэрт тушаагдсан литр сүү тутамд 1000 төгрөг гэсэн ийм 3 төрлийн урамшуулал өөрөө саяын таны хэлдэг 40 хэдэн тэрбум төгрөг дотор байгаа.

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр манай салбар бас энэ гаднын хөрөнгө оруулалт төслөөр бас энэ асуудлуудаа нэлээд шийдвэрлэдэг. Энд ялангуяа агаарын бохирдлыг шийдвэрлэх асуудал дээр бол НҮБ-ын, АХБ-ны үе шаттай олон төслүүд хэрэгжиж байгаа. Мөн энэ агаарын бохирдлыг хэмжих автомат станцуудыг орон нутагт байршуулах дээр Солонгосын бас нэлээд том төсөл хэрэгжээд эхэлж байгаа. Тийм учраас энийг бол аймгийн төвүүдэд байршуулахаар ажиллаж байна. Жил болгон 7, 7 аймгаар нь ингээд хийгээд явж байгаа.

Сүүлийн үеийн хамгийн бас яах вэ үр дүнгээ өгч байгаа төсөл юу вэ гэхээр гэр хорооллын айлуудад хашаанд нь нөгөө сэргээгдэх эрчим хүчний нарны хавтанг тавих асуудал бол нэлээд эхэлсэн. Хэд хэдэн тавьсан айл дээр очиж уулзсан. Сэтгэл хангалуун, ямар ч нүүрс түлдэггүй, сэргээгдэх эрчим хүчээр батарей иж бүрнээр нь ингээд хан хангачихсан ийм төслүүд .../минут дуусав/

Б.Бейсен: Замира гишүүн асуултаа асууя.

С.Замира: Энэ төсөв алдагдалтай болсон. Тийм учраас Ерөнхийлөгч маань хориг тавьсан байдаг. Тэгэхдээ энэ төсөв ярихаар дандаа нүүрсээр ярих юм бүгдээрээ. Нүүрснээс өөр боломж манай Монгол оронд байгаа шүү дээ. Хэрвээ төсвийг хасуулахгүй байя гэвэл эсвэл өөрсдөө бүрдүүлье гэвэл төлөвлөгөө боловсруулаад, оруулах ёстой байхгүй юу. Ялангуяа энэ Хөдөө аж ахуйн яам. Хөдөө аж ахуйн яам энэ 5 хошуу малын бүх бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн гаргах боломжтой шүү дээ. Тэгээд эрүүлжүүлэх тал дээр ер нь бид нар Орос улстай хамтарвал яасан юм бэ. Энэ замбараагүй хилийн бүсээр орж байгаа энэ

бүх вакцин, эм тан бүгд, ихэнх нь хортой болж таарч байгаа. Ялангуяа тэр малын биш зөвхөн ард түмний хэрэглэж байгаа эм тангийн 80 хувь нь хуурамч гээд яриад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр уулзах болгондоо яриад хөрөөд суугаад байх юм бүгдээрээ. Тийм учраас эрчимтэй арга хэмжээ аваад, төлөвлөгөө боловсруулаад, төр засагтаа танилцуулаад, батлуулаад хүчтэй хөдөлгөөн хийвэл яасан юм бэ. Хэдүүлээ тэгээд ч юм бас манай Монгол оронд бол ганцхан нүүрс биш шүү дээ. Нүүрс нүүрс гээд нүүрс авахгүй бол яана гээд чичрээд суух биш.

Ашигт малтмалыг нь бол өөр төрөлд зөндөө байгаа. Жишээлбэл, алт. Алт бол манайх нөгөө муухайгаар хэлбэл уучлаарай. Алтан дээр суусан гуйлгачин гээд. Алтайн нурууг тэр чигээр алт шүү дээ. Тэр газруудын ихэнхийг нь аваачаад тусгай хамгаалалттай тусгай хэрэгцээтэй гээд хадгалаад хаячихсан. Цаад талд нь урд хөрш олборлолт хийгээд байдаг, бид нар гараад суугаад байдаг. Тийм учраас энэ бүгдийг нэг эрчимтэй ажил болгох хэрэгтэй л дээ. Алтыг олборловол бид нар бол нүүрсийг хараад суух шаардлага байхгүй. Алтны ханш гэдэг чинь дэлхийн зах зээл дээр тэнгэрт гарчихсан байгаад байдаг. Алтны нөөц дууссан, алтны хайгуулын ашиглалтын лицензүүд бүгд дууссан гээд байгаа. Дуусаагүй байна. Ажил хэрэг болохгүй байна. Энд тэнд янз бүрийн шат шатдаа саад хийгээд, хориод сууж байгаа хүмүүс байна. Бас тэгээд 10 тонн, 20 тонн алттай гээд Орос улсын тухайн үед социализмын үед бүр 1950 хэдэн онд, 1980 хэдэн онд судалгаа хийсэн газруудын алтыг үгүйсгээд худлаа цуурхал тараад хэсэг хүмүүс бий болчихсон байна. Тийм учраас энэ бүгдэд арга хэмжээ аваад, ялангуяа Хөдөө аж ахуйн сайд мал, түүхий эдийг ашиглалтад оруулаад, тэр бүгдийн эргэлтэд оруулаад, гадаадын хөрөнгө оруулалтыг татаад, өөрсдөө төсвөө бүрдүүл л дээ. Энэ тал дээр ер нь бодож байгаа, авах гэж байгаа арга хэмжээ байна уу.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя. 6 номер. Дараа нь Байгаль орчин сайд 5 номер.

Ж.Энхбаяр: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар 2 хөрштэйгөө ялангуяа энэ мал эмнэлэг, ургамал хамгааллын чиглэлээр маш нягт хамтын ажиллагаатай байх ёстой. Яагаад гэвэл өргөн газар нутгаар хиллэж байна. Биологийн олон төрөл зүйл байна. Нүүдлийн болон нүүдлийн шувууд, зэрлэг ан амьтны хөдөлгөөнүүд дамжин өнгөрч байна. Тийм болохоор энэ мал эмнэлэг, ургамал хамгааллын чиглэлийн гэрээ, протоколуудаа нэлээн сайн ойлголцдог, хамтран ажилладаг байдаг. Зөвхөн шүлхий гэхэд шүлхий буюу олон улсын гоц халдварт энэ өвчний вакциныг бол бид нар сүүлийн үед зөвхөн ОХУ-тай хамтран шууд худалдан авалт хийж байгаа. Та бүхэн санаж байгаа бол вакцин гээд л янз янзын хувийн ашиг сонирхол орлоо. Үнэ дамлалаа гээд янзын ийм маргаан үүсдэг байсан. Тэр зүйл байхгүй болсон. Үндсэндээ хамгийн сайн үйлдвэрлэгчээс шууд нийлүүлээд, шууд хэрэгжүүлдэг болсон нь ямар нэгэн юм дамжсан ченжийн шахдаг тендерийн зүйл үндсэндээ байхгүй болсон. Тэгээд бид энэ малын гоц халдварт өвчинтэй тэмцэх 2 шатын том хөтөлбөр хэрэгжүүлээд амжилттай дууссан. Одоо 3 дахь шатын хөтөлбөрөө хэрэгжүүлэхээр ЗГХК-т энэ 12 сарын хорьдоор болох комисст энэ асуудлуудаа санал хүсэлтээ өгөөд ингээд явж байна.

Б.Бейсен: 5 номер Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Замира гишүүнтэй санал нэг байна. Тэгэхээр Баян-Өлгий аймагт жишээлэхэд алтны уурхай байгаа. Тэгээд алтны үйлдвэр гаднын хөрөнгө оруулалтаар ажиллаж байгаа. Энэ дээр бол бас нэлээд удаан хугацаанд

ашиглалтад орж чадахгүй байсан. Манай яамнаас бол хяналт шалгалтыг хийгээд, дандаа хааж хорино гэхээсээ илүү зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж байгаа. Та нар энэ менежментийн төлөвлөгөөгөө яаралтай батлуул, усны гэрээгээ хий, байгаль орчны ийм стандарт байх ёстой гээд байнга ингээд бол ажиллаж байгаа. Тэнд бас манай Их Хурлын гишүүдээс ирсэн санал асуулгын дагуу бид нар бас энэ гаднын хөрөнгө оруулалтыг нэг талаасаа аль болохоор дэмжээд, байгаль орчны стандартыг нь хангаж ажиллуулахаар явж байгаа. Гэхдээ яах вэ нэг хэсэг бол бас алтны асуудал дээр монголчууд маш замбараагүй хандаж, их хэмжээний газрыг бол нөхөн сэргээгээгүй орхисон ийм үе байсан. .../минут дуусав/

Б.Бейсен: Манай Одонтуяа сайд гүйцээж хариулья.

С.Одонтуяа: Манай яамнаас нэлээд урт хугацааны эрчимтэй ийм стратеги төлөвлөгөө гаргасны үр дүнд 2020 оноос хойш бол техникийн 9773 га, биологийн 2549 га-г нөхөн сэргээлтийг хийлгэсэн байгаа. Тэгэхээр одоо манай яамны зорилт бол дараа жил гэхэд бид нар нөхөн сэргээгдээгүй талбай үлдээхгүй байх ийм зорилго тавиад ажиллаж байгаа. Тэгэхээр алтны уурхайнууд ажиллаж болно Гэхдээ нөгөө хариуцлагатай ул уурхайг бид нар бас хөгжүүлэх шаардлагатай байгаа.

Б.Бейсен: Замира гишүүн тодруулья.

С.Замира: Хөдөө аж ахуйн сайдаас уг нь мал аж ахуйн чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, хамтарсан үйлдвэрүүд барих, ялангуяа эцсийн бүтээгдэхүүн гаргах тал дээр ер нь төлөвлөсөн авч байгаа арга хэмжээ байна уу гэж асуусан. Тийм боломж байдаг уу яам дээр.

Б.Бейсен: 6 номер. Хөдөө аж ахуйн сайд хариулах уу.

Ж.Энхбаяр: Бид бүх орноос хөрөнгө оруулалт хийхийг бүх талаар хөхиүлэн дэмжинэ. Ялангуяа хөдөө аж ахуйн боловсруулах салбар дээр хөрөнгө оруулж байгаа бол бүх талын дэмжлэгийг үзүүлнэ. Бидэнд юу хэрэгтэй юм гэвэл хөрөнгө оруулалт хэрэгтэй байна. Шинэ технологи инновацын салбарт нэвтрэх хэрэгтэй байна. Энд ямар нэгэн яамны зүгээс саад, тусгай зөвшөөрлөөр хязгаарлах зүйл огт үгүй.

Б.Бейсен: Мэндсайхан сайд асуулт асууя. Энэ Мэндсайхан сайдын дараагаар зарчмын зөрөөтэй 3 санал байгаа. Гишүүд хуралдааны танхимд орж ирнэ үү.

З.Мэндсайхан: Байгаль орчны сайдаас 3 асуулт байна. Тэгэхээр энэ гадаргын ус хуримтлуулах, хөв цөөрөм байгуулах гээд баруун аймагт таны төсөв дээр 6,5 тэрбум төгрөг тавигдсан байна л даа. Тэгээд энэ дээр нэг ийм байна Одонтуяа сайд аа. Одоо энэ хөв цөөрөм байгуулах техникийн даалгавар талдаа энэ чинь ирэх жил хэрэгжээд явна. Та бүгд маань нэг эргэж харахгүй бол болохгүй юм байна лээ. Яг газар дээрээ хэрэгжихсэн энэ хөв цөөрөм чинь нөгөө хүлээлтээсээ их зөрчөөд байгаа юм. Байгаль орчин одоо тэр малчдад, ногоочдод. Юу гэхээр байгалийн усыг хуримтлуулчихдаг, эргээд ус юу нь татраад ирэхээр нөгөө хөв цөөрөм чинь дагаад ерөөсөө байгалийн шороогоо тэр чигээр нь аваад үлдчихэж байгаа юм. Тэрийгээ тунгаах зардал гэдэг бол тэр орон нутаг чинь дийлэхгүй. Нөгөө талдаа байгаль орчинд хортой ийм лаг шаврын овоолго үүсээд

байна. Тэгэхээр энд хөв цөөрөм байгуулах дээрээ та нар энэ техникийн даалгавар гэдэг юм уу, техникийн нөхцөлийг энийг эргэж харахгүй бол яг өмнөхөөр нь явж болохгүй юм байна лээ шүү.

2 дахь асуудал. Одоо ингээд удахгүй л хавар болно л доо. Нөгөө л үүлэнд зориулж зориудаар нөлөөлдөг асуудал гарна. Тэгээд нөгөө пуужин нь байхгүй байна. Цаг уур дээр байхгүй байна. Шадар сайдын нөөцөөс авъя. Засгийн газрын нөөцөөс авъя гэж байтал зун болчихдог. Энэ бэлтгэл ажлыг та эртнээс хангаач ээ. Ялангуяа энэ баруун бүсийн аймгууд хуурайшилттай энэ нөхцөлд бол хавар тэр үүлэнд зориудаар нөлөөлөх, говийн бүс нутаг ч гэсэн ялгаагүй байх. Энэ сум тэр техникийн юмыг нь бэлэн байлгахгүй бол яг үүнтэй холбоотой асуудлууд үүсдэг. Тэр үед нь орилоод, тэгээд л сандарцгаагаад л тэнд шийдэх гэж байна. Энд шийдэх гэж байна. Засгийн газрын хурлаар шийдэх гэж байна гэж явж байгаад 7 сартай золгоод энэ асуудал хаягддаг. Энэ асуудалд бэлэн байгаач ээ гэдэг ийм 2 асуудал байна.

3-д Одонтуяа сайд аа, нөгөө Их Хурлын чуулган дээр та Халзан бүргэдтэйн асуудлаар миний асуултад олон улсын үнэлгээний байгууллагыг оруулна гээд ярьсан. Тэгээд энэ асуудлаа хэзээ энэ олон улсын байгууллагын үнэлгээг оруулж, тэр бүс нутгийн ард иргэдэд хариулт өгөх вэ гэдэг энэ 3 асуултад хариулт авъя.

Хөдөө аж ахуйн сайдаас энэ юуны асуудал байна сайд аа. Мал эмнэлгийн ерөнхий газар дээр 63,7 тэрбум төгрөгийн төсөл орж ирсэн юм байна. Гэтэл доор нь Мал эмнэлгийн газар дээр 37 тэрбум гээд өнгөрсөн жил явж байсан. Энэ жил тэглэчихсэн байна. Энэ юу тэглээд хаячхав. Нөгөө вакцины зардал маань байхгүй болчхов уу. Тарилга үйлчилгээний зардлыг маань ингээд хасаад хаячхав уу. Энэ асуудлыг тодорхойлж өгөөч гээд.

Мөн Энхбаяр сайд аа, одоо бид нар чинь энэ хөдөө аж ахуйн салбар дээр 4 том зорилтот хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Тэгээд өнөөдөр яг энэ хоршооны чиглэл дээр эргэж харахгүй бол болохгүй байна. Энэ зээлийн ашиглалт болон өгөөжийн талаар ер нь судалгаа хийж, танилцуулаач гэж хүсэх байна.

Б.Бейсен: Байгаль орчны сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд хариулъя. Эхлээд 5 номер.

С.Одонтуяа: Хөв цөөрмийн асуудал дээр таны саналыг сайн сонслоо. Тэгэхээр манай яамны Усны газар дээр бол ТЭЗҮ гарсан. Одоо энэ ТЭЗҮ-ээр бол аймаг сумууд хөв цөөрмөө байгуулж болно гэсэн ийм зүйл яригдаж байгаа. Тэгэхээр мэдээж аймаг, сум болгон тэгээд л хуурайшилт бүх юм бол өөр өөр байх. Тэгэхээр энэ дээр дахиж ТЭЗҮ-г нь яг мэргэжлийн хүмүүстэй бид нар дахиж таны саналыг ярилцъя. Яг одоо би өөрөө бас тэр мэргэжлийн хүн биш болохоор энэ ТЭЗҮ-г нь одоогоор бол бид нар үзээгүй байгаа. Тэгэхээр энийг зөвлөлийн хурлаар оруулаад, яг мэргэжлийн хүмүүстэй дахиж ярилцъя. Мэдээж бид нар хөв цөөрөм дээр ямар санаагаар хэлсэн гэхээр энэ их гадаргын усыг бид бас хуримтлуулъя. Тэгээд 333 сум гэдэг санаачилга гаргаад сум болгон нь хөв цөөрмөө байгуулаад явъя. Тэгээд мөстлөг энэ мөнх цастай уулууд хайлж байгаа тохиолдолд ер нь энэ гадаргын усаа авах асуудал чухал болоод байгаа юм. Тэгээд таны саналыг ойлголоо.

Тэр нөгөө пуужин буу нөгөө үүл бууддаг гээд ойрын жилүүдэд бол манайх бол хангалттай авсан гэж манай цаг уурын дарга сууж байна. Одоо 1100-1200-г авч

байгаа юм байна. Тоо ширхгийн хувьд. Тэгэхээр энэ дээр бол хэвийн болсон юм байн. Ковидын үед бол тасалдал байсан. Одоо бол хэвийн болсон гэж байна.

Халзан бүргэдтэйн хувьд бол олон улсын хөндлөнгийн ийм шинжээчид гаргая гээд одоо та бид 2 санал нийлсэн. Ингээд энэ дээр би бол энэ байгууллагад бол уламжилсан байгаа. Бид бол мэргэжлийн биш хүмүүс учраас энийг яг мэргэжлийн хүмүүс нь олон улсын хөндлөнгийн шинжээчид нь гаргаад ирэг. Үнэхээр байгаль орчинд хортой юм уу, хоргүй юм уу хийж болох энийг нь бол бид нар үндэслэх шаардлагатай гэсэн зүйлийг өгсөн байгаа. Тэгээд яг хэзээ хийж эхэлсэн, энийг нь би танд мэдээд эргээд хариу өгье. Бараг олон улсын шинжээчдийнхээ асуудлыг эхэлсэн гэж би зүгээр сонссон. Албан бичгээр танд хүргүүлье.

Б.Бейсен: 6 номер. Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Мал эмнэлгийн ерөнхий газрын манай энэ урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд ер нь нийт зардал 10 хувиар л хасагдсан юм байна. Тэрнээс бусад нь бол хөдлөөгүй байгаа юм байна. Шинэ хоршооны зарцуулалтын асуудал яг Засгийн газар шийдвэр гаргаад, Шинэ хоршоо үндэсний хороо байгуулсан. Үндэсний хороог шадар сайд Амарсайханд хариуцуулж, шинэ хоршоотой холбоотой үйл ажиллагаа бодлогыг зангидах ийм үүрэг өгөгдсөн. Төсөв нь буюу гүйцэтгэлийн тэр зээлийн арилжааны банкнуудаар дамжуулан олгож байгаа зээлийн хүүгийн санхүүжилтийг манай төсөв дээр суулгаад ингээд явж байгаа. Тэгэхээр үндэсний хороо буюу нэлээн бүтэц бүрэлдэхүүнтэй төсөвтэй ийм Шадар сайдын хэмжээнд энэ хоршооны асуудлыг өндөрт нь илүү улс төрийн ач холбогдол өгөөд илүү анхаарах нь зүйтэй гэсэн ийм шийдвэр Засгаар гаргаад ингээд хэрэгжээд явж байгаа.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулъя.

З.Мэндсайхан: Одонтуяа сайд аа, тэр хөв цөөрөм дээр та ер нь нэг үзчихвэл зүгээр юм байна лээ шүү. Яагаад гэхээр тэр чинь нөгөө байгалийн усыг дагаж орж ирж байгаа шороо гэдэг чинь маш нягт ийм лаг шавар үүсчихдэг. Дараа нь тэр чинь ямар нэгэн хөрс нь ч нэмэргүй ингээд нэг овоолго үүсээд л, хийсэн газраа ер нь хамгийн том асуудал болчихсон байна лээ.

Энхбаяр сайд аа, тэр Үндэсний хороо байгуулаад явна гэдэгтэй би ерөөсөө санал нийлэхгүй байгаа юм. Энэ дээр та бас салбарын сайд нэг бодооч. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх агентлаг гээд бид нарт ерөнхийдөө бол Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг дэмжсэн агентлаг нь байж байгаа шүү дээ. Тэгээд зэрэгцүүлээд бид нар хөдөө аж ахуйн салбарын дэмжих чиглэлээр 4 үндсэн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Энэ хөтөлбөрийн чинь асуудал бол агентлаг маань бүрэн хариуцаад явах боломжтой шүү дээ. Дахиад бид нар ингээд нэг бүтэц тэлээд явж байдаг бол болохгүй юм гэж үзэж байгаа. Тэгээд энэ дээр та бас саналаа оруулж ирээч ээ гэж хүсэх байна.

Б.Бейсен: Санал хэллээ гэж ойлголоо. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Монгол Улсын 2025 оны төсөвтэй холбоотой Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц 4 зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа. Зарчмын зүйлийн саналын томъёолол танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр хавсралт “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын” 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн 22.6.1.1 дэх заалтыг “Монгол улсын бүх хот, суурин буюу хүн ам төвлөрсөн газруудад Озон, PM_{2,5}, PM₁₀ тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл зэрэг агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодис тус бүрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг хэмжих” гэж, суурь оныг “2023” гэж тус тус өөрчлөх гэсэн санал байна. Санал хураалт. 35,5-аар дэмжсэнгүй.

Энэ уг нь Лувсанжамц гишүүн саналаа танилцуулах ёстой байсан. Байхгүй учраас шууд санал хураалгаж байна.

2.Төслийн 1 дүгээр хавсралт “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн “22.6.1.2. дахь дэд заалтыг Улаанбаатар хот болон 21 аймгийн төвүүдэд агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулах” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал хураалт 5,9 хувиар дэмжигдсэнгүй.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн шалгуур үзүүлэлтэд “22.6.2.4-д “Байгальд ээлтэй, дэвшилт техник, технологи нэвтрүүлсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлэх” гэж, хэмжих нэгжийн “Тоо” гэж, Суурь оныг “2023” гэж, Суурь түвшнийг “0” гэж, Зорилтот түвшнийг “1” гэж тус тус нэмэх. Санал хураалт. 47,1 хувиар дэмжигдээгүй.

Ганхүлэг гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргая гэж байна. Горимын санал.

М.Ганхүлэг: Саяын асуудлаар дахин санал хураалт явуулж өгөөч. Саналаа өгч арай амжсангүй.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн, Замира гишүүн нарын саналаар саяын саналыг хүчингүй болгоё. Санал хураалт. Мэндсайхан гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаж байна. Горимын санал.

3.Мэндсайхан: Саяын санал хураалтыг дахиж явуулж өгөөч гэж хүсэх байна. Нөгөө төхөөрөмжтэйгөө харьцаж чадахгүй байсаар байтал дуусчихлаа.

Б.Бейсен: Гишүүд анхааралтай байж байгаад санал өгөөрэй. Саяын саналыг хүчингүй болгоё. Санал 58,8 хувиар хүчингүй боллоо. Тийм учраас түрүүн 3 дахь саналыг дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Анхааралтай байгаарай. 3 дахь санал 52,9 хувиар дэмжигдлээ. Замира гишүүнийг дэмжсэнээр протоколд тусгаарай.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тооны хэмжээний үзүүлэлт”-ийн шалгуур үзүүлэлтэд “30.8.1.2.Санхүүжилт авсан хоршоодын орлогын өсөлтийн хувь” гэж, хэмжих нэгжийг “Хувь” гэж, суурь оныг “-” гэж, суурь оныг “-” гэж, суурь түвшнийг “-” гэж,

Зорилтот түвшнийг “10” гэж тус тус нэмэх. Санал хураалт. Лувсанжамц гишүүний санал 17,6 хувиар дэмжигдээгүй.

Дараа нь Мэндсайхан гишүүний санал.

“Дархан арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламж, Дархан-Уул, Хонгор сум” гэснийг “Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц, Дархан-Уул, Хонгор сум” гэж өөрчлөх. Мэндсайхан гишүүн саналаа тайлбарлана уу.

3.Мэндсайхан: Тэгээд энэ ийм юм байгаа юм аа гишүүд ээ. Ямар нэгэн байршлын ч юм уу, янз бүрийн юм өөрчилж байгаа юм байхгүй. Нөгөө хувийн хэвшил “Дархан арьс ширний цогцолбор” гэж хэрэгжүүлж байгаа. Төр “Дархан арьс ширний цогцолбор” гэж хэрэгжүүлж байгаа. Энэ 2 төсөв дээр нэг нэршлээр суучихаар хувийн хэвшил, төр 2-ын хооронд зодоон үүсгээд байгаа юм. Ийм нэр томъёоны зөрчил гараад байгаа юм. Тэрийг нь төвийн бүсийн парк гэж өөрчилж байгаа байхгүй юу. Түүнээс биш санхүүжилтийн дүн, тэр байршил, төслийн хэрэгжилт энэ тэрд ямар ч нөлөөлөх юм байхгүй. Энэ төрийнхтэй ороод явах байхгүй юу.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд 6 номер дээр тайлбар хийе.

Ж.Энхбаяр: Хувийн төсөл нь “Дархан арьс ширний цогцолбор ХК” гэж байгаа юм. Нөгөө бодлогын явж байгаа нь “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ХК” болчхож байгаа юм. Төрийн өмчит хувьцаат компани болчхож байгаа юм. Тэгэхээрээ язгуур үг буюу “Дархан арьс ширний цогцолбор” гэдэг манай үндсэн нэрийг энэ төрийн нэр авч ашигласан байна. Иймд энийг зөвшөөрөхгүй гээд маргаан үүсгэчихсэн. Тэгэхээр бид нар ирэх оныхоо төсвөө яг хэрэгжүүлэхийн тулд Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл технологийн парк гэдгээрээ авч яваад, зөвхөн хөнгөн үйлдвэрлэл дотроо ганц арьс шир биш ноос ноолуур, даавуу даалин, ээрмэл сүлжмэл, тэгээд л тэр мод чулуу, бүх үйлдвэрүүд нь хөнгөн дотроо ороод хийгдэг гэж бодож нэгдсэн дэд бүтцийг нь татах нь. Тэгэхгүй бол зөвхөн арьс ширээр хязгаарлачихаар бусад чиглэлийн хөрөнгө оруулалт, хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэрүүдийн үйл ажиллагаа хязгаарлагдах гээд байгаа юм. Тэгэхээр энийгээ нэрийг нь өөрчлөөд, ер нь бодлогынхоо дагуу... /минут дуусав/

Б.Бейсен: Дэмжих юм байна. Тийм ээ. Санал хураалт. 58,8 хувиар санал дэмжигдлээ.

Одоо 3 дахь зарчмын зөрүүтэй санал. Үүрийнтуяа, Болормаа, Сарнай, Ундраа, Нарантуяа-Нара, Эрдэнэбат, Лодойсамбуу, Мөнхсайхан, Батчимэг, Энхцэцэг гишүүдийн санал байна.

Үндэсний аудитын газрын дүгнэлтээр зураг төсөвгүй, төслийн шаардлага хангаагүй 4 арга хэмжээ нийт 99,2 тэрбум төгрөгийн 31,4 тэрбум төгрөгийг бууруулан хасаж, цэцэрлэг, сургууль, дотуур байрны хүүхдийн хоолны материал худалдан авах зардлыг 10 хувь буюу 31,4 тэрбумаар нэмэх гэсэн байна.

Тэгэхээр энэ ийм асуудал байгаа. Түрүүчийн нөгөө уур амьсгалын өөрчлөлтийн НҮБ-аас явуулж байгаа энэ дээр манай Ерөнхийлөгч бас оролцсон.

Байгаль орчны яамныхан, эрдэмтдийн зөвлөл, залуучуудын хувийн хэвшлийнхэн бүгд оролцсон. 2026 онд энэ манай яг энэ арга хэмжээ явагдах юм. Тэгэхээр чинь төсвийг нь бас тавихгүй бол зураг төсөв байхгүй гэдгээр хасаж бас болохгүй байх гэсэн асуудал байна. Энэ талаар Байгаль орчны яам тайлбар ярих уу. Үүрийнтуяа гишүүн саналаа тайлбарлаад, дараа нь Байгаль орчны яам тайлбар хийнэ үү.

Д.Үүрийнтуяа: Байнгын хорооны дарга, гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ зарчмын зөрүүтэй санал яагаад Байгаль орчны байнгын хороогоор оров гэж. Тэгэхээр гол нь эх үүсвэр талдаа байгаа юм. Эх үүсвэр талыг би тайлбарлах нь зүйтэй байх. Үндэсний аудитын газрын 2025 оны төсөвт өгсөн аудитын дүгнэлтийн дүгнэлт хэсгийн 12 дээр Төсвийн хуулийн шаардлагыг хангаагүй, төсөлд тавигдах шалгуурыг хангаагүй, зураг төсөв байхгүй 99,2 тэрбум төгрөгийн 4 арга хэмжээ туссан байгааг аудитын дүгнэлт гарсан байгаа. Үндэсний аудитын газраас энэ 4 ажлын жагсаалтыг нийт төсөвт өртөг санхүүжих дүнгээр нь авсан. Энд бол Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцтай холбоотой 2 ажил, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцтай 1, Барилга, хот байгуулалтын сайд буюу Эдийн засгийн байнгын хороонд хамааралтай 1 асуудал байгаа юм.

Тэгээд энэ оруулж байгаа 31,4 тэрбум төгрөг яагаад эх үүсвэр шаардлагатай болчхов гэхээр сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны материалын зардлыг 10 хувиар хасах зардал дотор оруулчихаад байгаа юм. Тэгээд энэ нь болохоор 31,4 тэрбум төгрөгийн зардал хасагдаж байна гэсэн үг. Одоо 4300 төгрөг байгаа. Үүнийг 2025 оны сая хүчингүй болсон хуульд бол 6600 болгохоор санал оруулсан. Тэгээд энэ 6600-аа дахиад 10 хувиар хасахаар 5940 төгрөгөөр дотуур байрны хүүхдүүд гэхэд өдрийн 3 хоол, 2 унд идэх ёстой болж байгаа байхгүй юу. Аяга кофены мөнгө хүрэхгүй.

Тийм учраас энэ 31,4 тэрбум төгрөгийг хасахгүйгээр шийдвэрлэх нь зүйтэй. Хүүхдүүдийнхээ төлөө гэж байгаа. Тэгээд хамгийн гол нь энэ 4 ажлыг яагаад авсан бэ гэхээр нэгэнт Төсвийн тухай хуулийг зөрчиж орж ирж байгаа бол зураг төсөвгүй ажил төсөвт тусгагдахыг хуулиар хориглочихсон. Тийм учраас энэ 4 ажлаас 2 ажил дээр нь оруулж байгаа. Саяын таны хэлдэг, Байнгын хорооны даргын хэлдэг КОП-ын зардал руу бол ороогүй. 4 ажлын 1 нь энэ байгаа 50 тэрбум. Энэ рүү бол ороогүй. Төрийн албан хаагчийг орон сууцжуулах хөтөлбөрөөс 30 тэрбум. Энэ бол Эдийн засгийн байнгын хороон дээр яригдана. Гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах гээд сайдын багц дээр 13,2 тэрбум байгаа юм. Эндээс л 1,4 тэрбумыг л бууруулж өгөөч ээ гэсэн хүсэлт байгаа юм. 13,2-ыг бүтнээр нь биш 1,4-ийг л хасаж өгөөч ээ. Яагаад гэвэл зураг төсөв нь хийгдээгүй. Энэ ажлууд дэмжигдээд ордог юм гэхэд зураг төсөв нь хийгдээгүй байгаа, магадлал ороогүй байгаа ажил бол зураг төсвөө хийгээд, магадлалаа хийгээд явахад ирэх 2025 ондоо бүтэн санхүүжих магадлал бол бас бүрэн дүүрэн биш ээ. Тийм учраас 1,4 тэрбумыг нь шилжүүлээд явчих боломжтой байна гэж үзэж, яг одоо Байгаль орчны байнгын хороонд хамаарах асуудал бол энэ хөв цөөрөм байгуулах зардлыг л 1,4 тэрбумаар бууруулж өгөөч өгөөч ээ гэсэн санал байгаа.

Б.Бейсен: Байгаль орчны сайд тайлбар хэлье.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ жил манай хөрөнгө оруулалт бол 77 тэрбум байгаа. Эндээс КОП-ын хурлын 50-г хасчихаар ердөө 22 тэрбум байгаа юм. Тэгэхээр энэ бол байгаль орчны салбарын хувьд бол үнэхээр бага тоо. Та нар

бусад зарим яамнуудыг хараарай. 400, 500 тэрбумаар явж л байгаа. Тэгэхээр бүхэл бүтэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын хөрөнгө оруулалт 22 тэрбум. Би энэ дээр яагаад юм хэлээгүй вэ гэхээр ямар ч байсан энэ КОП-ын хөтөлбөрөө авч үлдэхийн тулд энэ удаадаа тэгээд л дуугай байсан. Тэгээд л аль болохоор гаднын хөрөнгө оруулалтаар юмаа хийх гээд үзэж байгаа юм. Тэгэхээр манай энэ гадаргын усны юу чинь нөгөө хөв цөөрмийнх нь бүх ТЭЗҮ, зураг төсөв нь 2024 ондоо гарч хасан юм. Тэгэхээр энэ гадаргын усны төсвөөс бид нар хасаад явах юм бол эргээд л нөгөө бүх гадаргын усаа гадагшаа алдаад, тэгээд л усгүй л болох ийм аюулд учрах юм шүү дээ. Одоо Монгол орны хөв цөөрөм энэ мөнх цэвдгүүд чинь бүгд хайлаад явж байгаа. Бид нар ерөөсөө гадаргын усаа л барьж үлдэхгүй бол ямар ч усгүй болоод байгаа. 98,2 хувь нь гадаргын ус шүү дээ Монгол орны. Тэгэхээр бид бол эндээс хасаад хэцүү л байх. Би зүгээр яг алийг нь гэдгийг нь энэ дээр олохгүй л байна л даа. Яг хэд гэдгийг нь.

Б.Бейсен: Үүрийнтуяа гишүүний саналаар бол энэ төрийн албан хаагчдын орон сууцжуулах цогц хөтөлбөрийн 90 тэрбумын 30 тэрбумыг нь уу. 30-ийн 30-ийг юм уу. Гадаргын усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах баруун бүс гэж байна. Үүнээс 1,4-ийг гэж байгаа юм уу. 13,2-оос нь 1,4-ийг хасах.

Шууд санал хураачихъя. Гишүүд анхаарал тавиарай санал хураалт. 11,8 хувиар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт хурааж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлэг хийсэн талаар Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

14.05 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. **Монгол Улсын 2025 онд төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл анхны хэлэлцүүлэг явуулъя.**

Ажлын хэсэг хэвээрээ байгаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье.

Гишүүд та бүхэнд тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрөөтэй санал гаргаж болно.

Эхлээд **Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулъя.**

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу. Амгаланбаатар гишүүнээр тасалъя. Бат-Эрдэнэ гишүүн бас байна уу. Бат-Эрдэнэ гишүүн, Амгаланбаатар гишүүнээр тасалъя. Амгаланбаатар гишүүн асуулт асууя.

О.Амгаланбаатар: Төрийн хэмнэлтийн хуулийг бас өөрчлөх, сайжруулах, цаашлаад бүр хүчингүй болгох, бүтээмжийн хууль болгох талаар бас 69 гишүүн гарын үсэг зураад, Засгийн газарт шаардлага хүргүүлсэн. Энэ төрийн хэмнэлтийн хуульд орж байгаа энэ өөрчлөлтүүд бол нэр төдий өөрчлөлтүүд байх шиг байна. Дээр нь дахиад энэ хэмнэлтийн хууль хөдөө орон нутагт хэрэгждэг. Улаанбаатар хотын яамдад, төв газраа бол хэрэгждэггүй ийм л хууль болчихоод байгаа. Тэгээд тэр хэмнэлтийн хуулийг өөрчлөх, сайжруулах, бүтээмжийн хууль болгож оруулж ирэх талаар бас та хэдэд бас мэдсэн, сонссон юм байна уу. Засаг дээр бас иймэрхүү яриа яригдсан юм байгаа юу.

Б.Бейсен: Асуултад Сангийн яамны Ганбат дарга хариулах уу. 9 номер.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Хэмнэлтийн хуулийг өөрчлөх талаар энэ Засгийн газрын үед бол асуудал одоогоор яригдаагүй байна. Өмнө нь бол яах вэ ЗГХЭГ дээр өмнөх Засгийн газрын үед орон нутаг болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэхэд хэрэгжүүлэхтэй холбоотой сайжруулах зарим нэг асуудлыг тодотгох байдлаар санал бол ЗГХЭГ-т нэгтгэж байсан ийм юмнууд бол байсан. Энэ засгийн үед бол тэгж асуудал яригдаагүй байгаа.

Б.Бейсен: Амгаланбаатар гишүүн тодруулъя.

О.Амгаланбаатар: Хэмнэлтийн хууль хэрэгжсэнээрээ яг хэдэн төгрөг хэмнэгдсэн бэ. Тийм яг тооцоолол байна уу.

Б.Бейсен: Ганбат дарга 9 номер хариулъя.

Ж.Ганбат: Хэмнэлтийн хууль хэрэгжиж 2022 онд бол 330 гаруй тэрбум төгрөг хэмнэгдэж байсан гэдэг ийм тооцоолол гарч байсан. 2022, 2023 онд нийлээд 330 орчим тэрбум төгрөг Хэмнэлтийн хууль батлагдсанаас хойш бол хэмнэгдэж ийм үр дүн гарсан юм байна. Одоо энэ оны 2024 оны санхүүгийн тайлан хавар гарахаар энэ дүн бол нэмэгдээд гарна.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хүн байгаа болов уу. Энэ төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт яах вэ, тодорхой хэмжээнд Ганбат дарга сая бас хэллээ. Мөнгөн дүнгээр нь хэлж байх шиг байна. Жишээлэх юм бол төрийн албан хэрэгцээнд ашиглах ёстой авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудлууд байгаа. Би нэг зүйлийг ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4 дээр заасан заалттай. Гэтэл энэ төрийн албаны тодорхой дарга нар яагаад 2 дугаартай яваад байдаг вэ гэдгийг би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Цагаан дугаар нэг хэрэглэх юм. Тэгээд шүүмжлэл дагуулаад, асуудал үүсээд эхлэнгүүт цэнхэр болчих юм. Тэгээд байж байтал

дахиад цагаан болчих юм. Энэ хуулийн хэрэгжилт яг хаанаа ингэж займчуулаад байгаа вэ гэдгийг 1 дүгээрт ойлгохгүй байна. Тэгээд энэ дээр би хариулт авмаар байгаа юм.

2 дугаарт Төрийн хэмнэлтийн тухай хуульд зарчмын зөрүүтэй саналд оруулъя гэсэн саналтай байгаа. Өөрөөр хэлбэл энэ Засгийн газрын болон Улсын Их Хурал, Ерөнхийлөгчөөс зарлигаар явж байгаа ч юм уу, тэмдэглэлт байгаагаас бусад ой, тэмдэглэлт баяр ёслол, биеийн тамир, спортын арга хэмжээтэй холбоотой асуудлууд бий. Маш их хэмжээний ойн медаль хэвлэж байна. Ойн медалиудыг хэвлээд л болсон, болоогүй баахан медаль БНХАУ-д хэвлүүлээд л манай ой болж байгаа гээд л. Ингээд л энгэрт нь зүүж өгөөд л явуулах юм. Энэ төрийн хэмнэлтийн тухай хууль дээр бас зарчмын зөрүүтэй санал гаргаж, энийг би энд нь бичээд өгчихье. Гаргах саналтай байна. Тэгээд эхнийхээ асуултад би хариулт аваад тэгээд тодруулъя. Баярлалаа.

Б.Бейсен: Ганбат дарга 9 номер хариулъя.

Ж.Ганбат: Яах вэ таны хэлээд байгаа тэр цагаан, цэнхэр дугаар гээд энэ автомашин, авто тээврийн хэрэгслийн дугаар олгох асуудал бол авто тээврийн бүртгэл хариуцсан АТҮТ энийг бол олгож байгаа. Зүгээр яах вэ, хэрвээ 1 машин дээр цагаан, хөх ийм 2 номер олгож байгаа асуудал байвал энэ өөрөө хууль зөрчсөн асуудал шүү дээ. Яах вэ ийм асуудал байвал бид хууль хяналтын байгууллагад шилжүүлж, бас шалгуулах нь зүйтэй болов уу. Ер нь бол АТҮТ ингэж 1 машин дээр 2 номер олгох ийм хуулийн бол үндэслэл бол байхгүй. Яах вэ олон нийтийн иргэдийн хяналтын дагуу хөх номер зүүх ёстой машин цагаан номер зүүж байна гээд энэ дагуу ТӨХ, ЗГХЭГ-аас нэлээн өргөн хүрээтэй бол шалгалтыг явуулсан. Энэ хүрээнд бол төрийн байгууллагуудын автомашин бол ерөнхийдөө бол бүрэн бол хөх номерт бол шилжсэн гэдэг ийм байдлаар үзэж байгаа. Хэрэгжилт дээр нь Үндэсний аудитын газар бол жилийн эцсээр хяналт тавиад явах ийм байгаа.

Ой тэмдэглэхтэй холбоотой асуудлыг ямар нэгэн ойн медалийг хийлгэх энэ төсвийг бол бид тавьж өгдөггүй байгаа. Ийм зориулалтаар бол төсөв бид баталж өгдөггүй байгаа. Зөвхөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар дээр одон медальтай холбоотой зардал төсөв дээр бол тусгагдаж байгаа. Яах вэ орон нутгийн хувьд бол сумууд болон аймгууд өөрсдөө сум, аймгийн ИТХ-аараа бас энэ асуудлуудыг албан ёсоороо хэлж батлуулаад, энэ хүрээндээ тухайн аймаг, сумын ойн медалийг хэвлүүлэх асуудал бол орон нутгийн түвшинд бол иргэдийн Хурлын зөвшөөрөлтэйгөөр хийгдсэн ийм асуудлууд бол гарч байгаа. Энэ дээр бас мөн Үндэсний Аудитын газар бол шалгалт хийж, гүйцэтгэл дээр нь хяналт тавьж ажилладаг. Сангийн яам дээр бас Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас бас хяналтыг тавьж, яг энэ дээр хууль зөрчсөн асуудлуудыг нь бол хянаж шалгаж холбогдох хуулийн дагуу арга хэмжээг бол авч ажилладаг байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм Ганбат даргын эрхэлсэн хүрээний асуудал биш болчихоод байгаа юм л даа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх агентлагийн л асуудал болчихоод байгаа учраас би Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хүн байна уу гээд асуугаад байгаа нь энэ. 9762УЕМ, 8942 УАТ, 9879 УНУ, 0371 УБҮ ингээд дурдвал надад маш олон дугаарууд байна. 100

хувь төрийн албаны машиныг 100 хувь цэнхэр дугаартай хуулийн хүрээнд болгосон гэж байгаа бол эдгээр дугаартай машинууд хаанаас цагаан дугаараа олж аваад байна вэ гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр энэ бол хуулийн зөрчил. Бид нар хууль нэг мөр л хэрэгжих ёстой. Төрийн албаны үйлчилгээнд явж байгаа авто тээврийн хэрэгслүүд бүгд цэнхэр болоод, дарга нарынх нь цагаан давхиад байж болохгүй. Тэгвэл төрийн хэмнэлтийн хууль байсны ч хэрэг байхгүй болчхож байгаа юм.

Тэгэхээр энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх болон хяналт үнэлгээний агентлаг хүн байвал энэ дээр хариулж өгөөч ээ. Энэ бол төрийн албаны тухай хуулиар санкцтай, тодорхой хариуцлага тооцох ёстой. Энэ дээр ямар хэмжээний зөрчил дээр ямар хариуцлага тооцсон бэ гэдэг ийм хариултыг авмаар байгаа юм. Нэгэнт Төрийн хэмнэлтийн тухай хуульд бид нар өнөөдөр тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг оруулах, энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг хөндөж байгаа бол олон нийтээс ирж байгаа ялангуяа энэ Шилэн Цогоо гэж яриад байдаг иргэн Цогтгэрэлээс ирүүлж байгаа энэ мэдээллүүд бол үндэслэлтэй шүү дээ.

Тэгээд энийг нь манайхан одоо ингээд тодорхой хэмжээнд Байнгын хороонууд дээр үгүй ээ, тийм юм байхгүй гээд суугаад байдаг. Гэтэл өнөөдөр ч гэсэн Улаанбаатар хотын гудамжинд цэнхэр дугаараа цагаантай тавиад л давхиж байгаа маш олон тээврийн хэрэгслүүд төрийн үйлчилгээнд явах ёстой авто тээврийн хэрэгслүүд хувийн хэрэгцээнд явсаар л байгаа.

Б.Бейсен: Ганбат хариулъя. Саяын таны хэлсэн дугааруудыг би тэмдэглэж аваад бас энэ дээр нь нөгөө хяналт шалгалт хэрэгжүүлэх агентлагт бас өгье. ЗГХЭГ, АТҮТ-д өгөөд шалгуулаад хэрвээ ийм хууль зөрчсөн асуудал байвал эргээд танд бас тэр байгууллагуудыг хариу өгүүлээч ээ гэдгээ бас уламжилъя.

Б.Бейсен: 1 санал байгаа юм байна.

1 дүгээр зүйлийн 15.1.9 байгууллагын төсвөөр түүхэн үйл явдлын ой, салбарын зарим ажил мэргэжлийн тэмдэглэлт өдөр, бусад тэмдэглэлт өдрийг тэмдэглэх гэж нэмэх. Санал гаргасан Бат-Эрдэнэ гишүүн. Тайлбар хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Саяын л нөгөө одон медальтай холбоотой асуудал байхгүй юу. Одоо агентлагууд ингээд болсон болоогүй баахан одон хэвлэх юм. БНХАУ-д баахан тэмдэглэлийн дэвтэр. Мөнхтулга гишүүнийг шүүмжлээд байсан шүү дээ. Нийслэлээс гишүүн болгонд нэг ийм ойгоор нь ийм том бэлэг ирлээ гээд л. Одоо бид нар цаашдаа энэ Хятад ард улсад үйлдвэрлэгдэж байгаа энэ дэвтэр, бал, үзэг бие биедээ бэлэг өгөх байдлаар төрийн албанд явж байгаа энэ хэвшлээ болихгүй юм уу. Энийг л больё гэж байгаа юм. Дээрээс нь татвар төлөгчдийн мөнгийг бид нар энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулиар угаасаа л Төрийн хэмнэлтийн тухай хууль бол арвилан хэмнэх, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль шүү дээ. Тэгэхээр энэ төрийн албанд явж байгаа татвар төлөгчдийн мөнгөөр худалдан авалт хийж байгаа дарга нарын энэ баахан үргүй зардлыг больё л гэдэг саналыг гаргаж байгаа гэсэн үг. Баярлалаа.

Б.Бейсен: Санал хураалт. 35,3 хувиар дэмжигдсэнгүй. Санал хураалт явагдаж байна. Гишүүд хуралдаа ирээрэй. Ганхүлэг гишүүн горимын санал гаргая.

М.Ганхүлэг: Нөгөө санал хураалтын төхөөрөмжтэй холбогдолтой бас асуудал байна. 2, 3 удаа бас саналаа өгч чадахгүй гацаад байна. Дээрээс нь ирцээ сайн шахаж байгаад саяын асуудал дээр бас сайн ярилцаж байж, мэдээлэл өгөөд саналаа бас хураалгах нь зөв байх. Одоо байгаа гишүүд маань ер нь бас ирц хүрэхгүй байдалтай бас байна. Тэгэхээр саяын санал хураалт дээр минийх бас төхөөрөмжийн алдаанаас болоод эсрэг санал өгчихлөө. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Б.Бейсен: Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Ганхүлэг гишүүний горимын саналаар. 47,1 хувиар хүчингүй болгож дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл тус бүрээр нь хэлэлцэж дууслаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар асуулт асуух гишүүд нэр өгнө үү. Нэр өгөөгүй. Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Дээрх тогтоолын төсөлтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар асуулт асуух гишүүд нэр өгнө үү. Байхгүй байна.

Дээрх тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг

Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

14.25 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалд оръё.

Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсъё.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдож хүрэлцэн ирсэн ажлын хэсэг хэвээр байгаа. Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, Энхтөр Жижиг, дунд үйлдвэрийн газрын Зээл, төслийн хэлтсийн дарга.

Мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Эрдэнэсайхан хийнэ.

Я.Эрдэнэсайхан: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 2009 онд анх үүсгэн байгуулагдсан. Засгийн газрын тогтоолоор. Анх бол 1993 онд Үйлдвэр худалдааны яам Жижиг дунд үйлдвэрийн хэлтэс гэсэн нэрээр анхны суурь нь тавигдаж байсан. Ингээд Үйлдвэр худалдааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөлмөрийн яам зэрэг байгууллагуудад бол сан шилжиж явсан.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль гэсэн 2 гол хууль дээр үндэслэж үйл ажиллагаагаа явуулдаг. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль дээр бол ЖДҮХС-ийн эх үүсвэрийг ямар зориулалтаар зарцуулах талаар заасан байдаг. Жишээ нь Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн хүүгийн татаас олгох, тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх, бизнес инкубацын зөвлөгөө өгөх, сургалт давтан сургалтад хамруулах, судалгаа шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлэх, үзэсгэлэн худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах, сангийн өр төлбөрийг барагдуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх гэсэн ийм үйл ажиллагаануудад бол зарцуулдаг.

2019 онд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд бол шинэчилсэн найруулга оруулж, Улсын Их Хурлаар батлагдсан. Үүний дагуу 2020 онд Засгийн газрын тогтоол гарсан. Үүнээс өмнө 2009-2019 оны хооронд бол 10-аад удаа энэ журамд өөрчлөлт оруулсан байдаг. 2020 оны энэ журам бол Засгийн газраар батлагддаг болсон. Засгийн газрын тусгай сангийн хуулиараа. Үүний гол ач холбогдол нь бол сангийн журмыг Засгийн газрын гишүүн буюу сайд батлаад явдаг байсныг бол өөрчилсөн байгаа. Энэ журам бол өнөөдөр хүртэл тогтвортой мөрдөгдөж явж байгаа.

Сан нийтдээ 2009 оноос хойш 737 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс, Засгийн газрын бонд, Хөгжлийн банкны бонд, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн. Жишээ нь бол улсын төсвөөс 203 тэрбум төгрөг,

Засгийн газрын бондын 290, Хөгжлийн банкны бондын 193, орон нутгийн 19, бусад 31 гэсэн ийм эх үүсвэр бүрдүүлсэн. Энэ эх үүсвэрээсээ нийтдээ 8,928 төсөлд 1 их наяд 86 тэрбум төгрөгийн зээлийг бол олгосон ийм үр дүн гарсан байгаа. Энэ оноороо эхний график бол он оноороо тухайн жилүүдэд хэдэн тэрбум төгрөгийн зээлийг олгосон бэ гэдэг үзүүлэлт байна. Нийтдээ бол ер нь 2009-2024 оны хугацаанд 5 их наяд төгрөгийн санхүүжилт хүссэн 33 мянган төслийг санд ирүүлсэн. Үүнээс түрүүн хэлсэн 8,928 төсөлд зээл олгосон байгаа. Энэ нь бол нийт аж ахуйн нэгжийн зээл хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн 26,7 хувь, мөнгөн дүнгийнхээ бол 22 хувийг нь бол шийдвэрлэсэн ийм үр дүнтэй байгаа.

Цаана нь бол 70, 80 хувийг нь бол эх үүсвэрээс шалтгаалаад бол санхүүжүүлж чадаагүй гэсэн үг. Үүнээс 7,398 иргэн, аж ахуйн нэгж 854 тэрбум төгрөгийнхөө зээлийг бүрэн барагдуулсан. 80 хувь нь бол бүрэн барагдуулаад дууссан байгаа. Өнөөдрийн байдлаар бол нийтдээ санд 1530 зээлдэгчийн 228 тэрбум төгрөгийн авлага байгаа. Нийт олгосон зээлийнхээ өнөөдрийн байдлаар бол 12,7 хувь нь бол муу зээлийн ангилалд байгаа. Энийг бол хууль хяналтын байгууллагад хандаж, шийдвэрлүүлэхээр хөөцөлдөж байгаа. Энэ мэдээллийг хойно өгнө.

Ингээд мөн дээр олгосон зээлүүдийг хүнсний үйлдвэр, хөнгөн үйлдвэр, мал аж ахуй гэх мэтчилэн эдийн засгийн салбар чиглэлээр нь бол хувааж гаргасан байгаа. Нийтдээ 6600 үйлдвэрийг бол өргөтгөсөн, 2200 үйлдвэрийг шинээр барьсан байгаа. Энэ төслийн үр дүнд. Нийтдээ 54 мянган ажлын байрыг шинээр бий болгож, 39 мянган ажлын байрыг хадгалсан ийм үр дүн байна. Орон нутгийн хувьд бол нийтдээ 6 мянга гаруй нь бол одоо орон нутагт, 2400 нь бол Улаанбаатар хотод аж ахуйн нэгжийнхээ тоогоор бол зээл олгосон байгаа. Гэхдээ 47 хувь нь бол мөнгөн дүнгийнхээ 47 хувь нь бол орон нутагт, 53 хувь нь бол Улаанбаатарт олгогдсон байгаа. Энэ нийт олгогдсон зээлийн дүн.

Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулиараа бол хоршоо, нөхөрлөл, компани хэлбэртэй байна. 200 хүртэл ажилтантай, 2,5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой байх юм бол ЖДҮ гэж томьёолж байгаа. Энэ салбарт нийтдээ 293 мянган хүн ажиллаж байна. Ажлын байраар хангаж байна гэсэн үг. 72 мянган аж ахуйн нэгж энэ салбарт өнөөдрийн статистикаар бүртгэлтэй. Үүний 51 мянга нь бол нийслэлд, 21 мянга нь бол Улаанбаатар хотод байгаа гэсэн 2023 оны Статистикийн хорооноос гаргасан судалгаагаар байгаа.

2020-2024 онд агентлаг байгуулагдсан. Энэ хүрээнд бол нийтдээ 135 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг зөвхөн эргэн төлөлтөөсөө бүрдүүлсэн. Үүний 117 тэрбумыг бол 951 аж ахуйн нэгжид зээл болгож өгсөн байгаа. Энэ хүрээнд нийтдээ Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга, Их Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд бол хүнсний хангамж, аюулгүй байдал, Цагаан алт, Шинэ хоршоо, Тэрбум мод, орон нутагт шилжин суурьшиж байгаа иргэдийн Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд бол илүү зээлийг олгосон. Эндээс жишээ нь хүнсний хангамж, аюулгүй байдалд 494 аж ахуйн нэгжид 50 гаруй тэрбум төгрөгийн зээлийг олгосон байгаа. Энэ хүрээнд 5 жилийн хугацаанд бол 951 аж ахуйн нэгжид зээл олгосноор 5200 ажлын байрыг шинээр бий болгоод, 3500 ажлын байрыг хадгалсан, нийгмийн даатгал, татварын орлогоор 52 тэрбум төгрөгийг бол улсын төсөвт нэмэр болж явж байгаа. Ажлын байрыг олноор бий болгох, хадгалах, татвар, нийгмийн даатгалаар улсын төсөвт эргээд дэмжлэг болох ийм ажлууд бол хийгддэг.

Нийтдээ 80 тэрбум байх ёстой. Агентлаг байгуулагдсанаас хойш бол хууль, тусгай активын хэлтэс гэж муу ангилалд өмнө олгогдсон байсан зээлүүдийн араас хөөцөлдөх ийм нэгжийг байгуулсан. Энэ хүрээндээ 2019 онд гэхэд 2 тэрбум төгрөг, 2020 онд 7, 2021 онд гээд ингээд өсөөд явсан. Нийтдээ 2023 онд 19 тэрбум төгрөгийг зээлийн муу ангиллаас бол төлүүлсэн. 2024 оны хувьд бол 9 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 21 тэрбум төгрөгийг бол үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгөөр бол барагдуулсан. Энэ ямар учиртай юм бэ гэхээр тэр доор нь байгаа Капитал банк 2018, 2019 онд дампуурсан. Үүнтэй холбоотойгоор бид 2023 оноос өмнө бол зөвхөн мөнгөн хөрөнгөөр барагдуулах чиглэлд илүү анхаарч ажиллаж байсан бол мөнгөн бус хөрөнгөөр авахаас өөр аргагүй нөхцөл байдал үүссэн.

Өөрөөр хэлбэл Капитал банкнаас мөнгөн бус хөрөнгөөр авахгүй бол мөнгөн хөрөнгөөр барагдуулах ямар ч нөхцөл байхгүй. Нөгөө банкны өр барагдуулах хуулиараа болохоор 8 дугаарт байдаг. Ингээд даатгалтай хадгаламж эзэмшигч, даатгалгүй хадгаламж эзэмшигч, ингээд төрийн Эрүүл мэндийн даатгалын сан гэх мэт өрийг барагдуулж явж байгаа 8 дугаарт нь энэ ЖДҮХС-ийн өрийг барагдуулах ийм дараалалтай. Тэгэхээр нөгөө мөнгөн хөрөнгө бол ямар ч боломжгүй болж байгаа. Ингээд бид нар бас энийг сайдаар тушаал гаргуулаад, нийтдээ 21, 22 тэрбум төгрөгийг бол үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгөөр авсан байгаа. Бид нар журамдаа өөрчлөлт оруулахаар яамнуудаас санал аваад, удахгүй Засгийн газраар хэлэлцүүлнэ. Өмнө нь түрүүний олгосон 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан журмаар бол бид нар мөнгөн хөрөнгөөр барагдуулах талаар ярьж байсан бол одоо мөнгөн бус хөрөнгөөр барагдуулаад, үүнийгээ дуудлага худалдаагаар байна уу, ямар нэгэн хэлбэрээр мөнгөн хөрөнгө болгож дараачийн зээлийг гаргах ийм шаардлага бол үүсэж байгаа амьдрал дээр.

Өнөөдрийн байдлаар бид нар эрэн сурвалжлах ажиллагаатай буюу цагдаагийн байгууллага, шүүхээр хайгаад явж байгаа 3 зээлдэгчийн 1,5 тэрбум төгрөг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа буюу шүүхэд хандаад явж байгаа 55 зээлдэгч, шүүхийн шийдвэр нь гарчхаад, энийгээ төлөөд явж байгаа 38 зээлдэгч, шүүхийн шийдвэр нь гараад, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдээд явж байгаа 78 зээлдэгч, ингээд хөөн хэлэлцэх хугацаа дууссан, нас барсан, гадагшаа гарсан гэх мэт зээлдэгчид л 114 зээлдэгч дээр зөвлөх үйлчилгээ аваад, зөвхөн манай энэ хэлтэс 5 хүн байдаг 4, 5 хүн. Энэ хүчээр шүүх хуралд ороод бүх шатын шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хууль хяналтын байгууллагад ажиллахаас гадна энэ нөгөө байнгын зээлдэгчтэй харилцах ийм хүч хүрэхгүй байгаа учраас энэ зөвлөх үйлчилгээг авсан. Зөрчил барагдуулах ажиллагаа хийгдээд, манайх өөрийнхөө нөхцөл бололцоогоор төрийн албан хаагчдаараа төлье гээд график гаргаад, төлөөд явж байгаа аж ахуйн нэгжүүд бол 34 аж ахуйн нэгж ингэж ажиллаж байна. Он гараад бол 48 зээлдэгчийн энэ муу ангиллын зээлдэгчдийн өрийг бол бүрэн төлж барагдуулсан ийм ажлыг хийсэн байна.

Ер нь ЖДҮ-ийн агентлаг байгуулагдсанаас хойш нийт олгогдсон зээлийг бол өмнө олгогдсон зээл болон одоо олгогдож байгаа зээлийг бүгдийг нь шилэн болгосон. Үйл ажиллагааг ил тод болгосон. Цахимаар бүх мэдээллийг өгдөг болсон. 2020 оноос хойших үйл ажиллагаа дээр бол гомдол тэмцэл, өргөдөл гомдол гарсан ч гэсэн хууль хяналтын байгууллагад шалгагдаад энэ нь бол үндэслэлгүй байна буюу өөрөөр хэлбэл ямар нэгэн авлига, ашиг сонирхлын асуудал байхгүй байна гээд ингээд явж байгаа. Ийм учраас АТГ-аас бол төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд оноо өгөөд эзлүүлдэг. Шударга байдлын

үнэлгээгээр 2021 онд ЖДҮ-ийн 2018 онд ЖДҮХС энд орох ямар ч боломжгүй буюу хамгийн сүүлийн байр эзэлж байсан бол 2021 онд бол 2 дугаар байр, 2022 онд 1 дүгээр байранд орсон. Өөрөөр хэлбэл бүх үйл ажиллагаа ил тод, шилэн болсон байна. Сонгон шалгаруулалт бол хууль номын дагуу, ямар нэгэн ашиг сонирхлоос ангид явж байна гэдгийг мэргэжлийн байгууллагаас судалгаагаар гаргаад, тогтоосон.

ЖДҮ-ийн газар жилдээ олгож байгаа зээлийн хэмжээ, хаана, аль аймагт, аль сумд, ямар төсөл, ямар дүнтэй хэрэгжиж байгаа, үлдэгдэл нь хэд байгаа гэдэг мэдээллийг бол өөрийнхөө sme.gov.mn сайт болон shilen.gov.mn-ээр бол байнга мэдээлээд явдаг. Одоо ямар ч иргэн ороод, энд аль аймгийн, ямар төсөл хэдийг хэдийг авсан байна, одоо хэдий үлдэгдэлтэй байна, чанартай, чанаргүй байна уу гэдэг бүх мэдээллийг авах боломжийг бол бүгдийг нь хангасан байгаа.

2025 оны хувьд бол бид нар үндсэн төлбөрөөсөө 28 тэрбум төгрөг, хүү, хөшүүргээс 8 тэрбум гээд нийтдээ 36 тэрбум төгрөгийг бол төвлөрүүлэх ийм боломжтой байгаа. ЖДҮХС одоо ЖДҮ-ийн газарт шилжиж ирэх буюу агентлаг байгуулагдах үед бол бусдад төлөх 123 тэрбум төгрөгийн өртэй байсан. Хөгжлийн банкны бонд, Засгийн газрын бондын өртэй байсан. Энийг бол бид нар өнгөрсөн хугацаанд 2022 он хүртэл бүгдийг нь төлж барагдуулсан. Өнөөдөр өөрөөр хэлбэл ЖДҮ-ийн газар гэдэг айл бол бусдад төлөх өр төлбөргүй болсон. Одоо орж ирсэн мөнгөө бусдад зээл болгоод ингээд өгөөд явж байгаа.

Аудитын дүгнэлтээр бол 2016, 2017 онд сөрөг дүгнэлттэй, 2018 онд бол дүгнэлт өгөхөөс татгалзаж байсан бол үүнээс хойшоогоо бол хязгаарлалттай дүгнэлт өгч байгаа. Өөрөөр хэлбэл тодорхой хэсэг дээр асуудал байна. Энэ нь бол зээлийн эргэн төлөлтөө сайжруулах тал дээр асуудал байна. Түүнээс ил тод байдал, бусад юм нь бол асуудалгүй байна гэсэн ийм дүгнэлтийг бол өгөөд явж байгаа. Ер нь бид нар өнгөрсөн хугацаанд нэгтгээд дүгнээд хэлэх юм бол ямар ажлуудыг хийсэн юм бэ гэхээр бусдад төлөх өр төлбөрийг бүрэн барагдуулсан. Орон нутгийг бид нар энэ сангийн эх үүсвэрээ нэмэгдүүлэхийн тулд бол орон нутгийн төсөвт орон нутгуудтай болон гадаадын төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллаж байгаа. Жишээ нь Өмнөговь аймаг гэхэд өнгөрсөн хугацаанд 12 тэрбум төгрөг, Сүхбаатар аймаг, Завхан аймаг, Орхон аймаг, Дархан аймаг гээд аймгууд бол орон нутгийн төсөвтөө мөнгө тавиад, ЖДҮХС-аас нэмж мөнгө өгөөд ингээд эх үүсвэрийг бүрдүүлээд, тухайн орон нутагт нь зээлийг нь олгоод тухайн аймгийн Засаг даргатай гуравласан гэрээгээр байгуулсан гэрээнийхээ дагуу яг аль салбар чиглэлд өгөх вэ гэдэг салбар чиглэлээ тогтоогоод, ингээд олгоод явдаг болсон. Сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн. Энэ хүрээнд бол нийтдээ 17 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бий болгосон. 5 жилийн хугацаанд бол олон ажлын байрыг шинээр бий болгосон. Татвар, нийгмийн даатгалд нэмэр болж явж байна. Зээлээ олгохдоо даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн. Өөрөөр хэлбэл эрсдэл үүссэн тохиолдолд бол нөгөө зээлдэгчтэй хөөцөлдөхөөс гадна даатгалын байгууллагуудаар даатгуулаад, үүний эрсдэлийг бол бууруулж байгаа. Төслийн үйл ажиллагааг бол газар дээр нь очиж заавал үздэг болсон. Хуучин бол төсөл аваад хэрэгжихгүй байна. Хоосон цаасны төсөл хэрэгждэг байна гэсэн асуудал бол байхгүй болсон. Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг олон улсын арга аргачлалын дагуу Score-ийн систем нэвтрүүлээд бол бүрэн ил тод, нээлттэй болсон. Зээлдэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд тулгуурлаад багцыг бий болгосон. Энэ хүрээндээ хүртээмж бол 2018 онтой харьцуулахад 5 дахин нэмэгдсэн. Орон нутгаас түрүүний санхүүжилт бий болгосон тохиолдолд эрхийг нь шилжүүлж байгаа. Мөн орон нутаг дээр төсөл

сонгон шалгаруулалт хүсэлт ирүүлж байгааг бол аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаад, сонгон шалгаруулалтын эрхийг нь бол аймаг орон нутагт нь ингээд олгоод явж байгаа. Хууль хяналтын байгууллагаар өнгөрсөн агентлаг байгуулагдсанаас хойш бол чанаргүй ангиллаас 80 тэрбум төгрөгийн найдваргүй авлагыг бол барагдуулаад байна.

Бид цаашид бас ямар үйл ажиллагаа явуулах юм бэ гэхээр мэдээж Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн санаачилсан төсөл хөтөлбөр буюу хүнсний хангамж, аюулгүй байдал, Тэрбум мод, Шинэ хоршоо гэх мэт хөтөлбөрүүдийг бол дэмжих чиглэлээр ажиллана. Зээлийнхээ эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэхийн тулд орон нутгуудтайгаа бол хамтарч бас ажиллана. Бүх аймгуудын Засаг дарга, Иргэдийн хурлын дарга нарт орон нутгийн төсөв дээрээ санхүүжилт тавихыг хүссэн бичгийг хүргүүлсэн байгаа.

Энд ингээд нөгөө хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа өөрөөр хэлбэл төсөв нь хүрэлцэхгүй байгаа энэ тохиолдолд бол шаардлага хангасан хэрэгжих боломжтой төслүүдийг олон улсын төсөл хөтөлбөр лүү санал болгож, холбох ийм ажлыг бид нар бас эхлүүлээд явж байгаа. Түрүүний ЭПАТ-ын төсөл гэх мэтчилэн төслүүд байна. Мөн төслийнхөө үр дүнг гаргаад явж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг олон нийтэд хүргэх, муу зээлдэгчдийг төлүүлэх ийм аян зохион байгуулахыг төлөвлөж байгаа. Үл хөдлөх хөрөнгөөр барагдуулсан энэ хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ийм журмыг бол боловсруулаад, удахгүй Засгийн газраар хэлэлцүүлэхээр байгаа гэх мэтчилэн ажлуудыг төлөвлөөд, ажиллаж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Нэрсээ өгнө үү. Мөнхтулга гишүүнээр тасаллаа. Отгонбаяр гишүүн асуулт асууя.

У.Отгонбаяр: Өдрийн мэнд ээ, ЖДҮ-ийн сан ЖДҮ-ийн газар, агентлаг бол бас чамгүй сайн ажиллаж байгаа. Сүүлийн хэдэн жил бол бас Жижиг, дунд бизнес эрхлэгч хоршоод руу хандсан зээлийн үйлчилгээг ер нь давгүй сайхан үзүүлж байгаа гэж би хувьдаа ойлгож байгаа юм. Зүгээр эх үүсвэрийн хувьд бол бас жоохон дутагдалтай байхыг үгүйсгэхгүй. Саяын мэдээллээс харахад бол авлага нэлээн байгаа юм байна. Гэхдээ энэ дээр бол нэлээн бас гайгүй ажиллаад, жил жил авлага бол олж авч байгаа ийм график харагдаж байна л даа. Одоо ер нь үлдсэн авлагаас ер нь бүр найдваргүй болсон хэчнээн төгрөгийн зээл байна. Энэ дээр нэг мэдээлэл өгөөч. Энэ бол одоо бүр ямар ч найдваргүй болсон гэсэн ангилалд байгаа.

Б.Бейсен: Хариулт 5 номер.

Я.Эрдэнэсайхан: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. ЖДҮ-ийн газрын дарга Эрдэнэсайхан. Эх үүсвэр бол нэлээн дутагдалтай байгаа. 2020 оноос хойш бол улсын төсөв дээр ерөөсөө мөнгө төгрөг төсөвлөөгүй. Дандаа эргэн төлөлтөөсөө эх үүсвэрээ бүрдүүлээд, эсвэл орон нутаг, олон улсын төсөл хөтөлбөрөөс эх үүсвэр бүрдүүлж, явж байгаа. Ингээд 117 тэрбум төгрөгийг бол 4 жилийн хугацаанд зээл болгож өгсөн.

Авлага бол нийтдээ үндсэн төлбөр 229 тэрбум төгрөгийн авлагатай байгаа. Энэ үндсэн төлбөрийн авлага. Үүн дээр алдангиа тооцох юм бол 250, 260 тэрбум төгрөгийн авлага байгаа. Нийтдээ өнөөдөр бид нар хууль хяналтын байгууллагад

300 аж ахуйн нэгжийн 100 тэрбум төгрөгийн асуудлыг хууль хяналтын байгууллагын болон шүүхэд хандаад шийдвэрлүүлэх гээд явж байна. Үүнээс маш бага буюу 2, 3 хувь нь зээлдэгч нь нас барсан. Эсвэл гадагшаа гараад явчихсан ийм тохиолдол байгаа. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан. Бусдыг нь бол бид нар бүгдийг нь хууль хяналтын байгууллагаар эзэн холбогдогч нь байгаа тохиолдолд бол нэгэнт авсан учраас барьцаа хөрөнгөөр нь барагдуулах, шүүхийн шийдвэр гаргуулах ийм ажиллагааг бол үе шаттайгаар хийгээд явж байгаа.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Тэгэхээр үндсэндээ бол 100 хувь найдваргүй болчихсон зээл бол байхгүй юм шиг байна зөв үү. Тэгээд ямар ч байсан хөөцөлдөөд ганц, 2 одоо бурхан болсон ч гэдэг юм уу. Тэр дүнгүүд нь том юм уу. Хэчнээн төгрөгийн бүр найдваргүй тийм зээл байна вэ гэж.

Дахиад нэг юм бас тодруулаад асууя. 2019 онд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль шинэчилсэн найруулга бол батлагдсан. Энэ маань өнөөдөр бас яг нүдээ олсон, жишээ нь ЖДҮ эрхлэгчийн тодорхойлолт яг энэ ЖДҮ гэсэн энэ ангилалд багтаж байгаа зүйл заалтаараа ер нь хууль маань болж байна уу, болохгүй байна уу. Эсвэл шинэчлэх зайлшгүй шаардлага юм байгаа юу. Энэ чиглэлээр бас мэдээлэл өгөөч.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Эрэн сурвалжлах ажиллагаатай 3 зээлдэгчийн асуудал л хамгийн хүнд байгаа. Бусад нь бол эзэн холбогдогчтой, хууль хяналтын байгууллагад хандаад явж байгаа. 1,5 тэрбум төгрөгийн асуудал байгаа. Ер нь бид нар Монголбанкны зээлийн мэдээллийн санд энэ зээлдэгчтэй холбоотой мэдээллийг бол тогтмол нийлүүлж байгаа. Тийм учраас бусад банк санхүүгийн байгууллагаас зээл авах асуудал бол энэ найдваргүй зээлдэгчдийн хувьд хаагдаж байгаа учраас энэ аж ахуйн нэгжүүд зээлдэгчид маань бол зээлээ төлөхийг эрмэлзэж байгаа.

Дараачийн асуулт бол ЖДҮ-ийг дэмжих тухай хууль бол 2019 онд батлагдсан. Тухайн үеийнхээ шаардлагаар бол маш сайн хууль батлагдсан. Энэ дээр мэдээж өнөөдөр цаг үеийн шаардлагаар бас өөрчлөх асуудал бол байгаа. Таны хэлж байгаа яг үнэн байна. Тодорхойлолт бол 2,5 тэрбум төгрөг хүртэл жилийн борлуулалтын орлоготой гэж тухайн үедээ тооцож байсан. ЖДҮ-ийг дэмжих тухай хуулийг анх батлагдахад бол 1 сая доллар .../минут дуусав/

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Я.Эрдэнэсайхан: 1 сая орчим долларын борлуулалтын орлоготой бол жижиг дунд гэж тодорхойлж байсан. Энийгээ 2019 онд бас тухайн үеийн Монголбанкны ханшаараа ингээд тооцоолоод, 2,5 тэрбум гэсэн. Өнөөдөр энэ банкны ханшийг тооцсон ч тэр тухайн үед энийг бол бид нар бас нэмэгдүүлэх ёстой гэж байсан боловч бас өмнөх нь асуудал байсан. Том аж ахуйн нэгжүүд нь жижгийнхээ боломжоос бас илүү авах гээд байх юм байна. Тийм учраас энийг хэт өсгөх боломжгүй юм байна. Цаг үе нь болоогүй гэж үзэж байсан. Энэ цаг хугацаа бол өнөөдөр болсон байх гэж үзэж байгаа. Энэ бол үнэхээр энэ 2,5-ыг бол нэмэх шаардлагатай байгаа.

Б.Бейсен: Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Тэгээд Засгийн газрын энэ бүх л сангууд, ер нь бүх л сангууд тоногдоод дууслаа. Ганц номын сан үлдлээ гэж яригдаж байсан үе саяхан шүү дээ. Тэгээд сая би бас ЖДҮ-лэлийн сангийн энэ танилцуулгаас бас нэлээдгүй шилэн болж байгаа юм байна. Шилэн болох тусмаа янз бүрийн хардлага, мөн хууль бус зүйлүүд бол явах боломжгүй. Ийм механизмыг бас бүрдүүлж чадсан байна. Сайн ажиллаж байгаа юм байна гэж би бас дүгнэж байна. Нөгөө талдаа.

Тэгээд 2, 3 тодруулах юмнууд байгаа. 2018 оны үед байх. Тухайн үеийн Сангийн сайд бас л улсын төсөв хэлэлцэж байх үед жижиг дунд бизнесийг дэмжих дээр мөнгө тавьсангүй гээд Их Хурлын гишүүд хэлж байхад улсын хэмжээнд яг энд зориулагдсан 300, 400-аад тэрбум төгрөг эргэн төлөгдөхгүй байна. Тэрийгээ олж аваад, энийгээ хийх ёстой гэдэг зүйлийг бас хэлж байсан. Би андуураагүй бол. Тэгэхээр саяын энэ өр авлагын асуудал дээр 240-өөд тэрбум төгрөгийн авлага бас хууль хяналтын байгууллагад байгаа юм байна. Тэгэхээр энэ дээр илүү энэ өр авлагаа олж авах тал дээр ямархуу дэмжлэг бас хэрэгтэй байгаа вэ гэдэг дээр би нэгд асууя.

Тэгээд танай ЖДҮ-ийн сан дээр 2 дахь асуулт бол тэр ТЭДС энэ тэр гээд баахан сангууд байсан юм байна лээ. Тэд нар бас нийлээд явж байгаа юу. Тэр сангууд нь тусдаа юм уу. Нийлсэн бол тэр сангууд дээр байсан өр авлагын асуудлууд бас хаашаа яаж мухарлагдсан бэ.

3-д нь бол энэ сумдад олгож байгаа жижиг дунд бизнесийг дэмжих сангийн зээл гэж байж байгаа. Одоо хоршооны зээл болсон. Энэ сангуудтай ер нь танайх үйл ажиллагаагаа уялдуулдаг уу. Чиглэл, удирдлагаар хангаж ажилладаг уу гэж бас нэг ийм зүйл байна. Яагаад гэвэл энэ улсын хэмжээнд бас нэлээдгүй өндөр дүн гарах ийм мөнгө тэнд бас эргэлдэж байгаа. Энийг нэгдсэн удирдлагаар хангах нь зүйтэй болов уу гэж бас бодож байгаа юм.

Дээрээс нь сая хэлж байна. Та хууль, эрх зүйн хувьд бас жоохон зохицуулалтууд хэрэгтэй байгаа. Тэгэхдээ мөнгөн дүнг нь нэммээр байна гээд ярьж байна. Миний хувьд бол бас үйл ажиллагааг нь нэмэх, чиглэлийг нь нэмэх бололцоо байгаа юу. Жишээ нь адилхан бизнес эрхэлж байгаа хэр нь аль ч, хаанаас ч тийм хөнгөлөлттэй зээл, бусад тэтгэлэгтэй явж байгаа, татаастай явж байгаа салбарууд шиг явж чаддаггүй салбар бол аялал жуулчлалын салбар болж хувираад байна шүү дээ. Тэгэхээр аялал жуулчлалын бизнес бол бас энэ салбарыг хөгжүүлж байж Монгол Улсын эдийн засгийн дараагийн томоохон тулгуур болно гэж үзэж байгаа цаг үед танайхаас аялал жуулчлалын компаниуд зээл авах тэр бололцоог бий болгох, шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдийг тэнд материалаа өгөх ийм бололцоог бүрдүүлэх шаардлага байна уу даа гэж ингэж бас харж байгаа. Энийг бас та бүхэн юу гэж харж байгаа вэ гэж би тодруулъя.

Б.Бейсен: Хариулт авах юм уу. 5 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Идэрбат гишүүний асуултад хариулъя. 2018 онд бол бас 300 гаруй тэрбум төгрөгийн найдваргүй авлага гэж гарч байсан. Энэ бол өнөөдөр 100 тэрбум болж буусан байгаа. Өөрөөр хэлбэл энэ хооронд бол 200-аад тэрбум төгрөгийн найдваргүй авлагыг ямар нэгэн хэлбэрээр ангиллыг найдвартай болгох,

төлүүлэх ийм арга хэмжээнүүдийг бол хийсэн. Тийм учраас шилэн дээр бүх мэдээлэл орсны бас үр дүн энд гарсан гэж ингэж үзэж байгаа.

Дэмжлэг бол үнэхээр хэрэгтэй байгаа. Эрх зүйн орчны хувьд сайжруулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр маш их хугацаа шүүх дээр маш их хугацаа явдаг. Авсан зээлдэгчид маань шүүх хурлыг хойшлуулах ийм ажлуудыг бол маш их хийдэг. Зарим шүүх хурал 4, 5 жил явж байна. Ингээд шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр очихоороо бас дахиад хэдэн жил болдог ийм асуудлууд байгаа. Тэгэхээр улсын төсөв дээрээс эх үүсвэрүүд бол маш их шаардлагатай байгаа. Би түрүүн хэлсэн. Сүүлийн жилүүдэд бол дандаа одоо эргэн төлөлтөөсөө явж байгаа учраас эрэлт хэрэгцээ маш их байдаг. Харамсалтай нь үүний 20 хүрэхгүй хувийг нь л хангаж байгаа. Цаана нь 80 хувь нь гомдолтой үлддэг ийм байдал байгаад байгаа.

Улсын төсөв дээрээс ерөөсөө сүүлийн 4 жилд 1 ч төгрөг тусгагдаагүй. Хоршоо хөгжүүлэх санг бол удирдлагаар ЖДҮ-ийн газар хангаж ажиллаж байгаа. Энэ Хоршооны тухай хууль 2001 онд батлагдаад, Сум хөгжүүлэх сан байсныг бол Хоршоо хөгжүүлэх сан болгосон. Энэ хүрээнд бол журмыг нь бол сайдаар батлуулж, өнөөдөр Хоршоо хөгжүүлэх сан тухайн үедээ сум хөгжүүлэх сан байхдаа найдваргүй зээлийн хувь бол 79 хувь байсан. Өнөөдөр 39 хувь болж буурсан байгаа. Энийг дахиад илүү багасгах шаардлага байгаа. Энэ бол олголт нь тухайн сум дээрээ сумын Засаг даргын байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг нь хийгээд хяналтыг нь тавиад эх үүсвэрээ бүрдүүлээд явдаг. Сум, сум дээр байдаг 330 сан. Өнөөдрийн байдлаар 200 гаруй тэрбум төгрөг энд эх үүсвэр бий. Нийтдээ 2022 онд энэ журмыг нь батлаад, олгосноос хойш зээлийн мэдээллийн санд мэдээллийг нь нийлүүлснээс хойш чанаргүй зээлийн хувь бол маш ихээр буураад ингээд явж байгаа.

Аялал жуулчлалын компаниудад бол зээл олгох боломжтой. Хуулиараа тухайн жилд ямар салбар чиглэлд олгох вэ гэдгийг бол салбарын сайдын тушаалаар шийдвэрлээд ингээд явдаг.

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Нэг хэсэг бол сангуудаа алдаж байсан бол одоо эргүүлээд сангуудаа олж авах, өглөг авлагаа тэглэх асуудлууд хийгдэж байна. Жишээ нь Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас бол Нийгмийн даатгалын сангаас алдсан мөнгөө олж авахын тулд яг таных шиг хэлээд байгаа хурлыг аль болох хойшлуулах тэр эрх зүйн процессуудыг сайн мэдээд байгаа өмгөөлөгчдийг тэд нар аваад байгаа бол төр ч гэсэн тэд нартай өрсөлдөхүйц хэмжээний өмгөөлөгч авахын тулд 300 сая төгрөгийн асуудлыг энэ төсөв дээр бас шийдүүлээд явж байгаа юм. Тэр шиг та хэрвээ шаардлагатай бол энэ эрх зүйн туслалцаа авах, тэр хэмжээний хүмүүсээ ажиллуулах тэр санхүүгийнхээ бололцоонуудыг бас нээлгэж авах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Салбарын сайдын тушаалаар чиглэл нэмэгддэг гэж байна. Тэгэхээр сайд энэ дээр бас аялал жуулчлалын салбарыг ирэх онуудад нэмэх, тухайн ондоо багтаах ийм бололцоо бодлого бас байгаа юу гэж би сайдаас тодруулж асууя.

Б.Бейсен: 6 номер. Сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Монгол төрийн бодлого энэ 1992 онд анх ер нь ЖДҮ-лэл, жижиг, дунд бизнес өөрөө улс орны гол хөгжлийн суурь болно гэж үзээд, Америкаас Монгол Улсад нэг тусламж үзүүлсэн. Шар тос, цөцгийн тосны борлуулалтаас анх жижиг, дундын сан байгуулаад, зээл олгосон ийм түүхтэй. Энэ маань ингээд тасралтгүй үндсэндээ 30-аад жил явж байгаа үйл ажиллагаа. Ингээд нэг үеэ бодвол арилжааны банкнуудад чадавхажсан, аж ахуйн нэгжүүд ч чадавхажсан. Үндсэндээ сүүлийн 4 жилд ЖДҮ-ийг бизнесийг дэмжих чиглэл дээр энэ эх үүсвэр улсын төсөв дээр үндсэндээ суугаагүй. Өмнөх үлдэгдлээр санхүүжих, орлогоосоо санхүүжих хэмжээнд яваад, олгож байгаа зээлийн хэмжээ нь тун бага. Жилдээ 20 гаруй тэрбум төгрөгийг Монгол Улсын 21 аймагт хэмжээнд хүргэх гээд л явж байгаа. Тэгэхээр энд нэг мэргэжлийн Байнгын хороо зарчмын дүгнэлт хийгээд, бодлого гаргах цаг ер нь болж байгаа. Жижиг дунд бизнес улам их олширч байна..../минут дуусав/

Б.Бейсен: Сайд гүйцээж хариулъя. 6 номер.

Ж.Энхбаяр: Том бизнесүүд бий болох хэмжээнд жижиг бизнесүүд олон мянгаар бий болж, үйл ажиллагаа явуулж байгаа. Ажлын байрыг хамгийн их гаргаж байгаа нийгмийн баялгийн хуваарилалтад хамгийн шударгаар оролцож байгаа энэ жижиг, дунд бизнесийг дэмжих зайлшгүй шаардлага байгаа. Тэгэхээр энэ дээр мэдээж 2025 онд бол бид дахин өөрийн эргэн төлөлтөөрөө, барагдуулсан өр авлагаараа л 20-оод тэрбум төгрөгийн зээл ЖДҮ-ийн газар бизнесүүдэд олгогдох байх. Тэгэхээр үнэхээр хүрэлцээ хаанаа ч байхгүй.

Ер нь аялал жуулчлал гээд оруулж болно. Оруулаад хүртээмж туйлын хязгаартай л юм байгаа юм. Нийслэл Улаанбаатар хот, 21 аймагт энэ 20-иод тэрбумыг л хуваах асуудал шүү дээ. Тэгээд шалгаруулалт нэлээн чангарчихсан. Шалгаруулалт хийх орон нутгийн томилолт, газар дээр нь заавал очиж үзэх, баталгаажих гээд хатуу шалгуурууд тавьчихсан. Өмнө нь нэлээн замбараагүй захиран зарцуулсан асуудал байсан тул нэлээн.../минут дуусав/

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя. Идэрбат гишүүнд тодруулсны дараа хариулчхаарай. Сонсчихъё гэж байна. 5 номер хариулаарай.

Я.Эрдэнэсайхан: Идэрбат гишүүнтэй үнэхээр санал нэг байна. Яг асуудлыг яг харж. Үнэхээр өнөөдөр эрх зүйн туслалцаа шаардлагатай байгаа. Түрүүний таны хэлсэн тэр нөгөө сайн өмгөөлөгч нөгөө тал нь авчихдаг, тэгээд ямар нэгэн байдлаар ингээд хойшлуулаад л яваад байдаг ийм нөхцөл бол байгаад байгаа.

Тийм учраас бид нар нөгөө өмгөөлөгч зөвлөх үйлчилгээгээрээ аваад 114 зээлдэгчдийн хувьд яг энэ арга барилаар нь энэ оноос ажиллаж эхэлсэн. Жишээ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр барагдуулъя гээд шүүхийн шийдвэр гаргаад, нөгөө барьцаа хөрөнгийг нь үнэлэхлээр 70 хувиар дуудлага худалдаа, тэгээд 50 хувиар дуудлага худалдаа хийгээд, нөгөөх нь борлогдохгүй юмыг ЖДҮ-ийн газарт 100 хувийн үнээр нь санал болгодог.

Өөрөөр хэлбэл 100 төгрөгийн барьцаа хөрөнгө гэж үнэлэгдсэн юмыг 70 төгрөгөөр зарах гээд 50 төгрөгөөр зарахгүй юмыг Шүүхийн шийдвэр. энэ зарагдсангүй, танайх 100 төгрөгөөр ав гэдэг. Тэгэхээр өнөөдөр бид нар тэр 50 төгрөгөөр зарагдахгүй юмыг 100 төгрөгөөр авахаар Эрдэнэсайхан гэдэг юм уу ЖДҮ-ийн газар ЖДҮ-ийн санд алдагдалтай. Авах ... /минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тэгэхээр сайдын юунд бол яах вэ, 20 тэрбум төгрөг хүрэхгүй л гэж байна. 200 тэрбум төгрөгийн авлага байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр тэр авлага авах механизм руу зүгээр хуулийн сургууль төгссөн 1 төрийн албан хаагчийг тэр мэргэжсэн өмгөөлөгчийн өөдөөс тавиад дийлэхгүй. Тэгэхээр тэр Энх-Амгалан сайдын хийж хэрэгжүүлээд, Нийгмийн даатгалын сангаас алдсан мөнгөө олж авахын тулд сайн мэргэшсэн өмгөөлөгч авч байгаа энэ процессыг ЖДҮ-ийн сан дээрээ бас хэрэгжүүлээд явах юм бол өнөөдөр 20 биш 200-аад тэрбум төгрөгөө олоод авчих юм бол энэ олон ажлын байруудыг нэмэгдүүлэхэд туйлын нэмэртэй, тустай ийм зүйл болно. Тэр өндөр үнэтэй өмгөөлөгч аваад төртэй маргаан мэтгэлцээн үүсгээд байна гэдэг чинь бол бас юу юу ч үгүй болчихсон аж ахуйн нэгжүүд ч бас тэнд байхгүй байгаа болов уу гэж ингэж бас би бодоод байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Мэдээлэл маягаар хэлэхэд энэ зээлийн хамгийн дээд хэмжээ нь 300 сая төгрөг л байгаа. 301-ийг өгөхгүй. Хамгийн дээд хэмжээ нь 300 буюу жижиг бизнес. Нөгөө талаар тэр 20 хэдэн тэрбум нь бэлэн байхгүй. Нөгөө олгосон хугацаатай зээлийн эргэн төлөлт болгонд эх үүсвэр үүсээд, тэр нь сонгон шалгаруулалтад ороод л, олгогдоод л жилийн турш тасралтгүй үргэлжлэх процесс. Ингээд нэгдсэн дүнгээрээ 20, 30 тэрбум хүрнэ. Эргэн төлөлтөөсөө л бүх үйл ажиллагаа шалтгаалдаг. Тэрнээс бэлэн эх үүсвэр сан дансанд хураагдаад, зээл өгөх гээд байгаа зүйл бас бас байхгүй. Тэгээд аль болох тэр цугласан өр авлага дээр нэлээн сайн ажиллуулж, шүүхийн шийдвэрийг нэлээн шахаж, тэгээд л явна даа. Ер нь эх үүсвэрээ жоохон нэмээд, ер нь өргөтгөх зайлшгүй шаардлага л бий болж байгаа.

Тэгэхээр гишүүд ээ, манай яам дээр очих үед бид нар яг энэ бодлогын хүрээнд жижиг, дунд бизнесийн нөхцөл байдал ямар байна. Ямар өсөлт .../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Саяын тайлбарыг сонсоод, ойрын үед сайхан мэдээ сонсоогүй, их сайхан мэдээ сонссон мэт мэдрэмж төрлөө. 123 тэрбум төгрөгийн өрийг барагдуулсан байна. 2020-2024 онд төсөв дээр ямар ч эх үүсвэр тавиулаагүй мөртөө 117 тэрбумын зээлийг, зээлийнхээ эргэн төлөлтөөс гаргаж байна гэдэг чинь их сайн. Нийгэмд үзүүлэх нөлөө нь ч гэсэн сайн байсан байна. Одоо орлогын албан татварт нийт 32,3 тэрбум төгрөг, НДШ-д 20,2 тэрбум төгрөгийг 961 аж ахуйн нэгжийн төслөөр 5 жилийн хугацаанд төвлөрүүлжээ гэдэг. Энэ бол үнэхээр сайн тоо, баярлууштай мэдээ байлаа.

Тэгэхээр Эрдэнэсайхан даргаас асуумаар байна. Эрдэнэсайхан дарга бол их олон жил ажиллалаа шүү дээ. Энэ ЖДҮ-ийг хариуцаж, их ч юм тууллаа. Тийм ээ. Тэгэхээр танд өөрт чинь бодол байгаа мэдээж. Яаж эх үүсвэрийг өргөтгөх вэ. Төр засгаас яаж дэмжих вэ гэдэг дээр ажил хийж байгаа хүний хувьд, олон зүйлийг туулж гарсан хүний хувьд мэдэж байгаа. Энийгээ бид нарт нэг хэлж өгөөч.

Энхбаяр сайд бол туршлагатай сайд. Энэ дээр бол сайхан хамтарч ажиллах байх гэж бодож байна. Нэг харамсмаар юм нь өнөөдөр төрийн ажил эрхэлж байгаа хүмүүс ингэж ажлаа сайн хийж байхад Монгол Улсын Засгийн газар өнөөдөр Евро-Азийн холбоотой чөлөөт худалдааны түр хэлэлцээр гэдэг юмыг байгуулна. 300 гаруй бүтээгдэхүүний импортын татвараас чөлөөлнө. Энд нь Монгол Улсын одоо энэ ЖДҮ-чид буюу улны бид нар, жижиг зээл авдаг, хөл дээрээ арай ядан тэнцэж байгаа, зээлээ буцааж төлдөг 80 хувь нь хөөрхий авч чаддаггүй. Энэ аж ахуйн нэгжүүд дампуурах байхгүй юу. Ийм хэлэлцээр хийгээд, энийгээ Улсын Их Хурлаар соёрхон батлуулах гээд сууж байгаа төртэй байгаадаа үнэхээр харамсмаар. Тэгээд Эрдэнэсайхан даргын би юуг сонсмоор байна. Яаж эх үүсвэрийг нэмэх вэ. Энэ дээр мэдээж бодлого, төлөвлөгөө байж л таараа.

Б.Бейсен: 5 Номер хариулъя Эрдэнэсайхан дарга.

Я.Эрдэнэсайхан: Баярлалаа. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Үнэхээр ЖДҮХС-тай ижил төстэй ийм сангууд бол олон улсад бүгдэд нь байдаг. Бид нарын судалгаагаар 48 улсад судалгаа хийхэд бол 47 дээр нь ийм байгаа юм. Өөрөөр хэлбэл арилжааны банкнаас зээл аваад, үйлдвэр байгуулна гэдэг бол хүнд. Тэгэхээр ЖДҮ-лэл эрхлэгчдээ нэн ялангуяа дэмжихийн тулд бол маш бага хүүтэй зээлийг засгаас, төрөөс дэмжих ийм сан бол байдаг. Тэгэхээр энэ дээр дэмжиж ажиллана гэдэгт итгэж байна. Баярлалаа.

Эх үүсвэр бол хэдхэн төрөл байгаа. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар байгаа. Нэгдүгээрх асуудал бол улсын төсөв. Энэ бол мэдээж нөгөө таны саяын хэлдэг татвар, нийгмийн даатгал, маш олон ажлын байрыг бий болгож байгаа чинээлэг дундаж давхарга буюу ЖДҮ эрхлэгчид өөрөө өөрөө тэжээж байгаа энэ хэсгийг бодлогоор дэмждэг ийм сан. Тэгэхээр энэ дээр бол улсаас тодорхой анхаарал тавьж, энэ бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бол төсөв дээр заавал мөнгө тавих ийм шаардлага байгаа. Түрүүн хэлсэн харамсалтай нь сүүлийн хэдэн жил бол ерөөсөө тавигдаагүй.

Дараагийн асуудал бол олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг жижиг дундын чиглэлийн энэ бодлого, санхүүжилт, төсөл хөтөлбөрийг бол ЖДҮ-ийн бодлоготой нийлүүлж, энэ агентлаг руу нь нийлүүлэх ийм шаардлага үүсэж байгаа. Орон нутгаас бид нар түрүүн ажилласан гэж байна. Орон нутгийн маань сайн жишээ Өмнөговь аймаг, Сүхбаатар аймаг, Завхан аймаг, Дархан-Уул, Орхон гээд аймгууд бол орон нутгийн төсөв дээрээ мөнгө тавиад, сонгон шалгаруулалтаа хийгээд, ЖДҮХС-гаас нэмж мөнгө өгөөд ингээд явж байгаа сайн жишээнүүд байгаа. Энийг өргөжүүлэх шаардлагатай байна.

Бид бол бас судалгаа хийж үзсэн. Гаднаас ийм олон улсын донор байгууллагуудаас маш бага хүүтэй зээл авах ийм боломжийг судалж үзсэн. Энэ бол Засгийн газрын тусгай сангийнхаа хуулиар бол хязгаарлалттай буюу хориотой байгаа. Өөрөөр хэлбэл энэ дээр бас хэдийгээр хуульдаа өөрчлөлт оруулаад ороод ирлээ гэж бодоход бас зарцуулалт дээрээ дараа нь эргээд нөгөө доллароор төлөх асуудал хүндрэл үүсэх магадлалтай байгаа учраас энэ бол нэг хувилбар мөн боловч бас эрсдэлтэй. Тэгэхээр төсөв олон улсын төсөл хөтөлбөр, орон нутаг гэсэн ийм санхүүжилт, тэгээд дээрээс нь нэмээд эргэн төлөлтөө сайжруулах энэ ажлуудыг бол ингээд хийнэ. Хийвэл сайн байна. Энэ дээр гишүүд маань дэмжлэг үзүүлээч ээ гэж хүсэж байна.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Түрүүн тэр гаднын зээл олгодог байгууллагуудтай холбож өгдөг гэсэн үү танайх. Тэгж би ойлгосон зөв үү. Хэрвээ тэгдэг бол тийм туршлага хэр их хуримтлуулсан, хэчнээн байгууллагыг холбож өгсөн бэ. Ямар үр дүнтэй байсан бэ.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: ЭПАД буюу Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас бол төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн. Энэ сангийн хяналтын баг ирж ажиллаад, 2021 онд уулзалт хийсэн. Төсөл дуусах гэж байна. Нийтдээ 2,4 тэрбум төгрөгийн мөнгө байна. Энийг танай яг орго олгож байгаа энэ арга аргачлал чинь Монгол Улсдаа тохирсон ийм арга аргачлал байна. Энийг бид нар 50 хувийн санхүүжилт хийвэл та нар 2,4-ийг нэмээд, 4,8-ыг загвар хоршоонд олгох ийм боломж байна уу гэдэг ийм яриа өрнөөд, энэ хяналтын багаас бол санал тавьсан. Энийг бид нар судалж үзээд, боломжтой гэж үзээд, нийтдээ одоо 20 гаруй хоршоодод бол энэ зээлийг олгоод явж байгаа ийм жишээ байгаа. Ер нь бол ЖДҮ-ийн газраас санхүүжилтийн эх үүсвэрээ сайжруулах, эргэн төлөлтөө чанаргүй байгаа энэ зээлээ ямар нэгэн хэлбэрээр төлүүлэх, үүнийгээ мөнгөн хэлбэрт шилжүүлэх гэх мэтчилэн ажлуудыг бол хийгээд явж байгаа. Сая бас.../минут дуусав/

Б.Бейсен: Замира гишүүнд асуулт асууя.

С.Замира: Асуулт тавиад л хариу аваад, дахиад асуулт тавиад байж болох уу. Нэгмөсөн хэлэх биш. Тэгээд асуулт ярихаар, зарим нь үлдээд байгаа байхгүй юу. Хариу өгөхгүй. ЖДҮ-ийн газар нэлээд ажил хийсэн байна л даа. Тэгэхдээ эхний ээлжид 2 юм тодруулмаар байна.

Найдваргүй зээлдэгч гэдэг дээр хэчнээн тэрбум төгрөг байна. Тэгээд хөөн хэлэлцэх хугацаа нь өнгөрсөн гэдэг дээр хэчнээн тэрбум төгрөг байгаа юм. Энэ дээр ямар арга хэмжээ авч байна. Тэгээд ЖДҮ-ийн зээлийг ямар шалгуураар гаргаж байгаа юм. Ямар хэмжээтэй, ямар хүүтэй юм. Тэгээд яг ЖДҮ гэдэг чинь алга болсон нөгөө дунд давхаргад зориулагдах ёстой гэж би боддог. Тэр дунд давхарга нь ямар учиртай гэхээр бараг Монгол Улсын ажилгүйдлийн 90 хувийг хангаж байсан салбар шүү дээ. Тийм учраас ямар ч эх үүсвэргүй газарт зээл олгосноос аж үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгжүүдийг дэмжих тал тал дээр ямар арга хэмжээ авч байна. Ийм асуудал байна даа.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: ЖДҮ-ийн газар бол зөвхөн зээл олгодог бас биш. Зээл олгохоос гадна бүхий л төрлийн ЖДҮ эрхлэгчдээ бойжуулах, худалдаа борлуулалтыг нь дэмжих, гадаадын зах зээлд холбох гэх мэт ажлуудыг бол өөрийн нөөц бололцоогоороо хийж байна. Сургалтуудад хамрагдаж байна. Олон улсын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдахад төслөө яаж бичих талаар нь бас заавар, зөвлөгөө сургалтуудыг өгч гэх мэт ажлуудыг бол хийж ажиллаж байна. Жишээ нь сүүлийн 4 жилийн хугацаанд гэхэд гаднын 20 үзэсгэлэн худалдаанд аж ахуйн нэгжүүдээ оролцуулаад, нийтдээ 1 мянга гаруй аж ахуйн нэгж оролцож, 21 тэрбум төгрөгийн экспорт буюу орлого олж ирсэн байгаа. Тэгэхээр энэ бол 1 үзүүлэлт гэж ингэж харж байна.

Түрүүний хэлснээр яг найдваргүй болчихсон буюу эрэн сурвалжлаад, нас бараад, бүр олдохгүй байгаа бол ерөөсөө 3 зээлдэгчийн 1,5 тэрбум төгрөгийн асуудал байгаа. Мэдээж зөрчилтэй буюу хугацаа зээлээ төлөхөөс 1 хоног хэтэрсэн, 10 хоног хэтэрсэн, эсвэл 300 хоног хэтэрсэн ингээд шүүх хяналтын байгууллагад хандаад явж байгаа нийтдээ 300 зээлдэгчийн 100 тэрбум төгрөгийн асуудал байгаа.

Түрүүний Идэрбат гишүүний нөгөө 229 тэрбум төгрөгийн авлага гэдэг маань манайх энэ жил жишээлбэл 36 тэрбум төгрөгийг олгосон. Энэ маань 5 жилийн хугацаатай жилдээ 10 тэрбум, 7, 8 тэрбум төгрөг орж ирээд явах юм. Тэгэхээр 229 тэрбум төгрөг маань 5 жилийн хугацаанд ингээд жил жилдээ бага багаар орж ирэх ийм мөнгө юм.

Шалгуурын хувьд бол бид нар хууль дээрээ хэлсэн. 2,5 тэрбум төгрөг хүртэл жилийн борлуулалтын орлоготой, 200 хүртэл ажилтантай байх юм бол жижиг дунд гэж үзэж байгаа. Төсөв мөнгөний хүрэлцээгээс хамаараад бол бичил буюу 300 хүртэлх жилийн борлуулалтын орлоготой, 10 хүртэл ажилтантай энэ хэсэгтээ сүүлийн жилүүдэд бол илүү анхаарч ажиллаж байгаа. Яагаад энэ хэсэгт анхаараад байгаа юм бэ гэхээр нийт жижиг, дундын маань 80 хувь нь энд байгаа. Орон нутагт ихэнх нь байгаа. Тийм учраас энэ аж ахуйн нэгжүүддээ шаардлага буюу шалгуур нь бол жишээ нь бусдад төлөх найдваргүй зээлгүй байх ёстой. Төсөл хөтөлбөрөө бүрэн биелүүлсэн байх ёстой. Төрийн өндөр албан тушаалтан буюу Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн гэх мэт хамааралгүй байх ёстой гэх мэтчилэн ийм шаардлагыг тавьж байгаа. Одоогоор олгогдож байгаа зээлийн хүү бол жилийн хүү 3 хувь, 300 сая хүртэлх зээлийг бол олгогдоод явж байгаа. Сүүлийн жилүүдэд бол барьцаа хөрөнгийг үнэлээд, ажлын хэсгээр оруулаад, зах зээлийн үнэлгээгээр нь хийгээд ингээд явдаг болсон. Даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн. Тийм учраас 2020 оноос хойшоо олгогдож байгаа зээл дээр бол найдваргүй зээлийн асуудал бол үүсэхгүй байгаа. Мэдээж өмнөх 2016, 2017 оноос өмнөх асуудлууд дээр бол ихэнх шүүх хяналтын байгууллагуудын ажлууд буюу найдваргүй зээлдэгчдийн хэсэг бол тэнд байгаа.

Энд нэг бас хамгийн том нөлөөлсөн зүйл бол ковид байгаа. Ковид бол хамгийн ЖДҮ-ийн салбар өөрөө ер нь олон улсад бол хамгийн эмзэг салбар гэж үздэг. Маш хурдан босож ирдэг, маш хурдан унадаг ийм салбар. Тийм учраас ковидын тэр хөл хорионы хугацаа бол маш олон ЖДҮ эрхлэгчид бол хүндрэл үүссэн. Энэ дээр бол тухайн үедээ Засгийн газраас бол хүүгийн төлбөрийг хойшлуулах хэд хэдэн удаагийн алхмуудыг хийсэн. Өнөөдөр энэ зөрчилтэй байгаа хэсэг дээр бас тийм хүсэлтүүд ирж байгаа. Тэр ковидын үеийн хүү алдангийг 1, 1 удаа чөлөөлөх ийм хууль гаргаад өгөөч. Тэгэх юм бол бид нар үлдсэн мөнгөө буюу төлчих ийм боломжтой гэсэн ийм асуудал байгаа. Энийг бол бид нар бас судалж үзэж байна.

Б.Бейсен: Тэр ковидын юуг чөлөөлөх гэнээ.

Я.Эрдэнэсайхан: Ковидын үед нөгөө жишээлбэл 5 жилийн хугацаатай 2018, 209 онд авсан зээлдэгчид дунд нь ковидын жил гаруй хугацаанд үйл ажиллагааг бүрэн зогсоонгуут, зээлээ төлж чадахгүй, хүүгээ төлж чадахгүй ийм нөхцөл үүсэж байгаа. Гэтэл бид нар гэрээ ёсоороо энэ нөгөө хүү, алданги тооцогдоод яваад байсан. Энэ дээр бол ХАҮТ-ын гаргасан Форс мажор буюу давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээг үндэслээд бол шүүхээр энэ хэсгийн алдангийг бол хасаж

тооцож байгаа. Гэхдээ заавал шүүхээр ороод байгаа юм. Одоо зөрчилтэй байгаа зарим аж ахуйн нэгжүүд бол тэр хэсгийг 1 удаагийн хууль гаргаад, яг ковидын үеийнх нь алдангийг нь чөлөөлөөд өгчих юм бол үндсэн төлбөр, хүү, бусад хэсэгт оногдож байгаа төлөөгүй хүүгийн алдангиа бол ингээд төлөөд явах боломжтой гэсэн ийм бас хүсэлтийг удаа дараа ирүүлдэг.

Б.Бейсен: Үгүй ээ ковидын үед байна шүү дээ. Наадхыг чинь ковидын хуулиар чинь чөлөөлчихсэн шүү дээ. Бүүр НДШ, татвар, халаалт, цахилгаан бүх юмыг нь чөлөөлсөн шүү дээ. Нийтдээ 13 төрлийн юмыг Монгол Улсын Засгийн газраас чөлөөлсөн байхгүй юу тухайн үед. Болсон уу. Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Асуултууд нэлээн бас давхардлаа. Тэгэхдээ яах вэ, нэмээд хэд хэдэн зүйл тодруулъя гэж бодож байна. Сүүлийн жилүүдэд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэл дээр бас нэлээн анхаарал хандуулж ажиллаж байгаа. Эргэн төлөлт сайжирсан. Мөн дээрээс нь бас өөрсдийн мэдээллийг хамгийн түрүүнд shile.gov.mn сайтад оруулсан сан бол манай ЖДҮ-ийн сан байсан тухайн цаг үед. Одоо цаашдаа энэ ажил нь нэлээн бас мөрдөгдөөд явах ёстой.

Шалгаруулалтыг цахим болон орон нутгийн оролцоо, мөн дээрээс нь бас мэргэжлийн хөндлөнгийн мэргэжилтнүүдийг бас оруулж ирдэг болсон гээд давуу талууд бол бид бүхэнд үүссэний үр дүн бас сая гарсантай холбогдолтой мэдээллүүд бас өгч байна. Цаашдаа энэ нь сайн талуудаа ашиглаад, үргэлжлүүлээд явах нь зөв юм гэж.

Ганц нэгэн саналууд бас байгаа. Журмын төслийн өөрчлөлт дээрээ энэ бүсчилсэн хөгжил, бусад энэ салбарууд дээрээ бас жоохон анхаарал хандуулж бас гаргах нь зөв болов уу. Саяын ярьж байгаа бүс болгон дээр тэргүүлэх болон дэд зорилтууд байгаа. Үүнтэй холбогдуулаад бас ЖДҮ-лэлийн бодлогоо чиглүүлэх тал дээр бас анхаарлаа хандуулаарай.

Мөн дээрээс нь 2025 оны энэ ЖДҮ эрхлэгчдийнхээ журмыг аль болох 1 сардаа багтаад, он гарангуут зарлаад явдаг болъё. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хугацаа бол бас яг хаврын 2, 3 сараас эхэлчихдэг учраас эртхэн зарлаад, шалгаруулалтаа хийгээд ингээд явсаар байгаад наадам хүргэчихдэг ийм асуудал бас байгаад байдаг. Энийгээ бас та бүхэн маань анхаараарай. Энэ жил яг хэзээнээс зарлагдах вэ. 2025 оных.

Мөн дээрээс нь 70 хувийг орон нутаг руу чиглүүлсэн байгаа энэ бодлого бас ирэх 2025 онд үргэлжлэх үү. Энэ бас сүүлийн жилүүдэд нэлээн бас үр дүнтэй болсон ийм шийдэл байсан гэж бодож байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай бид бүхэн яриад байгаа юм. Яг одоо ЖДҮ-лэлийг дэмжих сангаас ХААЯ-аар дамжуулаад сүүлийн жилүүдэд хэдэн төгрөгөөр нэмэгдүүлье гэдэг саналуудыг яг тоон утгаар яг дэвшүүлсэн үү. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг. Тэгээд Сангийн яам болон бусад газраас энийг хэрхэн хариу өгч явж байна вэ. Хэрвээ энэ чиглэлээр тодорхой зорилтууд байгаа бол энийг бас ярих, нэмэгдүүлэх тал дээр Байнгын хорооны гишүүд нэлээн бас дэмжих байр суурьтай байна гэдэг ийм бас уур амьсгал харагдаж байна. Тэгэхээр энэ чиглэлээрээ бас тодорхой тоон

мэдээллүүдээ өгөөд ингээд явахад бол бас дэмжлэг авахаар бас зүйлүүд бас байна гэдгийг бас хэлэх байна.

Үндсэндээ бол халамжаас хөдөлмөрт гэдэг энэ агуулга бол байгаа юм. Одоо яг юм хийж бүтээе гэж бодож байгаа ЖДҮ-лэл эрхлэгч иргэдээ бид бүхэн бас энэ дэмжих энэ чиглэлийн бодлого сүүлийн 4, 5 жилд огт нэмэгдэлгүйгээр бор зүрхээрээ яваад байгаа асуудлыг бол анхаарах, нэмэгдүүлэх энэ цаг үе бас болсон.

Б.Бейсен: 5 номер.

Я.Эрдэнэсайхан: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Үнэхээр бас салбарын дэд сайдаар ажиллаж байсан учраас асуудлыг үнэхээр сайн мэдэж байгаа хүний хувьд маш үнэтэй зөвлөгөөнүүдийг өгч байна. Энийг бол анхаарч бид нар ажиллая.

Үнэхээр бас одоо бид нар төсөл сонгон шалгаруулалтаа олон нийтэд лайваар нээлттэй зарладаг болсон. Ингэхдээ сонгон шалгаруулалтын хороо маань 7 хүний бүрэлдэхүүнтэй, үүний 4-ийг нь бол жижиг дундын салбарт сүүлийн 2-оос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан ТББ-ын төлөөллийг оролцуулж, ингээд ТББ-ын төлөөлөл бол олонхын шийдвэр гаргаж ингэж явж байгаа. Тийм учраас хяналт бол сайн хийгдэж явж байгаа.

Журмын төсөл дээрээ бид нар бас бүсчилсэн хөгжлийн бодлогоос оруулах талаар нь анхаарч үзье. 2025 онд бид нар зээлээ олгохдоо бол аль болох түргэн шуурхай, эрт зарлаад олгохыг хичээнэ. Гэхдээ энд нэг асуудал байдаг нь татвар 2 сарын 15-нд хааж авдаг. Тэгэхээр нөгөө өмнөх жилийн борлуулалтын орлогоор нь тухайн аж ахуйн нэгжийг 2,5 байна уу, 1 байна уу, 5 тэрбум байна уу гэдгийг нь тогтоодог учраас татварын тайлан баталгаажсан тайлангаар хардаг. Тэгэхээр 2 сарын 15-аас хойшоо заавал татварын тайлан өгч байж баталгаажиж байж нөгөө тодорхойлолтыг нь үндэслэж, жижиг дунд мөн биш гэж байж, зээл олгох журмаар нөгөө ААН-үүд маань хүсэлтээ өгөх ийм нөхцөл нь үүсээд байгаа. Журам дээрээ бол бид нар энэ сонгон шалгаруулалтын үе шатыг түрүүн бас сайд хэлсэн, чиглэл өгсөн байгаа. Тухайн үеийн нөхцөл байдлаар бол асуудал үүссэн учраас маш их ... сонгон шалгаруулалтыг нэлээн олон үе шаттайгаар хийдэг байсныг багасгах ийм чиглэл өгөөд, бид нар журам дээрээ энэ үе шатыг багасгах, хурдан түргэн шийдэх ийм асуудлуудыг бол оруулаад явж байгаа. Орон нутгуудад бол эрхийг нь өгдөг болчихсон байгаа.

Өмнөх жилүүдэд бол улсын төсөв дээр 50 тэрбум төгрөгийн санхүүжилт төсөвт суулгаж өгөөч гэдэг хүсэлтийг бол өгдөг байсан. Энэ жилийн хувьд бол бид нар 100 тэрбум төгрөгийн улсын төсөв дээр санхүүжилт хүссэн боловч өмнө батлагдсан одоо тодотгол явж байгаа төсвөөр бол энэ 0 болсон. Өөрөөр хэлбэл хасагдчихсан байгаа. Үнэхээр бас бид нар энэ халамжаас хөдөлмөрт гэсэн бодлогыг бол хэрэгжүүлэх ёстой гэж ингэж ЖДҮ-ийн салбарт ажиллаж байгаа хүний хувьд үзэж байгаа. Үнэхээр ажлын байр ажиллая гэдэг хүн ховордсон. Энэ маань өөрөө хэт хавтгайрсан халамжийн бодлогоос болоод ажил хийхгүйгээр амьдарч болоод байгаа учраас жижиг, дундын салбарт очоод 1 сая, 2 сая төгрөгийн цалин аваад ажиллахгүй, халамжаараа бор хоногоо өнгөрөөгөөд байх ийм боломж нь байгаад байгаа учраас ажиллах хүчний асуудал бол бас дутагдалтай байгаа. Тэгэхээр яг энэ өөрөө өөрийгөө тэжээгээд явж байгаа энэ жижиг, дундын салбар чинээлэг дундаж давхаргын хэсгийг бол бодлогоор дэмжиж,

улсын төсөв дээр төсөв мөнгө тавих ийм шаардлага бол нэн шаардлагатай байгаа.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Сангийн яамны байр суурь бас нэг талдаа зөв байгаа юм. Энэ жижиглэн үйлдвэрийн санг энэ өмнө ужгирсан олон асуудлаа шийд, өр авлагаа шийд, ил тод бол, шуурхай бол, яг салбартаа хүр гэдэг бодлогоор бид нарыг нэлээн сайн шахсан. Энэ их зөв. Ийм ч учраас байгууллага өөрөө дотоод үйл ажиллагаагаа сайжруулаад, нэлээн ахиц гарч байгаа юм.

Тэгэхээр 2025 ондоо бид нар нөгөө нэмэлт төсөвгүйгээр явах энэ хүрээндээ л эргэн төлөлтөөсөө үйл ажиллагаагаа зохицуулаад хийнэ. Гэхдээ бид эх үүсвэрүүдээ нэлээн бодлогын хувьд чамбайруулаад, одоо ярилцаж байна. Ер нь үйлчилгээний салбар дээр анхаарах уу, худалдаан дээр анхаарах уу, нийтийн хоолны үйлдвэрлэл дээр анхаарах уу буюу тухайн нэг салбарыг нэлээн бодитой, шинэ ахисан түвшинд гаргахын тулд хөрөнгөө төвлөрүүлэх нэг ийм шийдлийг янз янзын байр суурийг сонсоод байж байна. Тэгэхээр ирэх оны төгсгөл гэхэд нэлээн сайн үр дүнтэй, ирэх 2026 оны төсөв арай өөр зургаар зурагдах байх гэж найдаж байна.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Санал хэлчихье. Үндсэндээ иргэд олон нийт маань бол бизнес эрхэлбэ, аж ахуй амьдралаа сайжруулъя, өрхийн орлогоо нэмэгдүүлье гэдэг энэ агуулгын хүрээнд хандахад жоохон мэдээллийн урсгал, мэдээллийн төвлөрсөн байдал гэдэг тал дээр бас жоохон анхаарал хандуулах хэрэгтэй байгаад байгаа юм. Манай ЖДҮ сангийн мэдээлэл бол энэ хүрээнд үндсэндээ өгөгдөөд явж байгаа. Үүнээс гадна бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээрх өрхийн бас тодорхой зээлүүд бас байж байдаг. Тэгэхээр энэ агуулгуудыг ингээд 1, 1 рүүгээ явуулдаг. Яг одоо шалгуур үзүүлэлтийг нь хойноос нь хөөцөлдөж явах явцдаа шантардаг ийм асуудлууд бас иргэдийн маань дунд бол нэлээн байдаг. Тэгэхээр цааш цаашдын ажил үйл ажиллагаа дээрээ бас энэ төрөөс олгогдож байгаа энэ зээлүүдийг уялдаа холбоог нь сайжруулах, мэдээллийн нэг цонхны мэдээллийг өгдөг болгох чиглэл дээр тодорхой бас ажлуудыг тал талдаа тусгаж, яамнуудад уялдаа холбоотой бас ажиллаасай гэдэг энэ саналыг бас тэмдэглүүлье.

Б.Бейсен: Сэдэддорж гишүүн асуулт асууя.

Р.Сэддорж: Энэ бусад гэдэгт ямар ямар салбар орж байгаа вэ. Одоо бол 10 салбар чиглэлээр өгч байгаа юм байна. Тэгээд зарим энэ нийтийн хоолны үйлдвэрлэлээ яаралтай оруулж болохгүй юу. Жижиг зочид буудал гэдэг чинь юундаа орох вэ. Тэгээд энэ хөдөө орон нутагт аж амьдралаа аваад явъя гэсэн хүмүүс нийтийн хоолны салбарт маш олон ажлын байр бий болгох боломж байна. Энэ дээр нь дэмжлэг үзүүлбэл маш хэрэгтэй байна. Энийг бодлогоор дэмжээч. Энэ нь бол өөрөө аялал жуулчлалтай маш холбоотой. Олон айлын өрхийн үйлдвэрлэлийг дэмжих ийм чиглэл байгаа. Тэгээд жижиглээд бага хэмжээний зээлүүдийг ингээд оруулах шаардлагатай байгаа учраас энэ дээр анхаараач.

Тэгээд энэ жижиг motel буудлуудыг ер нь та бүхэн юу гэж үзэж байгаа вэ. Дээрээс нь энэ шалгуур үзүүлэлтээ жоохон хөнгөлж болохгүй юу. Эргэн төлөлт

дээр бас хэцүү байхыг бол үгүйсгэхгүй. Гэхдээ тэр тухайн нутагтаа олон жил амьдарсан бизнес хийх чин эрмэлзэл хүсэлтэй ийм айл өрхүүд бол нутаг орондоо нэр хүндтэй ийм айл өрхүүд байгаа. Тэгээд энэ өрхүүдийг дэмжих тал дээр уян хатан ажиллах ийм боломж байхгүй юу. Тэгээд зарим онд суусан мөнгийг гүйцэд өгөхгүй байгаа, авахгүй байгаа. Энэ бол маш том боломжийг алдаж байна гэсэн үг. Зарим нь хаана зарладгийг ч мэдэхгүй байгаа. Яаж сонгон шалгаруулдгийг ч мэдэхгүй байгаа. Тусалж дэмжих хүмүүс ч байхгүй байгаа. Тэр зээлд хамрагдахын тулд бас тусалж дэмжих, зөвлөх үйлчилгээ юмнууд бол жинхэнэ танай байгууллагын харьяанд бол байх ёстой. Тэгэхээр энэ бол жоохон дутмаг юм уу л гэсэн ийм бодолтой байдаг юм. Тэгээд энэ дээр хариулж өгөөч.

Б.Бейсен: 6 номер. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Тантай санал нэг байна. Үнэхээр эх үүсвэр ч бага байна. Үйл ажиллагаагаа бид нар сурталчлах, олон түмэнд хүргэх, худалдаа, экспо зохион байгуулах гээд олон зардлууд шаардагдаж байгаа. Тэгээд саяын энэ хэмнэлтээр бол нэлээн л хасагдсан. Сая түрүүн яригдаж байсан нөгөө сайдын багцад байгаа мөнгө гэдэг чинь яг ийм зүйлд нэлээн зориулдаг байсан зардал. Бас хасна гэсэн ийм томъёолол ажлын хэсэг дээр хажуу талд хураагдаж байх жишээтэй. Тэгэхээр ЖДҮ-лэл бол үнэхээр нэг үеэ бодвол юм хийдгүүд нь шалгараад үлдчихээд байгаа. Байгаа эх үүсвэрээ бид нар юм хийж байгаа, татвар төлж байгаа, ажлын байр хангаж байгаа, нутаг орондоо нэр хүндтэй тэр хүмүүс дээрээ л төвлөрүүлнэ. Ер нь шинээр эхлэхээсээ илүү юм хийж байгаа улсуудаа өргөтгөө, үйлчилгээний чанарыг нь сайжруулъя, тоног төхөөрөмжийг нь өргөтгөө, тэрийгээ дагаад бусад нь суралцаж дагана гэсэн ийм л юм байна. Тэгэхээр бид байгаа нөөцийг үр ашигтай яг зөв зарцуулах уу гэдэг дээрээ, тэгээд салбарууд дээр их тойрч яриад байна. Хамгийн тулгамдсан салбар аль байна.

Нөгөө талаас энэ агентлаг маань өөрөө яг улсын хөгжлийн бодлого дээр тулгуурлаж үйл ажиллагаа явуулах ёстой. Тэгэхээр бидний хэдэн гол чиглэл байгаа шүү дээ. Тэр хүнсний хувьсгал буюу хүнсний үйлдвэрлэлийн асуудал байна. Одоо аялал жуулчлалын салбарыг босгох том бодлого явж байна. Аялал жуулчлал, хөдөө аж ахуй 2-ыг л яаралтай босгоно. Уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийг олон тулгуурт болгоно гэсэн том одоо концепц байгаа. Тэгээд энэ хүрээндээ л бид нар бас тэр талд нь тэнд ажиллаж байгаа босож байгаа аж ахуй нь томуудаа дагуулж жижгүүдийг нь яаж бэхжүүлэх вэ гэдэг дээр л 2025 оны бодлого гаргах болно гэж хэлэх байна.

Тэгээд 2025 ондоо бид яах вэ, жоохон хатуухан шиг үзээд, өр авлагаа нэлээн барагдаад, өр авлагын хойноос хатуухан сайн хөөцөлдөөд нэлээн үр дүнгээ улам сайжруулаадахъя. Тэгээд сайн үр дүнтэй Их Хурал дээр асуудал оруулахад их дэмжлэг авах байх гэж л бодож байна. Нэгэнт төсөв өргөн баригдсан эх үүсвэр 0 гэж үзэж байгаа ийм бодлого гарч байгаа үед бол бид тэгээд энэ хэмжээндээ явна.

Б.Бейсен: Тодруулъя.

Р.Сэддорж: Эх үүсвэр нэмэх тал дээр аймгууд, дүүргүүдэд ялангуяа аймгуудад боломж эрэлхийлж байгаа юу. Жишээ нь уул уурхайн аль нэг төсөл тухайн аймагт байлаа гэхэд Ашигт малтмалын тухай хуулиараа нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутагтаа туслах, хандив санхүү өгөх гээд ийм хуулиар хүлээсэн үүрэг байгаа. Тэгэхээр тэр уурхайгаас юм уу, тэр аж ахуйн

нэгжээс орж ирж байгаа хандивыг шууд оруулж болох уу. Ингэж эх үүсвэрээ нэмж болох уу. Ийм хөдөлгөөн өрнүүлбэл бас хэн хэндээ хэрэгтэй баймаар юм шиг харагдаад байгаа юм.

Б.Бейсен: Сайд хариулъя 6 номер.

Ж.Энхбаяр: Энэ уул уурхайн компаниуд улс болон орон нутаг төлдөг татвараас гадна тухайн орон нутаг төвлөрүүлэх ёстой нөгөө дүйцүүлэн хамгаалахад зориулсан төсвийг бас төлөвлөгөөнд тусгаад сумын даргаараа баталгаажуулаад, тодорхой эх үүсвэрийг бүрдүүлээд, тэр нь байгаль орчин сэргээх, бэлчээрийн менежмент, усжуулалт, мод бут тарих, хадлан талбай хаших гээд зарцуулаад байдаг. Энэ дээр бид нар бүх яам руу бичиг авсан. Хэрвээ орон нутагт жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх чиглэлээр төсөв дээрээ мөнгө тавивал тэр тавьсан мөнгөний хэмжээнд сангаас мөнгийг нэмж өгч, тэр санг үүсгэнэ. Бидний цаад санаа нь юу гэдэг юм. Өмнөговь аймаг жижиг, дунд үйлдвэр дээрээ 1 тэрбум төгрөгийг оронд нь төсөвт тавивал, агентлагаас 1 тэрбум нэмж тавиад, тэр дүрмийн санг 2 болгож байгаа юм. Ингээд Өмнөговь аймгийн ЖДҮ эрхлэгчдэд 2 тэрбум төгрөгийн эх үүсвэр үүсгэнэ гэсэн үг. Ийм маягаар орон нутгийг бас их урамшуулж, хамтдаа хүчээ нийлүүлэх маягаар ингээд бичиг яваад, хөөцөлдөөд явж байгаа.

Б.Бейсен: Мөнхтулга гишүүн асуулт асууя.

П.Мөнхтулга: Монгол Улсад нийт 27 тусгай сан байгаа юм байна. Тэгээд энэ болгоны аудитын дүгнэлтүүдийг ер нь энэ сангуудын үйл ажиллагааг харсан юм. Тэгээд хамгийн их муу дүгнэлт авсан, бүр байгуулагдсанаасаа хойш сөрөг, сөрөг гэдэг чинь бол аудитын хамгийн муу дүгнэлт шүү дээ. Тэгээд сөргийн дараа муугаас жоохон дээгүүр нь бол хязгаарлалттай дүгнэлт байхгүй юу. Тэгээд хязгаарлалттай дүгнэлтийг маш олон жил дараалж авсан. Тэгээд хамгийн сүүлд 2024 оны 3 сарын 25-ны 845 дугаар тоот Үндэсний Аудитын дүгнэлт байгаа юм. Энэ дээр бол нийт зээлийн чинь шууд зээлийн 58 хувь нь буюу 99 тэрбум 373 сая төгрөг 347 зээлдэгчээс авах авлага чинь муу зээл байна гэсэн ийм аудитын дүгнэлт гарчихсан байна. Хамгийн сүүлийн дүгнэлт нь. Тэгээд энэ хүртэл дандаа хязгаарлалттай дүгнэлт хийгээд яваад байсан. Тэгээд тусгай сангийн хуулийг харахаар олон жил 5.6.3 дээр билүү тусгай сангийн үйл ажиллагаа доголдсон, үр ашиггүй болох нь тогтоогдсон гээд энэ нь ингээд аудитаар маш олон жил үр ашиггүй, үйл ажиллагаа нь доголдсон гэдэг нь он дараалаад 6, 7 жил тогтоогдчихсон. Тэгээд татан буугдаагүй ингээд яваад байсан юм байна лээ. Тэгээд энэ болгон нь юунаас болсон бэ гэхээр энэ санг өөрөө улс төрийн хэрэгсэл болгочихсон байхгүй юу. Сонгууль болохоор жижиглээд хүн ингээд 20 саяын төсөл бичээд орохоор ер нь тоонд нь хүргэе. 5, 5-ыг өгье гээд. Энэ яг бодит жишээ. Манай Архангай аймаг дээр гарч л байсан. 20 саяын зээл авахаар чамд 5-ыг өгнө. 1 хүнд 20-ийг өгч байхаар 4 хүнд 5-ыг өгчихье гээд. Тэгээд ингэж явсан. Дээрээс нь хэрвээ банк 58 хувийн муу зээлтэй болчихсон бол аль хэдийн дампуурчихсан. Одоо 58 хувь нь муу зээлтэй болчихоод, дахиад төсвөөс эх үүсвэр хүсээд явж байна гэдэг бол энэ ерөөсөө цаашаа явахгүй л гэсэн үг.

Тэгэхээр бодит санал юу вэ гэхээр одоо энэ муу зээлүүдээ 99 тэрбум гэдэг чинь 100-аад тэрбум төгрөгийг банк шиг ингээд иргэн бол банкнаас зээл авах гэж 7 булчирхайгаа тоочиж, өчнөөн удаа нааш цаашаа явж байгаа шүү дээ. ЖДҮ-лэлийн сан бол зүгээр үзэмж харж байгаад олгочоод байх шиг байгаа юм. Тийм учраас үр

дүн нь ийм 58 хувийн муу зээлтэй. Тэгээд аудит нь бүүр аргаа бараад ингэсэн байгаа шүү дээ. 1 жилд ингээд 58 хувийг барагдуулж барахгүй. 10 хувийг л барагдуулчих гээд. Тэгэхээр тэр.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхтулга гишүүнд 1 минут нэмээд өгье.

П.Мөнхтулга: Тэгээд тэрийгээ муу зээлийнхээ 10 хувийг ч барагдуулж чаддаггүй. Тэгээд ийм нөхцөл байдалд орчихсон, одоо дээрээс нь төсөв мөнгө нэмье гэж байхаар энэ муу зээлүүдээ эргэж олж аваач ээ. Энэ улс төрийн хэрэгсэл болгосон, энэ чанаргүй зээл олгосон. 3 хувь гэдэг бол инфляцаас доогуур хувь шүү дээ. Бараг үнэгүй мөнгө байхгүй юу. Ийм мөнгө авчхаад эргүүлж төлж чадахгүй байна гэдэг бол энэ ерөөсөө ямар ч эдийн засгийн шалгуур тавиагүй, зүгээр л цацчихсан мөнгө байна л гэсэн үг. Энэ сонгон шалгаруулах хороо нь ажиллахгүй байна л гэсэн үг. Тэгэхээр энд байгаа үлдэгдэл мөнгө байдаг юм бол миний тооцоогоор 40 тэрбум төгрөгийг зээлийн хүүгийн татаасанд өгөхөд бид нар 700 тэрбум төгрөгтэй болох юм байна лээ. Энэ 2025 оны төсөв дээр 45 тэрбум төгрөг хүсчихсэн байна лээ. Тэрүүгээрээ зээлийн татаасанд өгөөд үлдсэн байгаа активуудаа ер нь татаасанд өгчих юм бол өчнөөн их наядын мөнгө босгоод .../минут дуусав/

Б.Бейсен: 6 номер. Сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр 2000 он хүртэл иймэрхүү дүгнэлт, улс төржсөн зээл олголт гээд олон муу зүйл байсан. Тэгээд энэ хамт олныг энийг шийдэж зохицуул гээд бүтцийн өөрчлөлт хийгээд, сангуудаа нэгтгээд, үндсэндээ ЖДҮ-ийн агентлаг гээд зохион байгуулалт нь хийгдээд явж байна. Үр дүнгүүд сайн гарч байна. Тэгэхээр Мөнхтулга гишүүн ээ, одоо яг үр дүн гаргаад, тэр тулгамдсан өр зээлийг нь бүтэн төлж барагдуулаад, хамгийн ил тод болгоод, өр авлагаа хамгийн сайн барагдуулаад ингээд явж байгаа энэ хамт олныг бас яг одоогийн байгаа цаг дээр нааж болохгүй. Үйл ажиллагаа сайн болж байна, сайжирч байна. 2025 онд улам сайжруулах ёстой. Ингээд явъя.

Зөвхөн бас зээл биш нөгөө ЖДҮ-ийг эрхэлж байгаа хүмүүсийг маань дэмжих, туслах, төсөл хөтөлбөр бичдэг болгох, тэгээд гадаад, дотоод зах зээлд нь гаргах, олон улсын худалдаа, экспо арга хэмжээнүүдийг зохион байгуулах гээд л энэ чинь нүсэр их ажиллана. Сая тэр нүсэр их ажлын зөвхөн нэг хэсэг буюу зээл олголтын л зүйл ярьж байна. Тэгээд энэ маань мэдээж Сангийн яам хатуу байр суурь тавьж 2000 оноос хойш 2024 он хүртэл 5 дахь жилдээ төсөв тавьсангүй. Гэхдээ энэ байгаа өр авлагаа барагдуулаад, үйл ажиллагаа явуулаад, цэгцлээд сайжирч байна. Тэгээд 2025 оны сүүл гэхэд арай өөр дүнтэй, бүгдээрээ арай өөр юм ярих байх.

Энэ байгаа жоохон эх үүсвэрийг жижиг дундаас нь салгаад, банканд өгчихөд амархан. Ингээд том зээлийн том багц болоод л явчихна. Тийм бодлого бол энэ манай Цагаан алт, Тэрбум мод, Хоршоо, Хүнсний хувьсгал, Атрын 4 дүгээр аяны хүрээнд бол хангалттай байгаа. Үндсэндээ ирэх жил бараг 4 их наяд төгрөгийн зээл бизнес эрхлэгч дээр очно. Яамны нэг том бодлогын өөрчлөлийг та бүхэн анзаарсан бол сайдын захиран зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээг дээд зэргээр багасгаж, үндсэндээ байгаа эх үүсвэрээ хувийн хэвшил, бизнест эх үүсвэр болоход нь бид нар яг таны саяын хэлдэг бодлогын дагуу бүх эх үүсвэрийг нь шахаж өгч байгаа. Тэгээд эхлээд энэ үүссэн нөхцөл байдлыг бид нар нэг сайн

цэгцлээд, өр авлагаа нэг янзлаад, зохион байгуулалтын хувьд нэлээн боловсронгуй болгоод гаргаад ирье. Тэгээд 2025 оны эцсээр 2026 оны шинэ төсвийн үед бүгдээрээ эх үүсвэрээ яах вэ, дараа нь яаж зохион байгуулалт хийх вэ гэдгээ нэг ярих бололцоо гарах байх.

Өмнө бол яах вэ дээ сайд нар эх үүсвэрээ захиран зарцуулах эрхийн төлөө л яваад байсан. Энэ удаагийн Хөдөө аж ахуйн яамны бодлого бол эх үүсвэрээ бүгдийг нь арилжааны банк, татвар төлж байгаа бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүддээ аль болох олон эх үүсвэрийг л хүргэхийг бодож байгаа. Сүүлийн 30 жил байгаагүй маш сайн одоо хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр энэ салбарт очиж байгаа. Ингэх нь өөрөө уул уурхайн мөчлөгийг сөрсөн энэ цаг үеийг их зөв ашиглах тулд хийгдэж байгаа төрийн бодлого шүү дээ. Манайд хэрэгжиж байгаа 4 бодлого дөрвүүлээ үндсэндээ Их Хурлаар хэлэлцэгдээд, бодлого болоод, цаг хугацаатай төсөв хөрөнгө, хэмжих нэгжтэй, хүрэх зорилттой ингээд хөтөлбөрүүд явж байгаа юм. Үр дүнгүүд их сайн байна. Сайн мэдээнүүд их гарч байгаа. Зээлийн эргэн төлөлтүүд их сайн явагдаж байгаа. Бизнесүүд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна. Зөвхөн одоо тэр Хөгжлийн сайдын мэдээнд гараад байгаа шүү дээ. Энэ хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр боловсруулах үйлдвэрийн салбарын импорт, импортын тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтаа тэлж байгаа байдал маш сайн явагдлаа. 40 гаруй хувиар эрс нэмэгдээд байна гэдэг чинь ирэх онд улам л үйлдвэрлэл нэмэгдэнэ, ажлын байрууд их олноор бий болно л гэсэн үг. Тэгэхээр энэ байгаа жоохон 20-оод тэрбумын эх үүсвэрийг тэр зээлийн хүү рүү битгий хийгээч. Тийм санал та битгий гаргаарай. Үүний цаана чинь бас олон мянган аж ахуйн нэгжийн амьдрал, өрхийн амьдрал бас явж байгаа. Дээд хэмжээ нь 300 хүртэл сая төгрөг л олгож байгаа жижигхэн зээлүүд шүү дээ. Бичил, дэндүү бичил зээл. Арилжааны банканд хүрч чаддаггүй хүмүүс байхгүй юу. Тэгээд тодорхой хэмжээ нь цөөн хэмжээнд ч гэсэн хүрээд ингээд нэг ийм бодлого хадгалагдаад явж байх нь их чухал юм байгаа юм.

Б.Бейсен: ЖДҮ-тэй холбоотой бас нэг юм би асууя гэж бодож байна. Ер нь ЖДҮ-д хуваарилагдсан Засгийн газраас хуваарилсан төсөв бодож байхад ер нь олон ч үйлдвэр байгуулагдчихаар төсөв батлагдлаа. Би аймгийн Иргэдийн Хуралд 5 удаа суусан. Одоо Их Хуралд 2 дахь удаагаа сууж байна. Хяналт шалгалт сул ирсэн. ХААЯ-ны чиглэлээр ЖДҮ-ийн газраас ч гэсэн аймгуудыг ХАА-н удирдах газар, ЖДҮ-ийн газар. Тэгээд аймгийн удирдлагууд муу ажилладаг. Танил тал, хамаатан садан, найз нөхөд, улс төрийн чиглэлээр, намын харьяаллаар тэгээд найдваргүй ЖДҮ-чдэд зээл олгодог. Аль эсвэл хуваарилаад жижиг юм олгодог. Тэр нууц биш. Жишээлбэл сая танилцуулж байна л даа. Одоо ер нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дээр 78 зээлдэгч дээр 49,2 тэрбум байна гээд сая юун дээр гарч байна. Шүүхийн зөвлөх үйлчилгээ дээр 114 зээлдэгч дээр 36,6 тэрбум байна гээд ярьж байна. Тэгээд 48 зээлдэгчээс эргэн төлөлт 3 тэрбум, зөрчил барагдуулах 34 зээлдэгчээс 3,5 тэрбум л төлсөн байна шүү дээ. Тэгэхээр уг нь энэ зөвөөр явбал Ерөнхийлөгчийн Үндэсний хувьсгалын хүрээнд ч гэсэн одоо хавдар яаж ихсэж байна. Эх орны хөрсөнд ургасан хүнсний ногоогоор хангах, сүү цагаан идээгээр хангах боломж байгаа юм байна. Тэгэхээр энийг хяналтыг бид нар Байнгын хороо ч гэсэн хяналт тавья. Бид нар Байнгын хорооноос бүх аймгуудын ЖДҮ-ийн юуг авсан. Ямар байгууллага өгсөн, хэчнээн сая төгрөг авсан гэдгийг бүгдийг нь одоо аймгуудаас авсан байгаа. Гэтэл зарим аймаг дээр ерөөсөө 190 хэдэн сая, 200 сая авсан хүмүүс бол ерөөсөө тийм жижиг үйлдвэр байгуулаагүй. Үүний цаана бас жижиг авлига байж байгаа. Банкныхан авдаг. Аймгуудын ХАА-н газрынхан авдаг. Бичиг цаас дээр жинхэнэ бодит ийм зөрчилгүй гэдэг. Харин ХААЯ энэ дээр сайн

ажиллаад, сүүлд нь энэ жижиг дунд үйлдвэрийн зээлийн газар энэ дээр хяналт тавиад, шилэн болгож байгаа юм байна шүү дээ. Энийгээ улам сайжруулах хэрэгтэй. Тэгэхгүй бол жилийн жилд улсын төсөв ингээд яваад байдаг. Тэрийг ч бас Сангийн яам мэдэж байгаа байх. Тэгээд энэ жил бас ЖДҮ дээр төсөв тавиагүй, ноднин ч бага төсөв тавьсан. Зээл нь эргэн төлөлт нь муу байдаг. Тийм учраас энэ дээр бид нар манай Байнгын хороо та бүгд бас хамтарч ажиллаад шийдэхгүй бол энэ ерөөсөө болохгүй асуудал байгаа юм байна.

Сая бид Энэтхэг явсан. Нөгөө хоршооны асуудлаар. Тэд нар манайд Монголд ерөөсөө хоршоо, жижиг дунд үйлдвэр ерөөсөө хөгжөөгүй маягийн ойлголт юм байна. Гэтэл манайд чинь анх нэгдэл байж байгаад, хоршоологчдын холбоо байгуулагдаад, 20 жилийн ойгоо тэмдэглээд, сая энэ жижиг дунд жил болгон зээл олгодог. Үүний хэрэгжилт хяналт нь муу ирсэн. Үр дүн байхгүй. Тийм учраас энийг бас эрчимжүүлэх тал дээр манай Байнгын хорооны гишүүд, Байнгын хороо, тэгээд ХААЯ энэ жижиг дунд үйлдвэрийн зээлийн газар аймгууддаа шаардлага тавиад яахгүй бол энэ ерөөсөө цаашдаа улсын төсвийг үрэн таран хийгээд, эргэн төлөлт байхгүй тэгээд тийм бага асуудал болох юм байна. Тэгэхээр энэ дээр чинь нэлээн хяналт тавихгүй бол сая одоо 1,5 тэрбум төгрөгийн зээлдэгч олдохгүй байна гэсэн шүү дээ. 1 тэрбум 500 сая гэсэн үг биз дээ. Тэр чинь мөн адилхан танил талаараа явчихдаг юм уу, аль эсвэл найдваргүй зээлдэгчдэд ийм асуудал үүсчхээд байна. Тийм учраас энэ дээр нэлээд анхаарч хамтарч ажиллах шаардлагатай байна. Бид бас хяналт тавья. Тэгээд аймгуудын ХАА-н газар, ЖДҮ-ийн газарт нь бас хяналт тавиад, ер нь жилдээ нэг ганц удаа очих биш 3, 4 удаа очоод, ядахдаа хавар тариалалт хийж байвал, хавар тариалж байгаа үед нь, намар хурааж авч байгаа үед нь гэх мэт бүх сайн хяналт хийгээд, энийг эрчимжүүлээд явахгүй бол ер нь эх орны хөрсөнд ургасан хүнсний ногоогоор дотооддоо хангачих боломж байгаа.

Нөгөө талаар энэ тариаланчид жижиг дундуудын эрхлэгч дээр эрүүл хүнсний ногоогоор сургуулийн дотуур байр, цэцэрлэг энэ тэр хангах боломж байгаа байхгүй юу. Тэр тэртээ тэргүй төрөөс төсөв нь тавигдаж байгаа. Тэд нарыг тэд нартай холбож өгөх, хамтарч ажиллах тал дээр бодлого боловсруулах шаардлагатай байна. Сайд аа, бид нар ч энэ дээр анхааръя. Тэгэхгүй бол Хятадын хямдхан ногоог аваад, нөгөө тариаланчдын ногоо нь зарагдахгүй тийм асуудал үүсэж байгаа.

Гэтэл цаад талд нь сүү, цагаан идээ, жимс ногоо, тэгээд л хүнсний ногооны асуудлын төсвийг нь сургуулийн цэцэрлэг, үдийн цай, дотуур байр тавиад өгч байгаа шүү дээ. Үүний цаана мөн адилхан хүмүүс ажилладаг. Тэгэхээр энэ асуудал дээр хамтарч ажиллаад бас энийг эрчимжүүлэх шаардлагатай байгаа гэдгийг бас хэлэх байна.

Нөгөө талаар ЖДҮ-ийн юун дээр чинь маргааш бид нар юм тавиулах уу, зээлийн эргэн төлөлт гээд юм ярих уу. Бас яг одоо та бүгдийн ярьж байгаа 29 тэрбум гэж байна уу Сайд аа. Тэр ч юу ч болохгүй л дээ. Гэтэл аймгууд болохоор чинь ЖДҮ дээр чинь төсөв тавиулж өг та нар ийм юм байхгүй байна гээд ярьж байна. Тэгэхээр чинь энэ дээр чинь Цагаан алт байна. Хүнсний урсгалын хүрээнд хэд байна. Тэрний бүгдийг нь тооцоог гаргах хэрэгтэй байна. Гаргаж байж дотооддоо хангах асуудал ярихгүй бол тэгээд л энэ асуудал маань жаахан үр дүнгүй болчих гээд хүнсний хувьсгал хэрэгжих нөхцөл маань бүрдэхгүй тийм асуудал үүсчих гээд байна. Энэ дээр хамтарч ажиллах тал дээр та ямар саналтай байна сайд аа.

Ж.Энхбаяр: Тантай санал нэг байна. Яам өөрөө мэргэжлийнхээ Байнгын хороотой бүх юмаа, жаргал зовлонгоо хуваалцаж байж хамтдаа энэ бодлого өөрчлөлтийнхөө төлөө, үр дүнгийнхээ төлөө хамт явна. Тэгээд төсвөө баталчхаад бүгдээрээ яам Байнгын хороогоо хүлээж авч, ер нь бүх бодлогоо сайн дэлгэж яриад, бүгдээрээ хаана хаанаа юмаа яг яаж уях вэ гэдэг зүйл дээрээ ярилцъя гэж бодож байна. Үнэхээр байгаа бага эх үүсвэрийг яаж үр дүнтэй ашиглах вэ гэдэг дээр л бид бүх тооцоог л хийгээд байна. Энд тэнд тус тусад нь аваад хийх биш, нэг бодлого нөгөө бодлогодоо яг нөхцөлддөг, уягддаг, дараагийн шат дамжлагын шийдвэрлэг маягаар л эх үүсвэрүүдээ чиглүүлье.

Мэдээлэл өгөхөд Хүнсний хувьсгал 1,2 их наяд эх үүсвэр батлагдсан. Үндсэндээ 100 хувь бараг олгогдоод, амжилттай хэрэгжээд 20 гаруй үйлдвэрүүд өргөтгөөд, 200 гаруй бүтээгдэхүүн гараад ингээд явж байгаа. Нэг ийм төсөл. Цагаан алт бол 2025 оноос эхэлнэ. Энэ бол арьс шир, ноос ноолуурын салбарын боловсруулалтынхаа үйлдвэрлэлийнхээ боловсруулах түвшнийг сайжруулах, тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгөд зарцуулагдана. Энэ бол нэлээн том зээлүүд явна. Хоршоо бол ойлгомжтой хоршсон малчдын хүрээнд бүх 21 аймгийн хэмжээнд явж байгаа. Атрын 4 дүгээр аяны хүрээнд бид нар хөдөө аж ахуйд ганц дутаад байгаа тэжээлийн баазаа нэмэгдүүлэхийн тулд, мөн үр тарианыхаа тариалалтыг нэмэгдүүлэхийн тулд 200 мянган га-г нэмж эргэлтэд оруулах, 200 мянган ширхэг ашиг шимт мал сүргээр мал сүргийнхээ үржил селекцийнхээ тоо толгойг сэлбэх, ингээд тариалалтаа тогтворжуулах, хүнсний нэгдсэн худалдааны төвүүд, бөөний төвүүд, складууд, хүлэмжийн аж ахуй, усалгаа нэмэгдүүлэх, тариалалтаа нэмэгдүүлэх, таримлын шинэ нэр төрлийг бий болгох гэх мэтийн бодлогуудыг Атрын 4 дүгээр аяны хүрээнд ингэж хэрэгжүүлэхээр бэлдэж байна.

Тэгэхээр 2025 онд гол эрчимтэй явах 2 хөтөлбөр маань Цагаан алт, Атрын 4 гэсэн 2 хөтөлбөр. Мөн Шинэ хоршоо хөдөлгөөн нэлээн эх үүсвэр бас бараг 500 тэрбум төгрөгийн зээл олгох эх үүсвэр хасагдсан. Тодотголоор. Тэгээд одоо 600 гаруй тэрбум төгрөг олгогдчихсон байгаа бол ирэх онд 400 тэрбум нэмэгдээд 1 их наядын хүрээнд малчдын хоршооны асуудал яригдана. Уг нь төлөвлөгөөгөөр 1,5 байсан. 500 тэрбум нь үндсэндээ хасагдсан явж байгаа. Хүнсний хувьсгалын эх үүсвэр үндсэндээ ингээд шийдэгдээд дууссан гэж ойлгож болно. Одоо үр дүн хэрэгжилтээ гаргах ийм цаг үе ирж байгаа. Тэгэхээр бүх талын хамтын ажиллагаагаа хөгжүүлнэ гэдгээ хэлье.

Б.Бейсен: Тэр Энэтхэг дээр болсон юман дээр ХААЯ-аас тэр юуны нэвтрүүлэх төвөөс 2 эмэгтэй очсон. ЖДҮ-ийн бүтээгдэхүүн авааччихсан байна лээ. Тэгээд энэ Их Хурал дээр би өдөр ярьсан. Байнгын хороо яамнаас давсан ажлын хэсгүүд гардаг. Тэд нар очдог. Төсвийг нь тэд нар зарцуулдаг. Гэтэл тэнд сая сайд нь очсон байвал, тэгээд Шадар сайд юм уу аль нэг нь очих ёстой байсан байна л даа. Тэнд бас 2, 3 улсын Ерөнхийлөгч нь ирсэн байна. Тийм юман дээр чинь тэнд зээлийн асуудал бас яригдсан. Жинхэнэ хэрэгжилтийн асуудал, хамтран ажиллах тал дээр бүх юм ярь яригдсан. Тэгээд тэнд явж байсан тэр ажлын хэсгийн ахлагчаас бас асуугаарай. Тэгэхээр ийм юман дээр чинь нэлээн хамтарч ажиллахгүй бол болохгүй юм байна. Манайд ер нь энэ талын төсөв урьд нь хангалттай тавигдаж байсан. Харамсалтай нь хэрэгжилт муу, үр дүн байхгүй ийм болж байна. Тийм учраас энэ дээр бид нар хамтарч ажиллаад, энийг 1 зүг чигт нь оруулъя гэдгээ хэлмээр байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Мэдээлэлтэй холбоотой гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна.

15.48 цаг.

Дараагийн асуудал. Энэ “Тавантолгой түлш” ХК-ийн үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний асуудал, агаарын бохирдлын асуудал ярих ёстой байсан чинь нийслэлийн Засаг дарга, Шадар сайд 2 гадаадад явж байгаа юм байна. Тийм учраас энийг хойшлуулаад, ирэх 7 хоногт ярихаар тохирч байна.

Тийм учраас өнөөдрийн хуралдааны ажиллагаа дууслаа. Бас яамныхандаа баярлалаа гэж хэлье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

15.50 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ